



БОРООГОУЛД ХХК

БОРООГОУЛД ХХК



УЛААНБУЛАГИЙН АЛТНЫ ҮНДСЭН ОРДЫН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

(Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дугаар: MV-0015285)

(Аж ахуйн нэгжийн регистрийн дугаар: 2094533)

Хянасан:

.....

БОУАӨЯ ХБОБХГ-ын УУНБТ
хариуцсан ахлах шинжээч
/Ц.Жаргалнэмэх/

Биелэлтийг тайлагнасан:

.....

Бороогоулд ХХК-ийн Гүйцэтгэх
Захирал /Д.Цэрэнбадам/

.....

Бороогоулд ХХК-ийн БО-ны
Менежер /Б.Лхамсүрэн/

Улаанбаатар хот

2025 он

Агуулга

Агуулга	2
Зургийн жагсаалт	4
Хүснэгтийн жагсаалт	8
Хавсралтын жагсаалт	9
1.Төслийн товч танилцуулга	11
1.1. Төслийн хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллагын мэдээлэл	12
1.2. Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг	12
1.3. Төсөл хэрэгжих орчны дэд бүтцийн хөгжлийн байдал	12
1.4. Төсөл хэрэгжих хугацаа	12
1.5. Төслийн хүчин чадал, товч тодорхойлолт	12
1.6. Төслийн техник тоног төхөөрөмж	13
2.Тухайн оны уулын ажлын гүйцэтгэл	13
3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	15
4. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт	31
4.1. Ил талбайн мөчрийн болон үрийн тарилтын бэлтгэл, тарилт, арчилгаа.....	41
4.2. Хөрс сайжруулах	45
4.1. Хүлэмж, ил талбайн суулгац бойжуулалт, усалгаа, арчилгаа.....	46
4.2. Гадаа талбайн үрийн бойжуулга.....	48
4.3. Жимсний эх цэцэрлэг бусад талбайн арчилгаа	50
4.4. Гүзээлзгэнэ тарилт, арчилгаа, хадгалалт	52
5. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	53
6. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	57
7. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	57
Түүх, соёлын үл хөдлөх болон хөдлөх дурсгалын талаар баримтлах дотоод журмыг Түүх, археологийн хүрээлэнтэй хамтран боловсруулах, хянан сайжруулах, журмын хэрэгжилтийг хангаж ажиллах:	58
Үндсэн болон гэрээт ажилчдад Түүх, соёлын дурсгалын талаар танилцуулах:	58
8. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	59
8.1. Хатуу хог хаягдал, шатах тослох материалаар дамжин хөрсөн бүрхэвч бохирдохоос сэргийлэх арга хэмжээ	60
8.2. Байгалийн гамшигт үзэгдлүүд, Газар хөдлөлт, усны үер зэрэг байгалийн гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх.....	63
8.3. Галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ	66
8.4. Зөөврийн гэрэлтүүлгийн угсралт монтажийг шаардагдах стандартын дагуу хийх .	68
8.5. Эрүүл мэнд, эмнэлгийн анхны тусламж	69
8.6. Тэсрэх материалын ашиглалт	70

8.7. Автомашин, тээврийн хэрэгслийн осол гарахаас сэргийлэх арга хэмжээ.....	71
9. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	77
9.1. Хог хаягдал дахин ашиглах ажлын хүрээнд хийгдсэн ажлууд	80
9.1.1 Хуванцрын хаягдлыг дахин боловсруулж хийсэн сандал (RECYCLE)	80
9.1.2 Хаягдал ургамлын тосоор гарын саван хийдэг болов (RECYCLE).....	82
9.1.3 Хоол хүнсний хаягдлыг ашиглан компост бордоо үйлдвэрлэх төсөл.....	88
9.1.4 Чийгийн улаан өтөөр компост бордоо хийх	91
10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	91
10.1. Гадаргын болон гүний усны хяналт шинжилгээ	93
10.2. Хөрсний хяналт шинжилгээ	101
10.3. Агаарын хяналт шинжилгээ	106
10.4. Агаарын тоосонцор	110
10.5. Дуу шуугианы хэмжилт.....	115
10.6. Ажлын байрны эрүүл ахуйн үзүүлэлт	117
10.7. Ургамалан нөмрөгт судалгаа хийж ургамлын зүйлийн бүрдлийг тодорхойлж, биомассын хэмжилт хийх.....	117
10.8. Амьтны аймгийн судалгаа.....	122
11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	123
11.1. Хөндлөнгийн хяналт шинжилгээ хийлгэх	129
11.2. Уурхайн ажилтнуудыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангах .	130
11.3. Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамруулах	130
11.4. Байгаль орчны Аудитыг мэргэжлийн байгууллагаар хийлгэх:	130
12.Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт	131
12.1. Төв аймгийн Борнуур, Сэлэнгэ аймгийн Мандал сумын иргэдийн төлөөлөлд Төслийн үйл ажиллагаа, тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийг танилцуулах	131
12.2. БОМТ-нд тусгагдасны дагуу орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, дээжлэлт, шинжилгээ, хэмжилтийн ажилд орчны бүсийн иргэдийг оролцуулах, үр дүнг танилцуулах:.....	139
13. Дүгнэлт.....	141

Зургийн жагсаалт

Зураг 1. Төслийн талбайн байршил	11
Зураг 2. Уулын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан уурхайн төлөвлөлтийн зураг	14
Зураг 3. Шимт хөрсний овоолгын зураг	32
Зураг 4. Шимт хөрсний овоолгын байршил.....	32
Зураг 5. Шимт хөрс хуулалт хийгдсэн талбай.....	34
Зураг 6. Улаанбулаг уурхайн зам дагуу хаврын мод тарилт.....	35
Зураг 7. Улаанбулаг уурхайн зам дагуу ажилтнуудын мод тарилт /Хаврын тарилт/	36
Зураг 8. Улаанбулаг уурхайн зам дагуу тарьсан модны агаарын зураг /Хаврын тарилт/	36
Зураг 9. Хамар замын талбайн тарилтын үеийн зураг /Хаврын тарилт/	36
Зураг 10. Хамар замын талбайн тарилтын дараах зураг /Хаврын тарилт/	37
Зураг 11. Хамар замын тарилтын дараах агаарын зураг /Хаврын тарилт/	37
Зураг 12. Улаанбулаг мод үржүүлгийн газраас суулгац суллан шилжүүлэх явц	38
Зураг 13. Уурхайн зам дагуух мод тарилтын бэлтгэл ажил	38
Зураг 14. Уурхай доторх мод тарилтын үйл явц /Намрын тарилт/	39
Зураг 15. Хэлтэс нэгжүүдийн мод тарилтын үйл явц /Намрын тарилт/	39
Зураг 16. Уурхай доторх мод тарилтын агаарын зураг /Намрын тарилт/	40
Зураг 17. Хамар замын талбайн тарилтын зураг /Намрын тарилт/	40
Зураг 18. Хамар замын талбайн тарилтын агаарын зураг /Намрын тарилт/.....	40
Зураг 19. Бороо дүрс үсэг ургалтын байдал / 3 дахь жилдээ/.....	41
Зураг 20. Бургас болон улиасны мөчир харандаалж бэлдэв.....	42
Зураг 21. Мөчрийн болон үрийн тарилтын үйл явц	42
Зураг 22. Мөчрийн болон үрийн тарилтын усалгааны систем угсралт.....	43
Зураг 23. Мөчрийн талбайн зэрлэг зулгаах, агротехникийн ажлын зураг	43
Зураг 24. Мөчрийн талбай / Улиас/	44
Зураг 25. Мөчрийн талбайн бойжилт /1 настай Улиас/	44
Зураг 26. Мөчрийн талбайн бойжилт /2 настай Улиас/	45
Зураг 27. Зоорийн байгууламж.....	45
Зураг 28. Хөрс сайжруулах өнжмөл бууцыг нөөцлөн шигших, холимогт бэлтгэх	46
Зураг 29. Үрийн далан болон хөрс сайжруулалтад ашиглахаар элс, бууц, шимт хөрс буулгав.....	46
Зураг 30. Хүлэмжний усалгаа	47
Зураг 31. Нарсны суулгацыг дулаалгын үртсээс салгаж, хүлэмжид шилжүүлэв	47
Зураг 32. Хүлэмжний тарьц арчилгаа	47
Зураг 33. Хүлэмжний суулгацын бойжилт.....	48
Зураг 34. Үрийн бойжуулгийн талбайн тарилтын явц.....	48
Зураг 35. Үрийн бойжуулгийн талбайн ургалтын байдал	49

Зураг 36. Үрээр тарьсан агч модны бойжилт /3 настай/	49
Зураг 37. Үрээр тарьсан шар хуайсны бойжилт анхны жилдээ	49
Зураг 38. Үрээр тарьсан далан хальсийн бойжилт анхны жилдээ.....	50
Зураг 39. Үрээр тарьсан Далан хальс болон Голт борын бойжилт эхний жилдээ	50
Зураг 40. Жимсний эх цэцэрлэг	51
Зураг 41. Жимсний модны нөхөн тарилт.....	51
Зураг 42. Ил талбайн зэрлэг хог ургамал устгал	52
Зураг 43. Хүлэмжний доод тавцангийн гүзээлзгэнэ.....	53
Зураг 44. Борнуур сумын Ужгийн ам 10 га талбай.....	54
Зураг 45. Ойжуулах талбайн бэлтгэл.....	55
Зураг 46. Тарилтад ашигласан нарс модны тарьц	56
Зураг 47. Тарилтын үеийн зураг	56
Зураг 48. Тарилтын дараах зураг	57
Зураг 49. Гүйцэтгэх захирлын тушаал.....	61
Зураг 50. Аюултай хог хаягдал хариуцсан ажилтныг томилох тушаал	62
Зураг 51. Шатах тослох материалаар бохирдсон хаягдлын сав.....	63
Зураг 52. Асгаралтын үед хэрэглэх шингээгч материалуудын иж бүрдэл	63
Зураг 53. Цаг агаарын урьдчилсан анхааруулах мэдээ	64
Зураг 54. Үерийн усны хамгаалалтын суваг шуудуу татсан байдал.....	65
Зураг 55. Аянга зайлуулагч.....	66
Зураг 56. Улаанбулагийн уурхайн аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө	66
Зураг 57. Галын хор байрлуулсан зураг.....	67
Зураг 58. Галын хорны хуваарьт үзлэг хийж буй байдал.....	67
Зураг 59. Гал унтраах сургалт, дадлага	68
Зураг 60. Зөөврийн гэрлийн угсралт монтаж	69
Зураг 61. Анхны тусламжийн хайрцаг, хэрэгслүүд	69
Зураг 62. Шинэ ажилтны ХАБЭА сургалтын бүртгэл.....	70
Зураг 63. Тэсэлгээний мэдэгдэл.....	71
Зураг 64. Аюулгүй жолоодлого хийх сэрэмжлүүлэг мэдээ	72
Зураг 65. Тээврийн хэрэгслийн хурд шалгасан тэмдэглэл.....	72
Зураг 66. Аюулгүй жолоодлого хийх аюулгүй ажиллагааны хурал.....	73
Зураг 67. Уурхайн дотоод зам дагуу байрлуулсан замын тэмдэг, тэмдэглэгээ	74
Зураг 68. Хүдэр тээврийн зам дагуу байрлуулсан замын тэмдэг, тэмдэглэгээ.....	74
Зураг 69. Хүдэр тээврийн зам дагуу байрлуулсан хяналтын камер	75
Зураг 70. Замын тэмдэг тэмдэглэгээ, зогсоох саад.....	75
Зураг 71. Уурхайд хөнгөн тэрэг барих эрх олгох сургалт, ур чадварын үнэлгээний бүртгэл	76

Зураг 72. Тээврийн хэрэгслийн үзлэгийн хуудас шалгасан тэмдэглэл.....	76
Зураг 73. Улаанбулагийн уурхайн нарядны өрөөн дэх ангилах сав	81
Зураг 74. Бутлан, пресслэн хадгалж буй хуванцар	81
Зураг 75. Хуванцраар дахин боловсруулж хийсэн сандал.....	82
Зураг 76. Уурхайн гал тогооноос гарч буй хаягдал тосыг цуглуулсан байдал	83
Зураг 77. Гарган авсан эко гарын саван.....	84
Зураг 78. Хаягдал модоор хийсэн сандал болон ажилчдын хуучин хувцсаар сандлын дэр хийсэн байдал	85
Зураг 79. Хаягдал төмөр торхоор хийсэн сандал ширээ.....	85
Зураг 80. Хаягдал мод ашиглан модон бортого хийсэн байдал	85
Зураг 81. Төв замын хөмсөг дагуух гэрэл ойлгогч тэмдэгүүд.....	86
Зураг 82. Хаягдал агаар шүүгч, төмрийн хаягдлаар хийсэн цэцгийн сав	86
Зураг 83. Хаягдал төмөр торхоор хийсэн борооны ус цуглуулагч танк.....	87
Зураг 84. Хаягдал төмрөөр хийсэн шорлогны зуух	87
Зураг 85. Замын гэрээл ойлгогч тэмдэг	87
Зураг 86. Бордоо боловсруулах сав.....	88
Зураг 87. Бордооны шинжилгээний хариу.....	89
Зураг 88. Хүнсний хаягдлыг хатааж байна	90
Зураг 89. Бордоо хутгалт, хэмжилт	90
Зураг 90. Эцсийн бүтээгдэхүүн бордоо бэлэн болов.....	90
Зураг 91. Чийгийн улаанаар компост бордоо гаргах	91
Зураг 92. Улаанбулаг төслийн гадаргын усны хяналт шинжилгээний цэгүүд	94
Зураг 93. Туршилтад ашигласан байгалийн цеолит.....	97
Зураг 94. Лабораторийн түвшний туршилтын явц.....	98
Зураг 95. Талбайн түвшинд тохируулан хийсэн цеолиттой шүүлтүүр	98
Зураг 96. Улаанбулаг уурхайн улны усыг цуглуулах сан болон цеолиттой шүүлтүүр ...	99
Зураг 97. Гадаргын усны хээрийн хэмжилт, усны дээжлэлт	100
Зураг 98. Улаанбулаг төслийн хөрсний чанарын хяналт шинжилгээний цэгүүд.....	102
Зураг 99. Хөрсний чанарын хяналт шинжилгээний дээжлэлт	103
Зураг 100. Улаанбулагийн төслийн агаарын чанарын хяналт шинжилгээний цэгүүд..	107
Зураг 101. Агаарын хийн болон тоосонцрын хэмжилтүүд.....	108
Зураг 102. Хүдэр тээврийн замын агаарын тоосны хэмжилт	110
Зураг 103. 2025 оны 1-10 сарын агаарын тоосны хэмжилтийн үр дүн	113
Зураг 104. 2025 оны 1-10-р сарын агаарын тоосны хэмжилт	114
Зураг 105. Төслийн талбай орчмын агаарын тоосны тархалт	115
Зураг 106. 2025 оны 1-10 сарын дуу шуугианы хэмжилтийн үр дүн	116
Зураг 107. Дуу шуугианы болон агаарын хэмийн хэмжилт хийж буй байдал	117

Зураг 108. Ургамлын бичиглэлийн цэгүүд.....	118
Зураг 109. Сэргээх сургалтын үеийн зураг.....	128
Зураг 110. Сэргээх сургалтын кейс даалгавар	128
Зураг 111. Хөндлөнгийн хяналтын дээжлэлт, чанарын хэмжилт	130
Зураг 112. Байгаль орчны аудитын нээлтийн хурлын зураг	131
Зураг 113. Борнуур сумын иргэдэд БОМТ-ний биелэлтийн явцыг танилцуулав	132
Зураг 114. Нөхөн сэргээлтийн талбайтай танилцуулж буй үе	133
Зураг 115. Мод үржүүлгийн газрыг танилцуулах явцад	134
Зураг 116. Нээлттэй бороо өдөрлөг борнуур сум	135
Зураг 117. Байгаль орчны хэсэг.....	135
Зураг 118. Хүүхдүүдэд зориулсан танилцуулга, асуулт хариултын тэмцээн	136
Зураг 119. Мод тарих өдөрлөг	137
Зураг 120. Байгаль орчны мэдээлэлтэй танилцаж буй зочид.....	138
Зураг 121. Үзүүлэн болон гарын бэлэг	138
Зураг 122. Мод тарих Challenge	139
Зураг 123. МУ-ын Ерөнхий сайд, АҮЭБЯ-ны сайдад Бороогоулд ХХК-ийн мэдээллийг танилцуулав	139
Зураг 124. Иргэдтэй хамтарч хэмжилт, дээжлэлт хийж буй байдал.....	140

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. 2025 онд Улаанбулагийн уурхайд ашиглаж буй тоног төхөөрөмжийн жагсаалт	13
Хүснэгт 2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт	15
Хүснэгт 3. Эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, гүйцэтгэл	59
Хүснэгт 4. Хог хаягдлын ангилал, тэдгээрийн устгал	77
Хүснэгт 5. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	78
Хүснэгт 6. Хог хаягдлын тоо хэмжээ 2025.....	80
Хүснэгт 7. Орчны хяналт шинжилгээ гүйцэтгэсэн цэгүүд болон үзүүлэлтүүд	92
Хүснэгт 8. Усны шинжилгээний дээж авсан цэгийн тодорхойлолт	93
Хүснэгт 9. Гүний худгийн усны макро болон микрохимийн шинжилгээний дүн, чанарын үзүүлэлт	96
Хүснэгт 10. Гадаргын усны цэгт хийгдсэн лабораторийн макро болон микрохимийн шинжилгээний дүн, чанарын үзүүлэлт	100
Хүснэгт 11. Хөрсний чанарын хяналт шинжилгээний цэгүүдийн тодорхойлолт	102
Хүснэгт 12. Хөрсөнд агуулагдах Хромын лабораторийн шинжилгээний дүн	103
Хүснэгт 13. Хөрсөнд агуулагдах Зэсийн лабораторийн шинжилгээний дүн.....	104
Хүснэгт 14. Хөрсөнд агуулагдах хар тугалгын лабораторийн шинжилгээний дүн	104
Хүснэгт 15. Хөрсөнд агуулагдах Кадмийн лабораторийн шинжилгээний дүн	104
Хүснэгт 16. Хөрсөнд агуулагдах Цианидын лабораторийн шинжилгээний дүн	104
Хүснэгт 17. Шимт хөрсний агрохимийн үзүүлэлтүүдийн шинжилгээний дундаж дүн... ..	105
Хүснэгт 18. Шимт хөрсний давсжилт болон хуурай үлдэгдлийн лабораторийн шинжилгээний дундаж дүн.....	105
Хүснэгт 19. Агаарын чанарын хяналт шинжилгээний цэгийн тодорхойлолт	107
Хүснэгт 20. Хүхэрлэг хийн агууламжид хийгдсэн хээрийн хэмжилтийн дүн (SO ₂)	108
Хүснэгт 21. Азотын давхар ислийн агууламжид хийгдсэн хээрийн хэмжилтийн дүн (NO ₂)	109
Хүснэгт 22. Нүүрстөрөгчийн хийн агууламжид хийгдсэн хээрийн хэмжилтийн дүн, бохирдлын түвшин (CO).....	109
Хүснэгт 23. Циант устөрөгчийн хийн агууламжид хийгдсэн хээрийн хэмжилтийн дүн, бохирдлын түвшин (HCN)	110
Хүснэгт 24. Ургамал зүйн бичиглэл	119
Хүснэгт 25. Тогтолцооны түвшний журам, зааврууд	126
Хүснэгт 26. Байгаль орчны сургалтад хамрагдсан ажилчдын мэдээлэл.....	129

Хавсралтын жагсаалт


Хавсралт 1. Агаарын чанарын хэмжилтийн багажны баталгаажуулалтын гэрчилгээ .	144
Хавсралт 2. Уурхайн талбайн тээврийн хэрэгслийн аюулгүй байдал ба замын хөдөлгөөний дүрэм.....	148
Хавсралт 3. Дуу чимээний хэмжилтийн үр дүн	149
Хавсралт 4. Асгаралтын багц болон асгаралтыг тосох сав ашиглах заавар зааварчилгааны сургалтын бүртгэл	151
Хавсралт 5. Асгаралтаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, цэвэрлэх, тайлагнах ажиллагааны журам	155
Хавсралт 6. Ус ашиглуулах дүгнэлт, зөвшөөрөл, гэрээ, төлбөрийн баримт	156
Хавсралт 7. Гүний худгийн усанд хийсэн бактериологийн шинжилгээний үр дүн.....	161
Хавсралт 8. Нийт ажилтнуудад зохион байгуулсан мөстөл, мөсөн голыг хамгаалах сургалтын бүртгэл	162
Хавсралт 9. Газар хөндөх зөвшөөрлийн маягт	164
Хавсралт 10. Үржил шимт хөрс хуулалт ба хадгалалтын журам	166
Хавсралт 11. Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах журам	167
Хавсралт 12. Энгийн хог хаягдлыг шилжүүлэх гэрээ.....	168
Хавсралт 13. Хог хаягдлын цэгт ариутгал хийсэн бүртгэл	169
Хавсралт 14. Ан амьтны бүртгэлийн хуудас	170
Хавсралт 15. Мал, ан амьтныг хамгаалах журам	171
Хавсралт 16. Үржил шимт хөрс хуулалтын журам танилцуулсан сургалтын бүртгэл .	172
Хавсралт 17. Сонор Жигүүр Хайрхайн ХХК-тай байгуулсан гэрээ	175
Хавсралт 18. Түүх соёлын үл хөдлөх болон хөдлөх дурсгалыг хамгаалах журам	176
Хавсралт 19. Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө	177
Хавсралт 20. Хаягдал тос шилжүүлэх гэрээ	178
Хавсралт 21. Уурхайн байгууламж, хог хаягдлын цэгт ариутгал, халдваргүйжүүлэлт хийсэн акт	179
Хавсралт 22. Хог хаягдлын цэгт АБҮ хийсэн тайлан	180
Хавсралт 23. Усны хяналт шинжилгээний лабораторийн үр дүн.....	181
Хавсралт 24. Улаанбулаг уурхайн усны шинжилгээний үр дүн	188
Хавсралт 25. Хөрсний хариу.....	190
Хавсралт 26. Хөрсний агрохими шинжилгээний үр дүн.....	193
Хавсралт 27. “Draeger Ham 5000” багажийн хэмжилтийн үр дүн	194
Хавсралт 28. Ажлын байрны эрүүл ахуйн үзүүлэлт	201
Хавсралт 29. ISO стандартын гэрчилгээ.....	202
Хавсралт 30. 2025 оны Байгаль орчны талаар баримтлах бодлого.....	203
Хавсралт 31. 2025 оны батлагдсан зорилго зорилт	204
Хавсралт 32. ГЗ-ийн БО-ны баримт бичиг баталсан тушаал.....	205

Хавсралт 33. Сэргээх сургалтийн бүртгэл мэдээлэл.....	206
Хавсралт 34. Хөндлөнгийн дээжлэлтийн үр дүн.....	210
Хавсралт 35. Ажлын хувцас, хувийн хамгаалах хэрэгслийн журам.....	214
Хавсралт 36. БО-ны аудит гүйцэтгэгч Тод Марк ХХК-тай хийсэн ажлын гэрээ.....	215
Хавсралт 37. ОХШХ-г хамтран гүйцэтгэсэн, БОМТ-ны биелэлттэй танилцсан иргэдийн бүртгэл.....	216
Хавсралт 38. Цэвэршүүлэх туршилтийн үр дүн.....	217

1. Төслийн товч танилцуулга

Улаанбулагийн алтны үндсэн орд нь Төв аймгийн Борнуур, Сэлэнгэ аймгийн Мандал сумдын нутаг дэвсгэрийн хил залгаа хэсэгт, Улаанбаатар хотоос баруун хойш 130-140 км, Мандал сумаас баруун урагш 23 км, Борнуур сумаас хойш 24 км, Улаанбаатар-Алтанбулагийг холбосон төв замаас холгүй зайд дэд бүтэц сайн хөгжсөн бүсэд оршдог. Улаанбулаг төслийн ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нь “Өнжин Уул” нэртэй MV-015285 тоот бүртгэлийн дугаартай 1:50000 масштабтай байр зүйн зургийн М-48-117-Г хавтгайд, 1204.47 га талбайг хамран байрлана.

“Бороогоулд” ХХК нь Улаанбулагийн алтны үндсэн ордыг ашиглах төслийн Техник эдийн засгийн үндэслэлийн нэмэлт тодотголыг 2022 оны 7 дугаар сарын 1-д батлуулсан. 2023 онд “Баялаг-Эко” ХХК нь тус төслийн байгаль орчны суурь төлөв байдал, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННУ)-г боловсруулсан. Улаанбулаг төслийн 2025 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-г Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яам (БОУАӨЯ)-аар батлуулан хэрэгжүүлж ажиллалаа.



Зураг 1. Төслийн талбайн байршил

1.1. Төслийн хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллагын мэдээлэл

Аж ахуйн нэгжийн нэр:	Бороогоулд ХХК
Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн дугаар:	9019011029
Регистрийн дугаар:	2094533
Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл:	Алтны эрэл хайгуул, олборлолт, боловсруулалт, алтны тоног төхөөрөмж, сэлбэг үйлдвэрлэх, алт баяжуулах үйлдвэр

1.2. Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг

Бороогоулд ХХК-ийн төв оффисын хаяг:	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 1-р хороо, Энх тайвны гудамж 17, Блюскай цамхаг 7-р давхарт байрладаг. Утас: 11-317798, факс: 316100
Захирлын нэр, утас, цахим шуудангийн хаяг:	Д.Цэрэнбадам, 99117215, Tserenbadam.Duger@boroogold.mn
Холбогдох мэргэжилтний нэр, утас, цахим шуудангийн хаяг:	Б.Лхамсүрэн, 99113852, Lkhamsuren.Baasandolgor@boroogold.mn , Ө.Бямбасүрэн, 99336618, Byambasuren.Unurtushig@boroogold.mn

1.3. Төсөл хэрэгжих орчны дэд бүтцийн хөгжлийн байдал

Уурхайн ойр орчны дэд бүтэц нь уурхайн хашаа болон уурхайн дотоод замуудаас бүрдэнэ.

Улаанбулаг алтны уурхай нь хүдрийн ил уурхай, засварын зөөврийн контейнер, хамгаалалтын пост, ажилчдын наряд заавар өгөх зөөврийн байр, авто пүү, шимт хөрсний овоолгууд гэсэн дэд бүтцээс бүрдэнэ.

1.4. Төсөл хэрэгжих хугацаа**Улаанбулагийн алтны үндсэн ордын олборлолт, боловсруулалт:**

Улаанбулагийн уурхайгаас олборлосон хүдрийг Бороогийн алт боловсруулах үйлдвэр болон нуруулдан уусгалтын талбайд тээвэрлэн хүргэж, уусгалтынаргаар боловсруулж эцсийн бүтээгдэхүүнийг гарган авна.

1.5. Төслийн хүчин чадал, товч тодорхойлолт**Улаанбулагийн алтны үндсэн ордын уулын ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл:**

Улаанбулаг үндсэн ордын 2022 онд тодотгол хийсэн техник эдийн засгийн үндэслэлд тулгуурлан 2025 онд уулын ажлыг гүйцэтгэж байна. Одоогийн байдлаар уурхайн гурав дугаар үе шатны олборлолтын ажил үргэлжилж байна.

1.6. Төслийн техник тоног төхөөрөмж

2025 онд Улаанбулагийн үндсэн ордын төслийн талбайд дараах техник, тоног төхөөрөмжийг ажиллуулсан. Үүнээс гадна тоосжилтыг бууруулах зорилгоор усны машин, түлшний хангамжид зориулсан түлшний тэрэг, мөн бусад үйлчилгээний зориулалттай хөнгөн тэргүүд ажиллаж байна.


Хүснэгт 1. 2025 онд Улаанбулагийн уурхайд ашиглаж буй тоног төхөөрөмжийн жагсаалт

Д/д	Тоног төхөөрөмж	Зориулалт	Марк	Тоо, ш
1	Утгуурт ачигч	Хүдрийн түр овоолго	CAT 988H	1
2	Экскаватор	Олборлолт	CAT-390F	2
3	Зам услах машин	Зам талбай услах тоос дарах ажилд	WATER TRK	2
4	Түлш цэнэглэгч машин	Тоног төхөөрөмжүүдийг түлшээр хангах	FUEL TRK	1
5	Автогрейдер	Зам талбай засах	CAT 14H	1
6	Замын индүү	Зам талбай засах	CAT CS563	1
7	Бульдозер	Хөрсний овоолго	CAT-D9R	1

2. Тухайн оны уулын ажлын гүйцэтгэл

Улаанбулаг төслийн уурхайн олборлолтын үйл ажиллагаа 2025 оны 1-5-р сар хүртэл явагдаж, бусад хугацаанд Бороо уурхайн хаягдлын далангийн байгууламжийн өргөтгөлийн ажил болон бусад ажлын улмаас 10 сар хүртэл түр зогссон ба олборлолт, ачилтад CAT-390 экскаваторууд, тээвэрлэлтэд HOWO-400, CAT-773R маркийн өөрөө буулгагч техникүүдийг ашиглаж байна.

2025 онд уулын ажлын төлөвлөгөөний дагуу 3,827 мян.тн хөрс хуулж, 33.8 мян.тн хүдэр олборлосон байна.



Зураг 2. Уулын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан уурхайн төлөвлөлтийн зураг

3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт


Улаанбулаг төслийн үйл ажиллагааны хүрээнд тухайн жилийн БОМТ-нд тусгагдсаны дагуу сөрөг нөлөөллийг бууруулах 4 чиглэлээр 28 ажил төлөвлөн, хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан бөгөөд гүйцэтгэлийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр нь дараах хүснэгтэд нэгтгэн орууллаа.

Хүснэгт 2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулахаар авагдсан арга хэмжээ
Агаарын чанар			
1	Тоосжилт үүсч болох эх үүсвэрүүд: Уурхайн олборлолтын үеийн хөрс хуулалт, олборлолт, овоолго зэрэг газар шорооны ажил, болон хүнд машин механизмын хөдөлгөөн ;	Тогтмол хугацаанд агаарын хяналт шинжилгээ хийх	<p>Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсаны дагуу үйл ажиллагаанаас үүсэх сөрөг нөлөөллийг нийт 6 цэгт 7 хоногийн давтамжтай 44 удаагийн хэмжилтээр агаар дахь хүхэрлэг хий (SO_2), азотын давхар исэл (NO_2), метаны хий (CH_4), нүүрстөрөгчийн хий (CO), циант устөрөгчийн хий (HCN), аммиак (NH_3), хүчилтөрөгч (O_2) зэрэг 7 төрлийн элементийг хэмжин тодорхойлох замаар агаарын чанарын хяналт шинжилгээг хийж гүйцэтгэсэн.</p> <p>Төслийн үйл ажиллагаанаас агаарт үүсэх $PM_{2.5}$, PM_{10}, TSP тоосонцорын хэмжилтийг уурхайн талбайд 6 цэгт, тээврийн зам дагуу 14 цэгт 7 хоногийн давтамжтай Dusttrak 8533 DRX багажаар 44 удаа хийж гүйцэтгэсэн байна.</p> <p>Хавсралт 1-ээс агаарын хэмжилтийн багажийн баталгаажуулалтын гэрчилгээнүүдийн хуулбарыг харна уу.</p> <p>Хяналт шинжилгээний дэлгэрэнгүй мэдээллийг орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт хэсгээс үзнэ үү.</p>
2		Тоосжилтыг бууруулах – Хурдны хязгаарыг мөрдүүлэх, хурдны хязгаарын тэмдэг тэмдэглэгээ байрлуулах, засаж сайжруулах	Төсөл хэрэгжүүлэгч Бороогоулд ХХК-ийн дотоод үйл ажиллагааны журмын дагуу замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж ажиллахын тулд уурхайн замд үзлэг шалгалтыг тогтмол гүйцэтгэдэг. Мөн байгаль цаг уурын нөхцөл байдлаас үүдэн аюулгүй жолоодлогын анхааруулга санамжийг тухай бүрд нь нийтэд мэдээлж арга хэмжээ авдаг. Хүдэр тээврийн зам дагуу болон уурхайн дотоод зам дагуу байрлуулсан хурдны хязгаарын тэмдэг тэмдэглэгээний бүрэн бүтэн байдлыг тогтмол хянаж, зам дагуу хурд сааруулагчуудыг тогтмол засаж сайжруулж ажиллаж байна. Мөн тээврийн замаар зорчих өөрөө буулгагч HOWO техникүүдэд хар хайрцаг суулгах, засмал замтай нийлэх уулзварт 180 градус хянах боломжтой камер, тээврийн замыг хянах 2 ш камер суурилуулан осол эрсдэл, хурдны хязгаарын хэрэгжилт, тоосжилтыг тогтмол хянаж, эрсдэлээс урьдчилан сэргийлэн ажиллаж байна. Уурхайн талбайд тээврийн хэрэгслүүдийн хурдны шалгалт хэмжилтийг 7 хоног бүр төлөвлөгөөний дагуу Хамгаалалтын хэлтэс болон Аюулгүй ажиллагааны хэлтсээс хийж гүйцэтгэдэг. Хавсралт 2 -оос “Тээврийн хэрэгслийн аюулгүй байдал ба замын хөдөлгөөний дүрэм”-ийг үзнэ үү.


3		<p>Замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор - Тоног төхөөрөмж ажиллаж буй зам талбайг тоосжилт ихтэй, хуурайшилттай үед тогтмол услах, замын засвар арчилгаа хийх.</p>	<p>Төслийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй техникийн хөдөлгөөнөөс үүсэх тоосжилтыг дарах, бууруулах зорилгоор тоосжилт ихээр үүсэж буй ажлын талбар, тээврийн болон технологийн замын усалгааг 14 тн багтаамжтай 1ш, 25тн багтаамжтай 2 машин тоосжилт ихтэй үеүдэд тогтмол хийж гүйцэтгэж байна. Мөн замыг сайжруулах засвар үйлчилгээг тогтмол хийж гүйцэтгэдэг.</p>

			
4		<p>Төслийн талбайн хэмжээнд олон салаа зам гаргахгүй, хөрсний тоос салхинд хийсэж, агаар орчинд тархахаас урьдчилан сэргийлэх;</p>	<p>БОМТ-нд тусгагдсаны дагуу төслийн талбайд үүссэн технологийн хэрэгцээнд ашиглагдаж буй сайжруулсан зам, тогтоосон хяналт, хэмжилт, мониторингийн цэгүүд рүү хүрэх замаас бусад олон салаа замыг хааж тэмдэг, тэмдэглэгээ байрлуулж уурхайн авто техникүүд тогтоосон маршрут бүхий замаар хөдөлгөөнд оролцож байна.</p>

			
<p>5</p>	<p>Төслийн үйл ажиллагаанаас хүлэмжийн хий ялгарснаар агаар мандал дахь хүлэмжийн хийн агууламжийг нэмэгдүүлэх /Дизель генератор, техник хэрэгслийн хөдөлгүүр гэх мэт/</p>	<p>Уур амьсгалд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр – Эрчим хүчийг хэмнэж үр ашигтай зарцуулах, эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан хэрэгсэл ашиглах, эрчим хүч хэмнэх үйл ажиллагаанууд хэрэгжүүлэх</p>	<p>Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилгоор эрчим хүчний хэрэглээнд хэмнэлттэй лед гэрлийг Улаанбулаг уурхайн оффисын болон бусад байгууламжийн дотор 6 ширхгийг сольж байрлуулсан. Мөн уурхайн гадна гэрэлтүүлэгт 100Вт болон 200Вт лед гэрлүүд ашигладаг болсон. Улаанбулагийн Уурхайн байгууламжуудын халаалтад эрчим хүчний хэмнэлттэй цагийн болон температурын автомат тохиргоотой Элдом брендийн халаагуур 2 ш суурилуулсан бөгөөд шаардлагатай үзлэг шалгалт, засвар, тохируулга хийх арга хэмжээг авч ажиллаж байна. Улаанбулаг уурхайн эрчим хүчний хэрэглээ бага буюу нийт хэрэглэсэн эрчим хүчний 0.34 орчим хувийг эзэлдэг.</p>  
<p>6</p>		<p>Хүлэмжийн хийг ялгаруулж буй эх үүсвэрүүдийн мэдээллийг бүртгэх, ялгарлыг тооцох</p>	<p>Бороогоулд ХХК-ийн Улаанбулаг уурхайн ашиглалт болон бусад бүтээн байгуулалтын ажлууд хийгдэж байгаатай холбоотойгоор нийт хүлэмжийн хийн ялгаралтын хэмжээ 2024 оны 6 дугаар сараас хойш 2025 оны 6 дугаар сарын байдлаар 7.9 килотонн хүрсэн. Компанийн үйл ажиллагааны хэмжээнд хүлэмжийн хийн ялгарал үүсгэгч голлох эх үүсвэр нь дизель түлш болон эрчим хүчний хэрэглээ байна.</p>

			<p>Тайлант хугацаанд Улаанбулаг уурхайн үйл ажиллагаа 2025 оны 1–5-р сард явагдсан бөгөөд хүлэмжийн хийн ялгарлын хамгийн бага үе нь 6-р сард байсан ба энэ нь Улаанбулаг төслийн үйл ажиллагаа 10 сар хүртэл түр зогсоож Бороо уурхайн болон хаягдлын далангийн барилгын ажилтай холбоотойгоор техникүүдээ татсантай холбоотой байна.</p> <p>Харин хүйтний улиралд хүлэмжийн хийн ялгарал ихсэх төлөвтэй байгаа нь техник тоног төхөөрөмжийн түлшний хэрэглээ, үйлдвэрлэлийн процесс болон дулаан хангамжийн чиглэлээр эрчим хүчний хэрэглээ нэмэгддэгтэй шууд холбоотой. Энэ нь хүйтэн агаарын аэродинамикийн эсэргүүцэл илүү их байх, замын нөхцөл байдлаас шалтгаалан дугуйны барьцалдах чадвар муудах, өвлийн түлшний энерги ялгаруулалт бага байх, гэрэлтүүлэг, халаалт гэхчилэн цахилгааны хэрэглээ нэмэгдэх байдлаар түлш зарцуулалт өндөр байдагтай холбоотой.</p> <p>Уур амьсгалд нөлөөлөх сөрөг нөлөөлөл, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилгоор түлшний хэрэглээ болон эрчим хүч хэмнэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг барилгын дулаан алдагдлыг бага байлгах, байгалийн гэрэлтүүлэг түлхүү ашиглах, олон ажиллагаат цөөн төхөөрөмжөөр дулаан, сэрүүцүүлэх, агааржуулалтыг шийдвэрлэх зэргээр төлөвлөн ажиллаж байна.</p> <div data-bbox="907 630 2094 1189"> <table border="1"> <caption>2022-2025 оны Улаанбулаг уурхайн Хүлэмжийн хийн ялгарал</caption> <thead> <tr> <th>Он</th> <th>Шууд ялгарал (тонн CO2 e)</th> <th>Шууд бус ялгарал (тонн CO2 e)</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>2022</td> <td>~6000</td> <td>~2200</td> </tr> <tr> <td>2023</td> <td>~7200</td> <td>~2800</td> </tr> <tr> <td>2024</td> <td>~8500</td> <td>~1000</td> </tr> <tr> <td>2025 оны эхний хагас</td> <td>~2800</td> <td>~1000</td> </tr> </tbody> </table> </div>	Он	Шууд ялгарал (тонн CO2 e)	Шууд бус ялгарал (тонн CO2 e)	2022	~6000	~2200	2023	~7200	~2800	2024	~8500	~1000	2025 оны эхний хагас	~2800	~1000
Он	Шууд ялгарал (тонн CO2 e)	Шууд бус ялгарал (тонн CO2 e)																
2022	~6000	~2200																
2023	~7200	~2800																
2024	~8500	~1000																
2025 оны эхний хагас	~2800	~1000																
7	Уурхайн зам талбай, хүдэр тээврийн замаас тоосжилт үүсэх	Тогтмол хугацаанд тоосжилт хэмжих	Агаарын тоосонцрыг уурхайн талбайд 6 цэгт, тээврийн замын трассын дагуу 14 цэгт 7 хоногийн давтамжтай, 44 удаа хийж гүйцэтгэн үр дүнг “MNS 4585:2025 Агаарын чанар, техникийн ерөнхий шаардлага” стандарттай харьцуулан гаргасан. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт хэсгээс дэлгэрэнгүйг үзнэ үү.															

8	Тэсэлгээ, баяжуулах үйлдвэр, техникүүдээс дуу чимээ, чичиргээ доргио үүсдэг	Дуу шуугианы хэмжилт хийх - Тэсэлгээний үйл ажиллагааг явуулахдаа өдрийн цагаар гүйцэтгэнэ.	<p>Тэсэлгээний үйл ажиллагааг явуулахдаа агаарын дэлбэрэлт, чичиргээний талаарх үндэсний болон олон улсын стандартын дагуу өдрийн цагаар хийж гүйцэтгэдэг. Тэсэлгээ болон техникүүдээс үүсэх дуу чимээг тайлант хугацаанд хүдэр тээврийн зам-1, 2, ил уурхай орчим, оффис орчмын талбай гэсэн 4 цэгт “Sound Level meter” багаж ашиглан 7 хоногийн давтамжтай 44 удаагийн хэмжилт гүйцэтгэн мэдээллийн сан үүсгэн бүртгэсэн. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт хэсгээс дэлгэрэнгүйг үзнэ үү. Хэмжилтийн үр дүн холбогдох стандартын шаардлагыг хангаж байгаа. Хавсралт 3-аас Дуу чимээний хэмжилтийн үр дүнг харна уу.</p> 
Усны нөөц чанар			
9	ШТМ хөрсөнд асгарснаар газрын доорх ус бохирдох, газар доорх устай холбогдон ургадаг ургамалжилтад сөргөөр нөлөөлж болзошгүй.	ШТМ хөрсөнд алдахаас сэргийлж шаардлагатай газруудад асгаралтын үед ашиглах шингээгч материал бүхий иж бүрдэл байршуулах	Хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй бохирдуулагч бодисыг хяналтаас гаднах талбайд санамсаргүй алдах үйл явцыг асгаралт хэмээн тодорхойлдог бөгөөд уул уурхайн төслийн хувьд шатах тослох материал алдагдах эрсдэл тодорхой хэмжээнд байдаг. Иймд аливаа асгаралт гарсан тохиолдолд асгаралтыг хязгаарлах, тархалтыг зогсоох үүднээс шингээгч материалын иж бүрдэл /Spill kit/-г тусгай саванд хийж, засварын талбай, хаягдал тос хуримтлуулах танкны орчим зэрэг шаардлагатай газруудад байршуулсан. Эдгээр асгаралтын үед хэрэглэх шингээгч материалуудын иж бүрдлийн бүрэн байдалд хяналт тавьж ажилладаг.



Мөн техникүүдэд гэнэтийн асгаралтаас урьдчилан сэргийлэх үүднээс бохирдуулагч бодисыг тосож хөрсөнд алдахгүй байх зориулалттай хэрэгслийг шаардлагатай нөхцөлд хэрэглэхээр байршуулсан байдаг, асгаралт үүсэх үед шингэнийг тосож юүүлэх зорилгоор Spill pool буюу асгаралтыг тосох савыг уурхайн бүх хүнд техникүүдэд байрлуулж асгаралт үүсэж болзошгүй газруудад тараан байршуулсан ба хэрхэн ашиглах талаар компанийн бүх ажилчидад сургалт орж байгаль орчны ноцтой зөрчлөөс сэргийлж ажилласан. Spill pool савыг хэрхэн ашиглах талаар сургалт орсон хуудсыг **хавсралт 4-өөс** харна уу.



10

Асгаралтаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, мэдээлэх журмыг боловсруулж сургалтаар танилцуулж, мөрдөх

Бороогоулд ХХК нь асгаралтын эсрэг арга хэмжээнд бэлэн байх, байгаль орчинд асгаралтаас үзүүлж болох хохирол, нөлөөллийг хязгаарлах, асгаралт гарсан тохиолдолд зохих ёсны хариу арга хэмжээ авах, хяналт зохицуулалтын шаардлага болон компанийн стандартын дагуу цэвэрлэж, тайлагнаж мэдээлэх явдлыг хангах зорилготой байгаль орчны менежментийн “Асгаралтаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, цэвэрлэх, тайлагнах журам”-ыг

мөрдөж ажилладаг. Энэхүү журам нь төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан байгаль орчинд нөлөөлж болохуйц бүх асгаралтад хамаардаг бөгөөд Улаанбулагийн төслийн үйл ажиллагаанд уг журмыг мөрдөж ажиллаж байна. Хавсралт 5-аас “Асгаралтаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, цэвэрлэх, тайлагнах” дотоод журмыг үзнэ үү.

Журмын хэрэгжилтийг хангах хүрээнд Улаанбулагийн төсөлд ажиллаж буй гэрээт болон үндсэн бүх ажилчдад төслийн талбайд ажиллаж эхлэхээс өмнө байгаль орчны ерөнхий сургалтыг тогтмол зохион байгуулсан. Байгаль орчны дотоод журмууд, байгаль орчны хэлтсийн үйл ажиллагаа, БОХ төсөл хөтөлбөрүүдийн талаар ажилчдад сургалт, мэдээлэл хийснээр журмын хэрэгжилтийг хангахаас гадна байгаль орчныг хамгаалах асуудалд хариуцлагатай ханддаг соёлыг бий болгоход чухал ач холбогдолтой байдаг. Энэхүү сургалтын хөтөлбөрт “Асгаралтаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, цэвэрлэх, тайлагнах” журам багтсан байдаг. Компанийн хэмжээнд үндсэн болон гэрээт нийт 639 ажилтанд, 126 цагийн байгаль орчны сургалтыг зохион байгуулав. Сургалтын дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү тайлангийн “Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт” бүлгээс үзнэ үү.



Ажиргай, хариуцлагатай үйл үйлдлийг төвөггүйгээр явуулах

Асгаралтын үед авах арга хэмжээ

Асгаралт гарсан үед

- Тонот төхөөрөмжийн ажиллагсааны явцад асгаралт гарсан тохиолдолд доохио арга хэмжээг авна.
- Уурхайн диспетчер, аюулгүй ажиллагааны хэлтэс болон өөрийн ахлах ажилтанд нэн дэвдүү мэдэгдэх.
- Мэдээллийг дамжуулахдаа радио станцан 1, 3-р суваг болон диспетчерийн 9904478 дугаараар холбогдоно.
- Асгаралтын мэдээлэл нь асгарсан мэлээрмэ, асгаралтын байршил, асгаралтын хэмжээ, асгаралтын байдал, үүн, байгаль орчин эсүүг эд хөрөнгөнд уржж ажил байгаа эсэх, гүний усанд ойрхон байгаа эсэх, болондуулах боломжтой эсэх зэргийг агуулсан байна.
- Тонот төхөөрөмж бүр дээр асгаралтын сав байрлах бөгөөд асгаралт гарсан дарийд хуучна агааргүй асгаралтын савыг байрлуулж тархалтыг зогсоох арга хэмжээг авна.





11	ШТМ-ыг алдагдал, асгаралтын болон химийн бодисын агууламж бүхий үерийн урсацаар гадаргын ус бохирдох	Шаардлагатай газруудад үерийн ус зайлуулах суваг, шуудуу татах, засварлах	<p>Гадаргын борооны ус ил уурхайн талбай болон бусад байгууламжууд руу орж ирэхээс сэргийлж талбайн гадна талаар ус зайлуулах суваг шуудууг хийсэн бөгөөд шаардлагатай хэсгүүдэд засаж сайжруулж ажилладаг. Тайлант жилд ил уурхайн талбайн урд хэсэг, төв замын хойд хэсэгт шуудууг дахин сэргээж засварласан.</p> 
12	Гадаргын болон газрын доорх усны хими, физик шинж чанар өөрчлөгдөх, бохирдох, голын усны нөөц хомсдох	<p>Усны чанарын хяналт шинжилгээг ОХШХ-ийн дагуу хийх</p> <p>Ус ашиглах дүгнэлт гаргуулах, гэрээ байгуулах, ус ашиглалтын төлбөрийг гэрээний дагуу</p>	<p>Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу гүний усны хяналт шинжилгээний дээжлэлтийг Бороогийн уурхайн ус хангамжийн 5 гүний худгаас, Улаанбулаг уурхайн болон Мод үржүүлгийн 2 ш худгаас, гадаргын усны хяналт шинжилгээний дээжлэлтийг Улаанбулагийн төслийн талбайн баруун талд байрлах Бороо голын 3 цэгээс, төслийн талбайн хойд талд байрлах Зуунмодны голын 1 цэгээс, мөн дээж авах боломжтой нөхцөлд ил уурхайн уланд хуримтлагдсан хур тунадас болон хананаас үүсэх уснаас дээжлэлт гүйцэтгэж, нийт 13 цэгээс 5-9 саруудад сар бүр дээж авч итгэмжлэгдсэн лаборатори болох “Геологийн төв лаборатори”-т химийн шинжилгээг, “Ханлаб” ХХК-ийн лабораторид ундны усны химийн шинжилгээ, микробиологийн шинжилгээг хийлгэсэн. Усны чанарын хяналт шинжилгээний ажлын дэлгэрэнгүй мэдээллийг орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт хэсгээс үзнэ үү.</p> <p>Улаанбулаг төслийн ус ашиглах дүгнэлтийг 2025 оны 2-р сарын 27-нд Усны газраас E-2501-000403 дугаартайгаар гаргуулж, Хараа-Ерөө голын Сав газрын захиргааны даргын А/14 тушаалаар олгосон ус ашиглах зөвшөөрлийн дагуу 2025 оны 4-р сарын 15-ны өдөр №5 тоот ус ашиглах гэрээ</p>

		<p>тооцож, тогтоосон хугацаанд төлөх</p>	<p>байгуулан, тоолуурын заалтын дагуу ус ашигласны төлбөрийг төлж ажилласан. Хавсралт 6-аас ус ашиглах дүгнэлт, зөвшөөрөл, гэрээ болон төлбөрийн баримтыг харна уу.</p>
		<p>Газрын доорх усны худаг бактериологийн шинжилгээ хийлгэх</p>	<p>Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу гүний усны хяналт шинжилгээний дээжлэлтийг Улаанбулаг уурхайн худаг болон мод үржүүлгийн 2 ш худгаас сар бүр авч бактериологийн шинжилгээг “Ханлаб” ХХК-ийн итгэмжлэгдсэн лабораторид хийлгэн гүйцэтгэлийг хангаж ажилласан. “MNS 0900:2018 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээний стандарт”-д заасан бичил амь судлалын үзүүлэлтээс хэтэрсэн үзүүлэлтгүй. Хавсралт 7 аас шинжилгээний үр дүнг харна уу.</p>
<p>13</p>	<p>Хаягдлын далангийн сангийн хамгаалалтын HDPE доторлогоо ямар нэгэн байдлаар гэмтэх, микро нүх сүв үүссэний улмаас хаягдал шингэн нэвчиж гүний ус бохирдуулах</p>	<p>Цианидын агууламжийг тогтмол хугацаанд хэмжиж байх, хаягдлын далангийн пьезометрийн цооногт тогтмол хугацаанд хэмжилт хийж байх</p>	<p>Улаанбулагийн уурхайгаас олборлосон хүдрийг Сэлэнгэ аймгийн Баянгол суманд байрлах Бороогийн алт боловсруулах үйлдвэр болон нуруулдан уусгах аргаар боловсруулдаг.</p> <p>❖ Хаягдал усны хяналт шинжилгээ: Бороогийн уурхайн боловсруулах үйлдвэрээс гарах хаягдал усыг технологийн дагуу хоргүйжүүлэх цехээр дамжуулан хаягдал хадгалах санд байршуулдаг бөгөөд хаягдал уснаас тогтмол хугацаанд хяналтын дээжлэлт хийж, Геологийн төв лабораторид шинжилгээнд явуулдаг. Шинжилгээний үр дүнг БОННУ-ээр тогтоосон хаягдлын далан дахь усны чанарт тавих хяналтын түвшинтэй харьцуулахад холбогдох шаардлагыг хангаж байна.</p> <p>❖ Хаягдлын далангийн пьезометрийн (шүүрлийн хяналт) хэмжилт: Тайлант жилд 2025 оны БОМТ-нд тусгагдсаны дагуу үндсэн сангийн 10, зүүн сангийн 16 нийт 26 цооног тус бүрийг 7 хоногийн давтамжтайгаар 2025 оны 1 дүгээр сарын 1-ээс 2025 оны 10 дугаар сарын 28 хүртэлх хугацаанд нийт 44 удаагийн хэмжилт хийж, хяналт тавин ажилласан. Хэмжилтийн дүнгээс харахад пьезометр цооногуудад нэвчилт, шүүрэлт илрээгүй.</p> <div data-bbox="1066 922 1491 1264"> </div> <div data-bbox="1503 922 1962 1264"> </div>

15	Усны нөөц хомсдох	Усны нөөц хомсдох нөлөөллийг бууруулах ажлыг гүйцэтгэх, холбогдох сургалтыг зохион байгуулах	<p>Бороогоулд ХХК нь “Дэлхийн усны өдөр”-ийг тохиолдуулан жил бүр компанийн нийт ус ашиглалт, усны нөөц, үнэ цэнэ, усны хэрэглээг хамгийн бага түвшинд байлгах, хаягдал усыг эргүүлэн ашиглах, ус хэмнэх аргууд зэрэг сэдвүүдээр сургалт, мэдээлэл хүргэж, ус хэмнэлттэй холбоотой арга хэмжээг зохион байгуулж ажилладаг. 2025 оны 3-р сарын 18-19-ний өдрүүдэд Бороо болон Улаанбулаг уурхайн 150 орчим үндсэн болон гэрээт ажилтнуудад “Мөсөн голыг хамгаалах” уриан дор ус ашиглалт, усны үнэ цэнэ, ус хэмнэлт сэдвээр сургалт зохион байгуулсан. Мөн 2025 оны 3 дугаар сарын 22-нд “Дэлхийн усны өдөр”-ийг тохиолдуулан мөстөл, мөсөн голын хамгааллын ач холбогдлын талаарх мэдээллийг бүх ажилтанд цахим шуудангаар хүргэж, уриалга, постерыг компанийн 215 ширхэг компьютерийн дэлгэц амраах тохиргоонд байршуулан сурталчилгаа явуулсан. Хавсралт 8-аас сургалтад хамрагдсан ажилчдын гарын үсэг зурсан хуудсыг харна уу. 2025 оны 3 дугаар сарын 27-нд “Мөсөн голыг хамгаалах нь-2025” сэдэвт арга хэмжээг Хараа–Ерөө голын сав газрын захиргаа, Дархан-Уул аймгийн БОГ, “Дархан ус суваг” ХХК, ДДЦС болон их, дээд сургуулиудтай хамтран зохион байгуулж, “Усан орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах дэвшилтэт технологи” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал болон ЕБС-ын сурагчдын дунд усны үнэ цэнэ, хамгааллын талаар танин мэдэхүйн сургалт, гар зургийн болон эссэ бичлэгийн уралдаан зохион байгуулж, хурлын илтгэл, материалуудыг эмхэтгэн ном хэлбэрээр хэвлүүлэх ажлыг дэмжиж, ивээн тэтгэж ажилласан.</p> <p>Бороогоулд ХХК нь ахуйн хэрэглээний усны хэрэглээг бууруулах зорилгоор ажилчдын амралтын байр, оффисын гар угаалтуурт механик ажиллагаатай ус хэмнэгч хошууг суурилуулж, ахуйн цоргоноос гарах усыг 25–30 хувиар хэмнэж байна. Мөн уурхайн бүх суултуурын татуурганд хүндрүүлэгч хийн нэг удаагийн ус таталтаар 1,5-2 литр ус хэмнэж байна.</p>
Хөрс, Ургамлан бүрхэвч			
16	Уурхайн ашиглалтын явцад хөрсний бүтэц	Төсөлд дурдсанаас өөр эрүүл газар хөндөхгүй	Улаанбулаг төслийн талбайд тайлант хугацаанд ТЭЗҮ-д болон уулын ажлын төлөвлөгөөнд нийт хөндөгдөх газруудыг тодорхойлсон бөгөөд энэхүү баримт бичгүүдэд тусгагдсаны дагуу уурхайн



	<p>найрлагад өөрчлөлт орох, хог хаягдлаас бохирдол үүсгэх, хүнд даацын машин механизмууд олон салаа зам гаргаж хөрс болон ургамлыг гэмтээх. Шатахуун асгарах зэрэг болзошгүй осол аваараас үүдэн хөрс, ургамлан бүрхэвчийг бохирдуулах, шимт хөрс салхи, усны нөлөөгөөр элэгдэхээс сэргийлэх</p>	<p>байх, Засаж сайжруулсан замаас өөр зам гаргахгүйн тулд тэмдэгжүүлэх, ухуулах самбар байршуулах ба бүрэн бүтэн байдлыг хангах. Шаардлагатай үед зогсоол, замын тэмдгийг засварлах, сэргээх.</p>	<p>үйл ажиллагаа явагдсан. Уурхайн бүх техник засаж сайжруулсан замаар зорчдог бөгөөд хяналт шалгалт, мониторингийн цэгүүд рүү очихоос бусад шороон замуудыг хааж тэмдэгжүүлсэн.</p> 
<p>17</p>		<p>Хяналтгүйгээр газар хөндөхөөс сэргийлж аливаа газар хөндөх үйл ажиллагааг эхлүүлэхийн өмнө Газар хөндөх зөвшөөрөл авах, олгох</p>	<p>Шинээр газар хөндөх ажил хийгдэхээс өмнө тухайн үйл ажиллагааны мэдээлэл болон батлагдсан төлөвлөлтийн зурагт тусгагдсаны дагуу үйл ажиллагаа явагдаж байгаа эсэхийг хянах зорилгоор газар ухах, хөндөх зөвшөөрөл авч ажилладаг байх асуудлыг “ Газар хөндөх, ухах зөвшөөрөл”, “Үржил шимт хөрс хуулалт, хадгалалт” журмаар зохицуулдаг. Энэ журмын дагуу шаардлагатай баримт бичиг бүрдүүлэн холбогдох бусад хэлтсүүд болон байгаль орчны хэлтсээр хянуулж газар ухах/хөндөх/ зөвшөөрлийг авч ажиллаж байна. Газар хөндөх зөвшөөрлийн бичгийн батлагдсан маягыг Хавсралт 9-өөс харна уу</p>
<p>18</p>		<p>Шинээр хөндөгдөх талбайн шимт хөрс хуулах, хадгалалтыг стандартын дагуу хийх. Шимт хөрсний хуулалт, хадгалалтын талаар мэдлэг олгох сургалтыг зохион байгуулах Шимт хөрс хуулах талбайн ургамлан бүрхэвчийн мэдээллийг цуглуулах</p>	<p>Уулын ажлын төлөвлөгөөний дагуу шимт хөрсний овоолгын байршлыг төлөвлөсөн бөгөөд үйл ажиллагаа явагдах талбайн шимт хөрсийг хуулж, хадгалахтай холбоотой МУ-ын холбогдох хууль, журам стандартын шаардлагыг хангаж ажилласан. Улаанбулагийн төслийн талбайд мөрдөх “Үржил шимт хөрс хуулалт, хадгалалт”-ын журмыг боловсруулан шинэчлэн баталж ажиллаж байна. 2025 оны 04 болон 10 дугаар сард “Үржил шимт хөрсний хуулалт, хадгалалт” дотоод журам танилцуулах сургалтыг Ил уурхайн газар болон Инженер, төлөвлөлтийн албаны ажилтнууд, хүнд хөдөлгөөнт тоног төхөөрөмжийн операторуудад зохион байгуулж, 55 ажилтныг нийт 80 минутын сургалтад хамруулсан. Ургамлан бүрхэвчийн мэдээллийг ОХШ-ын биелэлтийн хэсгээс харна уу. Хавсралт 10 -аас “Үржил шимт хөрс хуулалт, хадгалах” дотоод журмын сургалтын бүртгэлийг үзнэ үү.</p>

19		Шимт хөрсний овоолгын байршил, хэлбэр хэмжээ нь холбогдох стандартын шаардлагыг хангасан байна. Шимт хөрсний бүртгэл хөтлөх, хаягжуулах, овоолго бүрийн үржил шимийн үзүүлэлтийг тодорхойлно.	Шимт хөрсний овоолгыг MNS 5917:2008 Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулах, хадгалах стандартын дагуу, олборлолт хийхээс өмнө шимт хөрсийг тусад нь хуулж зохих стандартын дагуу шимт хөрсний овоолгод байршуулж ажилласан. Төслийн талбайн зонхилох салхины чиглэлийн доор болон хаягдал чулуулгийн овоолго, бага агуулгатай хүдрийн овоолгуудын нөмөрт байрласан нь салхины нөлөөнд хийсэж тоосжилт үүсэх, шим тэжээл адагдахаас сэргийлсэн тохиромжтой байршил хэмээн үзэж төлөвлөсөн. Шимт хөрсний овоолгын байршлыг зураг 4-өөс харна уу. Тайлант жилд шимт хөрс хуулалтын ажил 4-р сард явагдаж 9,593 м3 хөрс хуулж зохих талбайд стандарт шаардлагын дагуу хадгалсан. Мөн ОХШХ-н дагуу үржил шимийн үзүүлэлтийг шинжлүүлсэн үр дүнг ОХШХ-н бүлгээс харна уу.
20		Хог хаягдлыг тээвэрлэж зайлуулах Мэргэжлийн байгууллагатай гэрээ хийж ажиллах	Бороогоулд ХХК нь хог хаягдлын тухай холбогдох хууль дүрэм, стандартын шаардлагад нийцүүлэн “204-5001-ENV-SOP-0016-07 Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах” дотоод журмыг боловсруулан мөрдөн ажилладаг бөгөөд жил бүр дахин хянаж сайжруулдаг. Хавсралт 11-ээс “Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах” дотоод журам-ыг үзнэ үү. Энэхүү дотоод журмын дагуу Улаанбулагийн төслийн үйл ажиллагаанаас үүссэн энгийн хог хаягдлыг зориулалтын саванд цуглуулна. 2025 оны 1-р сарын 1-ний өдрөөс 2025 оны 12 сарын 31-ийг дуустал Улаанбулаг төслийн үйл ажиллагаанаас үүсэх энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, сэргээн ашиглах, дахин боловсруулах, устгах, булшлах үйл ажиллагааг зохион байгуулах зорилгоор Сэлэнгэ аймгийн Мандал сумын хот тохижуулах газартай гэрээгээ шинэчлэн байгуулсан болно. Гэрээний дагуу тухайн байгууллагын ажилчид өөрсдийн ачааны машинаар Улаанбулагийн талбайн энгийн хог хаягдлыг Мандал сумын төвлөрсөн хогийн цэг рүү тээвэрлэн булшлан устгадаг. Хавсралт 12-оос “Хог хаягдлын гэрээ”-г үзнэ үү. Энгийн хог хаягдлаас бусад хог хаягдлыг төслийн талбайд тусгай саванд ангилан түр хугацаанд хуримтлуулж, Бороогийн уурхайн хог хаягдал ангилан түр хадгалах талбайд нэгтгэдэг.
21		Энгийн хог хаягдал хаях сав болон аюултай хог хаягдлын түр хадгалах савны нөхцөл байдлыг сайжруулж, ариутгал цэвэрлэгээг сард нэг удаа хийж, хог хадгалах савны битүүмжлэл, тэмдэг тэмдэглэгээг сайжруулах.	Энгийн хог хаягдлын цэгт ажлын байрны үзлэг, 7 хоног тутмын нийт 44 удаагийн байгаль орчны хяналтын хуудсаар үзлэг шалгалтыг тогтмол хийж шаардлагатай засах арга хэмжээг тухай бүрд авч ажиллалаа. Аюултай хог хаягдлыг Бороогийн уурхайн талбайд түр хадгалж гэрээний дагуу тусгай эрхтэй компанид шилжүүлэн ажилладаг. Уурхайн хог хаягдлын менежментийн тасралтгүй сайжруулалтын ажлын хүрээнд хог хаягдлыг цэгцлэх, ангилан цуглуулах талбайг хасраагуулах, аюултай хог хаягдал түр хадгалах сав байрлуулах, бүх газар хэлтсийн оролцоог нэмэгдүүлэн хогийн цэгүүдийг актаар хүлээлгэж өгч ажилласан. 7 хоног бүрийн энгийн хог ачсаны дараагаар хогийн савыг жавелины уусмалаар ариутгаж халдваргүйжүүлдэг. Хог хаягдлын савны хаягжуулалтыг шинэчлэн байрлуулж,

			<p>компанийн журмын дагуу хар өнгөөр хог хаягдлын савыг жигдрүүлэн будсан. Хавсралт 13- аас халдваргүйжүүлэлт хийсэн тэмдэглэлийг харна уу.</p> 
22		<p>Аюултай хог хаягдлын бүртгэл хөтлөх, мэдээ бэлтгэн орон нутагт хүргүүлэх</p>	<p>Улаанбулагийн уурхайн талбайд үүссэн аюултай хог хаягдлыг түр хадгалах цэгт бөөгнүүлэн Бороогийн уурхайн зориулалтын цэг рүү 7 хоног тутам зөөвөрлөдөг. Мөн БО-ны хэлтсийн ажилчид Улаанбулагийн уурхайн талбайд үүссэн бүх төрлийн аюултай хог хаягдлыг бүртгэж мэдээллийн сан үүсгэж орон нутагт тайлагнаж ажилласан. Дэлгэрэнгүй мэдээллийг Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт бүлгээс харна уу.</p>
23		<p>Жил бүр ургамлын хээрийн хэмжилт хийж ургамлын зүйлийг бүрдлийг тодорхойлж, биомассын хэмжилт хийх</p>	<p>Улаанбулаг төслийн талбайд 2025 онд 2 удаагийн давтамжтай 7 цэгт ургамлын хэмжилт мониторингийн судалгааг хийсэн. Талбай орчимд 3 хэв шинжийн буюу У-IV-2-12, Үетэн- алаг өвст, Х-I-4-1, Жижиг улалж-үетэнт, Н-II-2-3, Үетэн-улалж-алаг өвст бүлгэмдэл бүлгэмдэл бүлгэмдэл тархсан бөгөөд 13 овгийн, 23 төрөлд хамаарагдах 26 зүйл ургамал бүртгэгдсэн байдаг. Гэвч тайлант жилд Сэлэнгэ аймаг болон орчмын бүс нутагт цаг уурын нөхцөл хэт хуурайшиж, олон жилийн дунджаас бага хур тунадас орсонтой холбоотойгоор ган гачиг ноёлсон жил байлаа. Хавар, зуны хугацаанд бороо орсон өдрийн тоо цөөрч, агаарын температур өндөр, салхины хурд их байсан нь хөрсний чийгийг алдагдуулж, ургамлын ургалт муудаж, энгийн өвс, олон настын ургалт сул, ногоон бүрхэц эрс буурч, харин хуурай нөхцөлд тэсвэртэй хог ургамал давамгайлсан ургасан байдал ажиглагдсан. Дэлгэрэнгүй мэдээллийг ОХШ-ий хөтөлбөр хэсгээс үзнэ үү.</p>
24		<p>Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд тарьсан модны арчилгаа усалгааг хийж гүйцэтгэх</p>	<p>Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд Улаанбулаг уурхайн талбайд буюу уурхай доторх төв зам дагуу тарьсан модны арчилгаа усалгааг тогтмол хийж гүйцэтгэж байна. Хөтөлбөрийн хүрээнд мод тарилтын тайлан мэдээг Ерөнхийлөгчийн тамгын газар, БОУАӨЯ, Төв аймгийн Борнуур сум, Сэлэнгэ аймгийн Мандал сумын захиргаанд тус тус хүргүүлж ажилласан. Дэлгэрэнгүй мэдээллийг нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлтийн бүлгээс харна уу.</p>

Амьтны аймаг

25		<p>Уурхайн эргэн тойронд үзэгдсэн амьтдын зураг, ул мөр зэргийг тэмдэглэх, мэдээллийн санд бүртгэх</p>	<p>Хамгаалалтын постууд болон хэлтэс нэгжүүдийн ажлын байранд ан амьтан бүртгэл мэдээллийн хуудсыг байрлуулсан ба уурхайн ажилчид өдөр тутам Улаанбулагийн уурхайн талбайд таарсан болон үзэгдсэн амьтдыг бүртгэж БО-ны хэлтэст мэдээлэн хуудсыг имэйлээр болон цаасаар хүргүүлэн ажилладаг. БО-ны хэлтсийн ажилчид 7 хоног тутам ан амьтны хөдөлгөөн мэдрэгч камерыг уурхайн талбайд байрлуулж өртсөн ан амьтдын зургаар мэдээллийн сан үүсгэж тухайн амьтны төрөл зүйлийн судалгааг хийж ажилласан. Хасвралт 14 хэсгээс бүртгэл мэдээллийн бөглөсөн хуудсыг харна уу.</p>
26	<p>Ухсан нүх, карьерт амьтад орж үрэгдэх, Дуу чимээ, тээврийн</p>	<p>Мал, ан амьтан хамгаалах журмын талаар сургалтыг компанийн үндсэн болон гэрээт ажилчдад зохион байгуулах.</p>	<p>Байгаль орчны сэргээх давтан сургалтаар Бороо болон Улаанбулаг уурхайн үндсэн болон гэрээт нийт 566 ажилтанд “Мал, ан амьтан хамгаалах” журмын сургалт өгсөн байна. Хавсралт 15 -аас “Мал ан амьтан хамгаалах журам”-ыг харна уу.</p>
27	<p>Хэрэгслийн хөдөлгөөн, гэрлийн Нөлөөгөөр байршиж буй газар нутгаасаа үргэх, дайжих, амьдрах орчны шууд хомсдол, хуваагдалд орох</p>	<p>Хүдэр тээврийн замд анхааруулах болон мал, ан амьтны анхааруулах тэмдэг, тэмдэглэгээг байрлуулах Уурхайн тээврийн зам дагуу нүх гарсан байвал бөглөж, мал амьтан гарахад аюулгүй болгох.</p>	<p>Тээврийн зам дагуу MNS 4596: 2014 “Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх” стандартад нийцсэн хурдны хязгаарын болон мал, ан амьтны гарц бүхий газруудад 29 ширхэг анхааруулсан тэмдэглэгээг, Улаанбулаг уурхайн дотоод зам, хүдэр тээврийн зам дагуу нийт 14 ширхэг анхааруулах тэмдэг тэмдэглэгээг байрлуулсан бөгөөд шаардлагатай үед шинэчлэн засварлаж ажилласан.</p> <div data-bbox="958 810 2072 1093" style="display: flex; justify-content: space-around;">    </div>

				
28		<p>Улаанбулаг уурхайн ЦДАШ-д шаардлагатай газруудад шувуу үргээгч байрлуулах анхааруулах тэмдэг, тэмдэглэгээг байрлуулах, эвдэрсэн бол засаж сэлбэх</p>	<p>Тайлант жилд Улаанбулаг уурхайн цахилгааны агаарын шугамд шаардлагатай хэсгүүдэд тулгуурт тольтой болон тросон шувуу үргээгч суурилуулсан.</p>	

4. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

Улаанбулагийн үндсэн ордын олборлолтын гурав дугаар үе шатны явцтай холбоотойгоор 2025 онд нөхөн сэргээх талбай байхгүй учир байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажил тусгагдаагүй ч Улаанбулагийн уурхайн талбайд мод тарих, тохижуулалт хийх, цэцэрлэгжүүлэлт хийх, ил уурхайн олборлолтын ажлын үед үржил шимт хөрсийг “MNS 5916:2008 Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулах, хадгалах стандарт”-ын дагуу хуулах, стандартад заасан хэмжээгээр овоолго үүсгэн хадгалах, зам талбайг зөв төлөвлөн газар ашиглалтад анхаарах зэрэг ажлыг БОМТ-нд тусган хэрэгжүүлж ажиллалаа.


Нөхөн сэргээлт хийж гүйцэтгэхэд шаардагдах үржил шимт хөрсийг “MNS 5916:2008 Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулах, хадгалах стандарт”-д заасан, хангалттай хэмжээнд хуулж хадгалах нь нөхөн сэргээлтийн хувьд үр дүн сайтай, чухал ач холбогдолтой тул төслийн үйл ажиллагаа эхэлснээс хойш дараах арга хэмжээнүүдийг авч ажиллаж байна.

- Шимт хөрс хуулалтын ажлыг явуулахдаа техникийн операторуудад холбогдох шаардлага, журмыг танилцуулж зааварчилгаа өгч, стандартын дагуу хуулалтын ажлыг гүйцэтгэсэн. **Хавсралт 10-** аас “Үржил шимт хөрс хуулалт ба хадгалалт” дотоод журмаар хийсэн сургалтын тэмдэглэлийг харна уу.
- Шимт хөрсийг овоолгод стандартын дагуу байршил, хэлбэр хэмжээг харгалзан 5 м-ээс илүүгүй өндөртэй овоолго үүсгэн хадгалсан.
- Шимт хөрсний овоолгыг салхинд хийсэх, усанд автах, чулуу, хаягдалд дарагдаж зэргээс сэргийлэн, шимт хөрсний овоолгыг олон дахин зөөхгүйгээр тогтвортой хадгалах талбайд байршуулсан.
- Шимт хөрсийг салхины зонхилох чиглэлийн дагуу шимт хөрсний овоолгын гадна талаар салхиар тоос шороо дэгдэн, шимт хөрс алдагдахаас сэргийлж овоолгын дээд гадаргуу, хажууг хэлбэршүүлж олон наст үрийн холимгийг цацан ургамалжуулж хадгалсан.



Зураг 3. Шимт хөрсний овоолгын зураг


2025 онд Улаанбулаг уурхайн урд хана тэлэлтэд 9,593 м³ шимт хөрс хуулж хаягдлын овоолгын зүүн хэсэгт стандартын дагуу хураасан. Төслийн талбайн зонхилох салхины чиглэлийн доор болон хаягдал чулуулгийн овоолго, бага агуулгатай хүдрийн овоолгуудын нөмөрт байрласан нь салхины нөлөөнд хийсэж тоосжилт үүсэх, шим тэжээл алдагдахаас сэргийлсэн тохиромжтой байршил хэмээн үзэж төлөвлөсөн ба БОМТ-нд тусгасны дагуу тогтмол хугацаанд дээж авч итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн. Шимт хөрсний овоолгын байршлыг доорх план зургаас харна уу.



Зураг 4. Шимт хөрсний овоолгын байршил

Үйл ажиллагаа явагдах талбайн шимт хөрсийг хуулж, хадгалахтай холбоотой МУ-ын холбогдох хууль, журам стандартын шаардлагыг хангаж ажиллахын тулд "Үржил

шимт хөрс хуулалт ба хадгалалт” дотоод журмыг боловсруулан мөрдөн ажиллаж байна. **Хавсралт 10** -аас “Үржил шимт хөрс хуулалт ба хадгалах” журмыг үзнэ үү. Энэхүү журмын хэрэгжилтийг хангахын тулд Улаанбулагийн төслийн нийт ажилтнуудад сургалт хийж шимт хөрс хуулах, хадгалах үйл ажиллагаанд байгаль орчны ажилтнууд хяналт тавьж ажилладаг. **Хавсралт 16**-аас “Үржил шимт хөрс хуулалт ба хадгалалт”-ын сургалтын бүртгэлийг харна уу.



Зураг 5. Шимт хөрс хуулалт хийгдсэн талбай

Мод тарих, ойжуулах хөтөлбөр

2025 оны БОМТ-нд тусгагдсаны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэж 3,000,000 модыг 2031 он хүртэл тарьж ургуулахаар зорин ажиллаж байгаа бөгөөд Бороогоулд ХХК нь уурхайн үйл ажиллагаа явагдаж буй талбай болон түүний орчинд хязгаарлагдмал хэрэгцээний ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор ойжуулалт, гадна тохижилтын ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Энэхүү ажлын хүрээнд Улаанбулаг уурхайн талбайд мод тарьж, ургуулан арчлах, хамгаалах арга хэмжээг төлөвлөгөөтэйгөөр зохион байгуулж, уурхайн байгаль орчны нөхцөл байдлыг сайжруулахад чиглэсэн ногоон бүсийг бүрдүүлж байна.

2025 оны хавар болон намрын мод тарилтын хугацаанд Улаанбулаг уурхайн хашаанд болон төслийн талбайн хажууд Бороо гол дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутаг дэвсгэрт мод тарих ажлыг зохион байгууллаа. Уг ажилд компанийн бүх хэлтэс, нэгжүүдийг уриалан оролцуулж, талбайн хуваарилалт, зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулан гүйцэтгэх захирлаар батлуулж гүйцэтгэлийг хангаж ажиллав.

Тайлант хугацаанд төлөвлөгөөний дагуу хаврын улиралд төв зам дагуу нийт 2,530 ширхэг мод тарив. Үүнээс 870 нь улиас, 860 нь агч, 800 нь шар хуайс байсан бөгөөд тарилт нь орчны ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, тоосжилт бууруулах, байгаль орчны үзэмжийг сайжруулах зорилготой байв.

Мөн 2025 оны хаврын мод тарилтын үеэр төслийн талбайн хажууд, Бороо голын дагуу орших “Хамар зам” нэртэй эвдрэлд орж орхигдсон газарт нөхөн сэргээлт хийж, Улаанбулаг мод үржүүлгийн газарт бойжуулсан 3 настай бургасны суулгацыг ашиглан нийт 1,850 ширхэг бургас мод тарилаа. Тарилтыг 3 эгнээ болгон тогоолж ухсан нүхэнд болон шан татаж гүйцэтгэсэн бөгөөд уг ажил нь экологийн хамгаалалтын ач холбогдол бүхий бүс бүрдүүлж, хөндөгдөж орхигдсон голын татмыг сэргээх зорилготой байв. Бургас мод нь салхи, хөрсний элэгдэл, уур амьсгалын нөлөөллөөс хамгаалж, нөхөн сэргээлтийн бүсийн экосистемийг сэргээх ач холбогдолтой тул сонгон тарьсан болно.



Зураг 6. Улаанбулаг уурхайн зам дагуу хаврын мод тарилт



Зураг 7. Улаанбулаг уурхайн зам дагуу ажилтнуудын мод тарилт /Хаврын тарилт/



Зураг 8. Улаанбулаг уурхайн зам дагуу тарьсан модны агаарын зураг /Хаврын тарилт/



Зураг 9. Хамар замын талбайн тарилтын үеийн зураг /Хаврын тарилт/



Зураг 10. Хамар замын талбайн тарилтын дараах зураг /Хаврын тарилт/



Зураг 11. Хамар замын тарилтын дараах агаарын зураг /Хаврын тарилт/

Хавар болон намрын мод тарих ажлыг өөрсдийн “Улаанбулаг” мод үржүүлгийн газарт бойжуулсан, амьдрах чадвар сайтай улиас, бургас, агч модны суулгацаар гүйцэтгэсэн.



Зураг 12. Улаанбулаг мод үржүүлгийн газраас суулгац суллан шилжүүлэх явц



Зураг 13. Уурхайн зам дагуух мод тарилтын бэлтгэл ажил

Тайлант жилийн намрын мод тарилтын үеэр төв зам дагуух талбайд үргэлжлүүлэн 500 улиас, 1,473 агч, мөн Хамар замын талбайд 3,647 бургас мод нэмж тарьсан. Ийнхүү 2025 онд нийт 10,000 ширхэг улиас, бургас, агч, шар хуайс мод тарьж, тогтмол усалгаа, арчилгаа хийж хамгаалан ургуулж байна.



Зураг 14. Уурхай доторх мод тарилтын үйл явц /Намрын тарилт/

Намрын мод тарих ажлын үеэр уурхайн гал тогооноос гарсан хүнсний хаягдлыг боловсруулан гаргаж авсан компост бордоог ашиглаж, хар шороо, элс, бордоог 50:30:20-ын харьцаатайгаар хольж хөрсний бүтэц, шим тэжээлийг сайжруулсан. Тарилтын дараах усалгааг усны машинаар тогтмол хийж, тарьсан модны үндэс суурьшиж ургалт хэвийн явагдахад шаардлагатай нөхцөлийг бүрдүүлсэн.



Зураг 15. Хэлтэс нэгжүүдийн мод тарилтын үйл явц /Намрын тарилт/



Зураг 16. Уурхай доторх мод тарилтын агаарын зураг /Намрын тарилт/



Зураг 17. Хамар замын талбайн тарилтын зураг /Намрын тарилт/



Зураг 18. Хамар замын талбайн тарилтын агаарын зураг /Намрын тарилт/

Мөн уурхайн талбайд өмнө жилүүдэд тарьсан модны арчилгааг тогтмол хийж, усалгаа, арчилгаа, бордох, хог ургамал цэвэрлэх зэрэг ажлыг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн.



Зураг 19. Бороо дүрс үсэг ургалтын байдал / 3 дахь жилдээ/

Улаанбулаг мод үржүүлэг

Бороогоулд ХХК нь улсын хэмжээнд тарьц, суулгацын нөөц дутмаг байгааг нэмэгдүүлэх, өөрсдөө стандартын шаардлага хангасан тарьц, суулгац бойжуулж бэлтгэх зорилгоор уурхайн дэд бүтэц, байгууламжаа түшиглэн Улаанбулаг уурхайн дэргэд дэвшилтэд технологи бүхий мод үржүүлгийн газар байгуулан ажиллаж байгаа билээ.

Улаанбулаг мод үржүүлгийн газарт жил бүр орон нутгийн 10 иргэнийг модны үр, мөчир бэлтгэх, хөрс боловсруулах, үр мөчир тарих арчлах ажилд сурган дадлагажуулж улирлын ажлын байраар ханган ажил эрхлэлтийг дэмжиж байна.

Улаанбулаг мод үржүүлгийн газрын 2025 оны хаврын үйл ажиллагааны хүрээнд 2022 онд навчит, шилмүүст модны үр мөчрөөр тарьсан тарьцын хоёр настай 200,000 гаруй тарьцын бойжуулага, 2023 оны навчит, шилмүүст модны үр мөчрөөр тарьсан тарьцын нэг наст 200,000 гаруй тарьцын бойжуулага арчилгаа усалгааг хийж гүйцэтгэж байна.

4.1. Ил талбайн мөчрийн болон үрийн тарилтын бэлтгэл, тарилт, арчилгаа

2025 оны хаврын мод тарилтад ашиглахаар бойжуулгын талбайгаас шилжүүлэн авсан бургасны болон агчны талбайн усалгааны системийг хураан авч, талбайг шинэ тарилтад бэлтгэн газрыг хагалж, тэгшлэн үр болон мөчрийн тарилт хийхэд бэлтгэсэн.

2025 оны 03 сарын 25-аас 04 сарын 10-ны хооронд бургасны мөчир харандаалж 100,000 орчим харандаалсан мөчир бэлтгэсэн бол улиасны саваа мөчир 2,310 ширхэг бэлтгэгдсэн. Үүний зэрэгцээ мод үржүүлгийн талбайд Бороогийн уурхайн бүсээс хайлаас модны үр гараар түүж тарилтын эх материал бэлтгэсэн.

Хавар үржүүлэг хийх мөчрийг мод унтсан хойно, намар орой -15 хэм хүйтэн болох үед эсвэл хаврын эхээр буюу мод шүүс хөөхөөс өмнө бэлтгэдэг.



Зураг 20. Бургас болон улиасны мөчир харандаалж бэлдэв

Уг бэлдсэн бургас болон улиасны мөчрийн тарилтыг мөчрийн талбайд хийж гүйцэтгэж дууссан бөгөөд хайлаасны үрийн тарилт, нохойн хошуу, долоогоно, монос зэрэг жимсний модны үрийн тарилт хийгдсэн.



Зураг 21. Мөчрийн болон үрийн тарилтын үйл явц



Зураг 22. Мөчрийн болон үрийн тарилтын усалгааны систем угсралт



Зураг 23. Мөчрийн талбайн зэрлэг зулгаах, агротехникийн ажлын зураг




Зураг 24. Мөчрийн талбай / Улиас/



Зураг 25. Мөчрийн талбайн бойжилт /1 настай Улиас/



Зураг 26. Мөчрийн талбайн бойжилт /2 настай Улиас/



Зураг 27. Зоорийн байгууламж

4.2. Хөрс сайжруулах

Органик буюу шим бордоонд төрөл бүрийн малын бууц, шувууны сангас, хүлэр, багсармал компост бордоо, ой модны болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хаягдал, мөн ахуйн органик хаягдал зэрэг орно. Эдгээрээс бууц нь хамгийн өргөн тархсан,

ихээхэн хэрэглэгддэг, ахуйн органик хаягдал юм. Эдгээр нь хөрсний физик, хими, механик шинж чанарыг сайжруулан ургацыг нэмэгдүүлдэг. Малын бууц нь ургамлын гол шим тэжээлийн бодисын эх үүсвэр юм. Бууц нь шим тэжээлийн бодисын урт хугацааны эх үүсвэр болдог бөгөөд хөрсийг хэд хэдэн шим тэжээлийн бодисоор хөрсийг баяжуулж хөрсний бүтэц, чанарыг сайжруулдаг.

Бид бууцны тээвэрлэлтийг тогтмол хийж, хөрсний үржил шимийг дээшлүүлэхэд ашиглаж байна.



Зураг 28. Хөрс сайжруулах өнжмөл бууцыг нөөцлөн шигших, холимогт бэлтгэх



Зураг 29. Үрийн далан болон хөрс сайжруулалтад ашиглахаар элс, бууц, шимт хөрс буулгав 4.1. Хүлэмж, ил талбайн суулгац бойжуулалт, усалгаа, арчилгаа

Хүлэмж, ил талбайн суулгац болон өвөлжүүлсэн суулгацуудын усалгааг 3-р сараас эхлэн тогтмол хийж байна. Хүйтний саруудад МҮГ-ын 2 гүний худаг ажиллагаанд ортол Бонго машин болон Тоннын цагаан саваар ус зөөвөрлөн хүлэмж болон ил талбай, өвөлжүүлсэн суулгацуудын усалгааг тогтмол хийсэн. Түүнчлэн 5-р сарын эхээр ил талбайн дуслын усалгааны системийн холболт, шалгалт хийгдэж, бүрэн ажиллагаанд оруулан, усалгааг тогтмол хийж байна.



Зураг 30. Хүлэмжний усалгаа

2022-2024 оны шилмүүст моддын үрийн бортоготой тарьцыг хүлэмжнээс зөөж байршуулж 18-20 см үртэсээр хучиж торлон өвөлжүүлсэн бөгөөд 2025 оны 4-р сарын сүүлээр дулаалж өвөлжүүлсэн нарсны суулгацыг дулаалгын үртсээс салгаж, хүлэмжид шилжүүлэх, хучлага авах зэрэг шилжүүлгийн ажил хийгдсэн.



Зураг 31. Нарсны суулгацыг дулаалгын үртсээс салгаж, хүлэмжид шилжүүлэв



Зураг 32. Хүлэмжний тарьц арчилгаа



Зураг 33. Хүлэмжний суулгацын бойжилт

4.2. Гадаа талбайн үрийн бойжуулга

Үрийн бойжуулгын талбайд Агч, Шар хуайс, Гүйлс, Хайлаас, Голт бор, Буйлс, Далан хальсийн үрээр тарьсан суулгац нэгээс дөрөв дэхь жилдээ бойжиж байгаа ба технологийн дагуу 3 настай суулгацуудыг шилжүүлэн намрын мод тарилтад ашигласан.



Зураг 34. Үрийн бойжуулгийн талбайн тарилтын явц



Зураг 35. Үрийн бойжуулгийн талбайн ургалтын байдал



Зураг 36. Үрээр тарьсан агч модны бойжилт /3 настай/



Зураг 37. Үрээр тарьсан шар хуайсны бойжилт анхны жилдээ



Зураг 38. Үрээр тарьсан далан хальсийн бойжилт анхны жилдээ



Зураг 39. Үрээр тарьсан Далан хальс болон Голт борын бойжилт эхний жилдээ

4.3. Жимсний эх цэцэрлэг бусад талбайн арчилгаа

Жимсний эх цэцэрлэг 2 га талбайд үхрийн нүд, бөөрөлзгөнө, улаалзгана, алим чавга, хар интоор зэрэг долоон төрлийн моддын арчилгаа, усалгааны ажил технологийн дагуу хийгдэж байна. Мөн үрийн талбайд шар хуайс, монос, гүйлс, буйлс, өрөл зэрэг навчит модод, мөчрийн бойжуулгын талбайд улиас, бургасны бойжуулга, мананжуулах усалгаа бүхий 7 хүлэмжид шинэс, нарсны үрийн бойжуулгын арчилгаа, усалгааны ажил технологийн дагуу хийгдэж байна. Мөн 6-р сараас 8 сар хүртэл ил талбайн хог ургамал устгах, гар хадуур ашиглан хадах, модны усалгааг өдөр тутам хийх зэрэг мод арчилгааг хийж ажилласан. 2 га жимсний модны талбайн нөхөн тарилтыг бортоготой суулгацаар хийж гүйцэтгэсэн



Зураг 40. Жимсний эх цэцэрлэг



Зураг 41. Жимсний модны нөхөн тарилт



Зураг 42. Ил талбайн зэрлэг хог ургамал устгал

Тарьц суулгацын ургалт, тэжээл авах нөхцөлийг сайжруулахаар хүлэмж, ил талбайн зэрлэг болон хог ургамлыг гараар зулгаан цэвэрлэх ажил тогтмол хийгдэж байна.

4.4. Гүзээлзгэнэ тарилт, арчилгаа, хадгалалт

2024 оны намар унтуулж хөргүүрт хадгалсан гүзээлзгэний суулгацыг хүлэмжид сэргээн тарьж, арчлан ургуулж байна.





Зураг 43. Хүлэмжний доод тавцангийн гүзээлзгэнэ

5. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 2012 оны 5 сарын 17-ны шинэчилсэн найруулгаар 3.1.11. “биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах” гэж төслийн үйл ажиллагаанд өртөгдөн унаган төрх, хэв шинж, амьдрах орчноо алдсан биологийн олон янз байдлыг өөр газарт нөхөн хамгаалах арга хэмжээг хэлнэ гэж заасан байдаг. Уул уурхайн олборлолтын үйл ажиллагаагаар газар хөндөх, хөрс хуулах улмаар ургамал, амьтны амьдрах орчин хумигдах зэргээр байгаль орчинд гарцаагүй нөлөөлөл үзүүлж байдаг.

Төслийн үйл ажиллагаанаас үүсэх ул мөрийг хэрэгжилтийн үе шатанд бууруулах, уул уурхайн төсөл хэрэгжиж дууссаны дараа эвдэрсэн газрыг нөхөн сэргээх гэх мэт нөлөөлөл бууруулах арга хэмжээг шат дараалалтай хэрэгжүүлснээр ихэнх нөлөөллийг бууруулах боломжтой. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ гэж дүйцүүлэн хамгаалахаар тогтоогдсон газар нутагт сонгон авсан биологийн олон янз байдлыг хамгаалах, сайжруулахад чиглэгдсэн хамгааллын менежментийн багц арга хэмжээ юм.

Улаанбулагийн алтны үндсэн ордын төслийн үйл ажиллагаатай холбоотой нийт 87.69 га талбай элэгдэл, эвдрэлд өртөх бөгөөд уг талбайд ил уурхай, хөрсний овоолго, ядуу хүдрийн овоолго, хүдрийн овоолго, уурхайн дотоод технологийн зам, шимт хөрсний овоолго багтана.

Бороогоулд ХХК-ийн MV-015285 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбай нь Сэлэнгэ аймгийн Мандал болон Төв аймгийн Борнуур гэсэн 2 сумдын нутаг дэвсгэрт байрлах боловч олборлолтын үйл ажиллагаагаар ил уурхайн ухаш үүсэх 22.09 га талбай нь Төв аймгийн Борнуур сумын нутагт байрлах учир үлдэгдэл нөлөөлөлд өртөж буй талбай гэж тооцож дүйцүүлэн хамгаалал хийх шаардлагатай хэмээн БОННУ-ний хүрээнд тогтоосон болно.

2025 оны биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах хөтөлбөрийн төлөвлөгөөний дагуу ногоон байгууламжийн мод тарих ажлыг Төв аймгийн Борнуур сумын нутагт байрлах Ужгийн амны доройтсон ойн нийт 10 га талбайд 25,000 нарс модыг тарьж ургуулан, нөхөн сэргээхээр төлөвлөн ажилласан. Энэхүү мод тарих ажил нь тухайн бүс нутгийн хөрсний доройтол, ойн сийрэгжилт, биологийн олон янз байдлын бууралт зэрэг сөрөг үзэгдлийг бууруулах, цаашдын ойн экосистемийг сэргээх зорилготой юм.

➤ **Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалахад тохиромжтой газруудыг тодорхойлох**

Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах хөтөлбөрийн хүрээнд ойжуулалт хийх газрыг Төв аймгийн Борнуур сумын орон нутгаас ирүүлсэн саналыг харгалзан сонгосон бөгөөд Борнуур сумын Ужгийн ам нэртэй газрын доройтсон ойг нөхөн сэргээж ажиллаа.

Борнуур сумын удирдлага болон БОХУБ-аас өгсөн зөвлөмж, чиглэлийн дагуу тарилтын ажлыг намар гүйцэтгүүлэхээр “Сонор Жигүүр Хайрхан” ХХК-тай гэрээ байгуулсан.



Зураг 44. Борнуур сумын Ужгийн ам 10 га талбай

Бороогоулд ХХК-ийн Улаанбулаг төслийн Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд Төв аймгийн Борнуур сумын Бичигт 3-р багийн Ужгийн эхийн ойн санд 10га талбайд ойжуулалт хийж, мэрэгч амьтны хашаа барих ажлыг хийж гүйцэтгэх № БГК 220-08-25 дугаартай гэрээг 2025 оны 8-р сарын 25-ны өдөр байгуулсан /Хавсралт 17/. Гэрээнд заасны дагуу Сонор Жигүүр Хайрхан ХХК мэргэжлийн байгууллага нь нарс модны **MNS 6139:2010 “Шилмүүст модны суулгац**

техникийн шаардлага”-д нийцсэн 1-р зэргийн 25,000 ширхэг суулгацаар тарилтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Мөн түүнчлэн тарилт эхлэхийн өмнө тарилт хийх талбайг хашаажуулсан.

Ойжуулалтын технологийн үйл ажиллагааг чанартай гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлэх, ойжуулсан талбайн түймрийн аюулыг бууруулах, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах зорилгоор талбайг ойжуулалтад бэлтгэхдээ дараах ажлыг хийж гүйцэтгэсэн болно. Үүнд:

- Мод тарих эгнээний чиг шугамыг тэмдэглэх
- Техник тоног төхөөрөмжийг ажиллуулахад аюултай газрыг тодорхойлох
- Талбайд унасан мод чулуу саад болох модлог ургамал, жижиг хожуул, хатсан модыг хөрс боловсруулах зурвас дагуу цэвэрлэх



Зураг 45. Ойжуулах талбайн бэлтгэл

Мод үржүүлгийн газраас ухаж бэлтгэсэн суулгацыг тарих хүртэл хугацаанд гүнзгий шуудуунд технологийн дагуу түр хадгалсан. Ойжуулалтын үед суулгацыг ойжуулалтын талбай руу авч явахдаа зузаан материалаар хийсэн тор болон хайрцагт хийж тарьцны үндэсний систем хатахаас сэргийлсэн.



Зураг 46. Тарилтад ашигласан нарс модны тарьц

Тарилтыг 2-3 настай нарс модны суулгацаар 9-р сарын 25-ны өдрөөс эхлэн гар багаж ашиглан, жижиг талбайд хөрс бэлтгэн ойжуулсан. Мод хоорондын зай 2 метр, нүхний гүн, диаметр нь 25-30 см, өнгөн ширгэ хөрсийг хуулж авч доорх хөрсийг зөөллөн тарилтыг хийж гүйцэтгэсэн.



Зураг 47. Тарилтын үеийн зураг



Зураг 48. Тарилтын дараах зураг

6. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Төслийн үйл ажиллагаанд хөдөө аж ахуйн эдэлбэр газрыг ашигласнаар материаллаг болон эдийн засгийн шилжилт үүсдэг. Материаллаг шилжилт гэдэг нь айл өрх, тэдний өмч хөрөнгө (өвөлжөө, бууц, худаг), эзэмшлийг нүүлгэн шилжүүлэхийг хэлэх бөгөөд төслийн талбайгаас 500м хүртэлх зай дотор амьдардаг айл өрхүүдийг нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаа юм. Эдийн засгийн шилжилт гэдэгт айл өрхүүд, тэдний мал сүрэг хуучин бэлчрээсээ болон худаг уснаасаа алслагдах, нүүхийг хэлнэ.

Улаанбулагийн төслийн талбайд айл өрх, тэдний эд хөрөнгө байхгүй бөгөөд нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаа явуулах шаардлага үүсээгүй тул нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг 2025 оны БОМТ-нд тусгагдаагүй болно.

7. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Улаанбулагийн алтны үндсэн ордын дэд бүтэц, барилга байгууламжуудыг барьж байгуулах, тэдгээрийг ашиглахад тухайн нутаг дэвсгэрт буй улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газруудад шууд сөрөг нөлөөлөл байхгүй.

ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэнгийн эрдэмтэд Улаанбулагийн алтны үндсэн ордын талбайд археологийн авран хамгаалах хайгуул судалгааны ажлыг 2015 онд гүйцэтгэсэн бөгөөд “Ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд түүх соёлын аливаа дурсгал илрээгүй ба уурхайн олборлолтын үйл ажиллагаа нь археологийн дурсгалд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй” тухай албан ёсны дүгнэлт гарсан байдаг.

ШУА-ийн Палеонтологи, геологийн хүрээлэнгийн эрдэмтэд Улаанбулгийн алтны үндсэн ордын лицензийн талбайд 2015 онд палеонтологийн хайгуул судалгааны ажлыг гүйцэтгэн палеонтологийн олдвор илрээгүй тул БГК цаашид үйл ажиллагаа явуулахад татгалзах зүйлгүй тухай тэмдэглэсэн дүгнэлт гарсан байдаг. 2025 онд төслийн үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн ямар нэгэн дурсгал, олдвор илрээгүй болно.

Төслийн үйл ажиллагааны явцад ямар нэг түүх соёлын дурсгалын шинжтэй зүйл илэрсэн тохиолдолд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 38.3-т “Газрын хэвлийг эзэмших, ашиглах явцад соёлын биет өв илэрвэл газрын хэвлийг ашиглагч ажлаа зогсоож, энэ тухай сум, дүүргийн Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг хариуцсан байгууллагад нэн даруй мэдэгдэнэ” гэж заасны дагуу холбогдох байгууллага, албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх, боломжит хамгаалах арга хэмжээг авах үүрэг хүлээн ажилладаг.

Төслийн 2025 оны БОМТ-нд дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлийг нь бүрэн хангаж ажиллаа. Үүнд:

Түүх, соёлын үл хөдлөх болон хөдлөх дурсгалын талаар баримтлах дотоод журмыг Түүх, археологийн хүрээлэнтэй хамтран боловсруулах, хянан сайжруулах, журмын хэрэгжилтийг хангаж ажиллах:

БОМТ-нд тусгагдсаны дагуу Улаанбулаг төслийн хайгуулын болон олборлолтын үйл ажиллагаа эхэлснээс хойш үйл ажиллагааны бүхий л үе шатанд археологи, палеонтологийн олдвор санамсаргүй байдлаар олдсон тохиолдолд уг олдвор, хэрэглэгдэхүүнд аливаа гэмтэл учруулалгүй, зохих хууль тогтоомжийн дагуу хамгаалах, тээвэрлэх, судлуулах, мөн газрын хөрсөн доор байж болзошгүй дурсгалд тохиолдож болзошгүй эрсдэлийг бодитойгоор бууруулах зорилгоор ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн салбарын эрхлэгч Доктор, профессор Б.Гүнчинсүрэнтэй хамтран Улаанбулагийн төслийн талбайд хэрэгжүүлэх “Түүх, соёлын үл хөдлөх болон хөдлөх дурсгалын талаар баримтлах журам”-ыг боловсруулж /Хавсралт 18/ 2022 оны 05 сарын 31-ний өдрийн Гүйцэтгэх захирлын тушаалаар батлуулсан. 2025 оны 04 сарын 11-нд уг журмын ээлжит хяналтыг хийн батлуулсан ба өөрчлөлт ороогүй хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

Үндсэн болон гэрээт ажилчдад Түүх, соёлын дурсгалын талаар танилцуулах:

Бороогоулд ХХК-ийн үндсэн болон гэрээт бүх ажилтнуудыг уурхайн талбайд ажиллаж эхлэхээс нь өмнө түүх, соёлын талаарх болон бусад байгаль орчны журмын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд нийт ажилтнуудын хүлээх үүрэг хариуцлагыг байгаль орчны ерөнхий сургалтаар тогтмол танилцуулж, тест авч ажилтнуудын журмын талаар авсан мэдлэгийг бататгадаг. Уг сургалтаар түүх, соёлын үл хөдлөх болон хөдлөх

дурсгалын шинжтэй олдвор олдсон үед ажилтнуудын авч хэрэгжүүлэх арга хэмжээ болон нөхцөл байдлыг хэрхэн зөв мэдээлж ажиллах талаар тодорхой заадаг ба жил бүр нийт ажилтнуудын сэргээх сургалтаар уг журмыг давтан танилцуулж ажиллаж байна. Ингэснээр журмын хэрэгжилтийг хангахаас гадна нийт ажилтнууд түүх, соёлын үл хөдлөх болон хөдлөх дурсгалын ач холбогдол, үнэ цэнийг ойлгох, хэрхэн хамгаалах зэрэг хариуцлагатай хандах соёлыг бий болгох ач холбогдолтой байдаг.

БГК-ийн дотоод сургалтын хөтөлбөрийн хүрээнд тайлант жилд Бороо, Улаанбулаг төслийн талбайд шинээр ирж ажиллаж буй үндсэн болон гэрээт байгууллагын нийт 639 ажилтанд Байгаль орчны ерөнхий сургалтаар, нийт ажилчдын сэргээх сургалтаар 566 ажилтанд “Түүх, соёлын үл хөдлөх болон хөдлөх дурсгалын талаар баримтлах” журмыг танилцуулсан байна. Байгаль орчны сургалтын мэдээллийг энэхүү тайлангийн “Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт” бүлгээс үзнэ үү.

8. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Улаанбулаг төслийн 2025 оны БОМТ-нд тусгагдсан эрсдлийн менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа аюул, эрсдэл үүсэж болзошгүй 7 эх үүсвэрийг тодорхойлж, тэдгээрийг арилгах зорилгоор урьдчилан сэргийлэх, хамгаалах 10 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсний дагуу дараах арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж ажилласан болно.

Хүснэгт 3. Эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Эрсдэлийн эх үүсвэр	Эрсдэлүүд	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Гүйцэтгэл
1	Хатуу хог хаягдал, шатах тослох материал	Ахуйн хатуу хог хаягдлыг тусгай зориулалтын хогийн саванд, тогтоосон цэгт цуглуулах, бодис асгарсан, онцгой үед хэрэглэх багц, шингээгч материалыг зохих газруудад байрлуулах	1	Бүрэн хэрэгжсэн
2	Байгалын гэнэтийн аюултай үзэгдэл	Цаг агаарын аюулт гамшигт үзэгдлээс үүсэх эрсдэл үер ус, газар хөдлөлтийн аюул	1	Бүрэн хэрэгжсэн
		Аянга цахилгааны аюул	1	Бүрэн хэрэгжсэн
3	Үйл ажиллагаа	Болзошгүй галын аюулын эрсдэл	2	Бүрэн хэрэгжсэн

		Цахилгааны гэмтэл	1	Бүрэн хэрэгжсэн
		Хүний эрүүл мэнд	1	Бүрэн хэрэгжсэн
		Тэсрэх материалын тээвэрлэлт, ашиглалтын үеийн эрсдэл	1	Бүрэн хэрэгжсэн
		Автомашин, тээврийн хэрэгслийн ослын эрсдэл	2	Бүрэн хэрэгжсэн

Эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил тус бүрийн хэрэгжилтийг дор дэлгэрэнгүй тайлбарлав.

8.1. Хатуу хог хаягдал, шатах тослох материалаар дамжин хөрсөн бүрхэвч бохирдохоос сэргийлэх арга хэмжээ

Бороогоулд ХХК нь хог хаягдлын тухай холбогдох хууль дүрэм, стандартын шаардлагад нийцүүлэн боловсруулсан “204-5001-ENV-SOP-0016-07 Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах” дотоод журмыг мөрдөн ажилладаг. **Хавсралт 11**-ээс үзнэ үү. Энэхүү журмын хэрэгжилтийг хангах, хог хаягдлын менежментийг сайжруулах зорилгоор газар нэгжүүдийн үйл ажиллагаанаас үүсэж буй энгийн болон аюултай хог хаягдлыг тогтоосон цэгт эмх цэгцтэй, ангилан байршуулах, цуглуулах, овор хэмжээг багасгах боломжит бүх арга хэмжээг авч ажиллахыг актаар баталгаажуулан Гүйцэтгэх захирлын 2023 оны 7-р сарын 7-ны өдрийн А/58 тоот тушаалаар хог хаягдал хариуцсан ажилтан томилох, холбогдох эрх, үүргийг оноох тухай баталгаажуулан холбогдох газар нэгжүүдэд хүлээлгэн өгсөн. Мөн Аюултай хог хаягдал хариуцсан ажилтныг МУ-ын Хог хаягдлын тухай хуулийн 4-р зүйлийн 4.1.41-д зааснаар хэвийн болон аюул, осол гарсан үед аюултай хог хаягдалтай холбоотой үйл ажиллагааг зохицуулах үүргийг хүлээлгэн гүйцэтгэх захирлын 2024 оны 08-р сарын 16-ны Б-558 тоот тушаалаар шинэчлэн томилсон ба тухайн ажилтны ажлын байрны тодорхойлолт хог хаягдлын хууль, журмын хүрээнд гүйцэтгэх үүрэг хариуцлагыг тусгаж оруулсан.



БОРООГОҮЛД КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2023 оны 02 сарын 09 өдөр

Дугаар А/53

Угшанбаатар хот

“Хог хаягдал хариуцсан ажилтан томилох,
холбогдох эрх, үүргийг оноох тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх заалт, Компанийн дүрийн 24 дүгээр зүйлийн “Л” дэх заалт, Хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.17 дэх заалт болон 23 дугаар зүйлийн 23.7 дэх заалт, Гүйцэтгэх захирлын 2021 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 488/21 тоот тушаалаар батлагдсан “Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах” журам болон 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн А/53 тоот тушаалыг тус тус үндэсэн ТУШААХ НЬ:

1. Компанийн үйл ажиллагаанаас үүсэх аюултай хог хаягдал хариуцсан ажилтнаар Боловруулах үйлдвэр эрхэлсэн захирал /Ж.Батжаргал/-г томилон ажиллуулсугай.
2. Энэ тушаал гарсантай холбогдуудан 2019 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 117/19 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.
3. Компанийн үйл ажиллагаанаас үүсэх энгийн болон аюултай хог хаягдлыг ангилан ялгах, хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, сэргээн ашиглах, байгууллагын дотоод болон гадна орны нэвэрлэгээг хариуцах болон хог хаягдлын цэгийг хариуцах ажилтнаар тушаалын Нэгдүгээр хавсралтад дурдсан хог хаягдал үүсгэгч газар, хэлтсийн холбогдох албан тушаалуудыг томилсугай.
4. Компанийн үйл ажиллагаанаас үүсэх энгийн болон аюултай хог хаягдлыг устгах эрх бүхий байгууллагад шилжүүлэх, эдгээр үйл ажиллагаатай холбоотой гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орны хэлтэс /Б.Лхамсүрэн/-т үүрэг болгосугай.
5. Уурхайн талбайд хог хаягдлыг ангилан хаях, цуглуулах, түр хадгалахаар тогтоосон цэгүүдийг газар, хэлтсүүдэд хариуцуулан, хүлээлгэн өгөх актын маягтыг энэхүү тушаалын Хоёрдугаар хавсралтаар баталсугай.
6. Хог хаягдлын тухай хууль, Засгийн газрын 2018 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 116 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам” болон компанийн “Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах” дотоод журам зөрчсөн ажилтанд сахлагын журмын дагуу хариуцлага тооцох эрхийг Байгаль орны хэлтэс /Б.Лхамсүрэн/-т олгосугай.

7. Тушаалын 1, 3, 4 дэх хэсгүүдэд заасан албан тушаалтнуудын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн батлуулахыг Хүний нөөцийн хэлтэс /Б.Цэцэндулам/-т үүрэг болгосугай.


8. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн газар /Б.Чинбат/-т даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Д.ЦЭРЭНБАДАМ -г

Сураг 49. Гүйцэтгэх захирлын тушаал



Зураг 50. Аюултай хог хаягдал хариуцсан ажилтныг томилох тушаал

Төслийн талбайд хамгаалалтын постууд, ажилчдын нарядны болон цайны өрөө, засварын түр байр гэсэн байршлуудаас хог хаягдал үүсдэг бөгөөд эдгээр цэгүүдэд ахуйн гаралтай энгийн хог хаягдлыг түр цуглуулан Бороогийн уурхайн хог хаягдал ангилан ялгах, хадгалах нэгдсэн цэг рүү шилжүүлдэг. Хамгаалалтын постуудад энгийн хог хаягдлыг цуглуулах хогийн сав байршуулсан бөгөөд уурхайн оффис болон засварын байрны ойролцоо 1.64м x 1.22м x 1.20м хэмжээтэй 2 ширхэг энгийн хогийн сав, мөн аюултай хог хаягдлыг түр хадгалах зориулалттай 1.5м x 1.5м x 1м хэмжээтэй 1 ширхэг хогийн сав байрлуулан хаяг тэмдэг тэмдэглэгээний журмын дагуу хаягжуулж стандарт өнгөөр ялгасан. Техникийн засвар үйлчилгээнээс үүссэн аюултай хог хаягдлыг засвар үйлчилгээ хийгдэж дуусмагц механикууд Бороогийн уурхай руу зөөвөрлөн зориулалтын тусгай талбайд ангилан хадгалдаг ба хог хаягдлын бүртгэлийг хөтөлдөг.



Зураг 51. Шатах тослох материалаар бохирдсон хаягдлын сав

Төслийн талбайд шатах тослох материалаар дамжин хөрсөн бүрхэвч бохирдохоос сэргийлэн бодис асгарсан үед хэрэглэх багц, шингээгч материалыг уулын засварын байранд байршуулан лацдан, хэрэглэгдсэн үед нөхөн дүүргэлт хийн ажиллаж байна. БО-ны 7 хоног бүрийн үзлэг шалгалтаар асгаралтын багцын иж бүрэн байдлыг тогтмол шалган ажилладаг.



Зураг 52. Асгаралтын үед хэрэглэх шингээгч материалуудын иж бүрдэл

8.2. Байгалийн гамшигт үзэгдлүүд, Газар хөдлөлт, усны үер зэрэг байгалийн гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх

Болзошгүй байгалийн гамшигт үзэгдэл болон эрсдэлээс сэргийлэх үүднээс цаг агаарын урьдчилсан мэдээ болон аюулт ба гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх бэлгэж нийтэд тараадаг мэдээг үйл ажиллагаандаа бүх ажилчид тогтмол ашигладаг. 7 хоног бүрийн Даваа болон Баасан гарагуудад Сэлэнгэ болон Төв аймгийн ЦУОШГ-ын цахим хуудаснаас авсан 8 хоногийн урьдчилсан мэдээг компанийн гэрээт болон үндсэн ажилчдад мэйлээр холбогдох санамжийн хамт тараадаг. Мөн уурхайн өглөөний хурлын үеэр тухайн өдрийн цаг агаарын мэдээллийг ахлах ажилчдад тогтмол хүргэдэг.

Дохио!!! Цаг агаарын аюултай үзэгдлээс сэрэмжлүүлэх мэдээ



Bolortuya Munkhgerel
To BGC ALL Users
Cc BGC Environment

Reply Reply All Forward

Wed 8/20/2025 10:56 AM

Дохио!!! Цаг агаарын аюултай үзэгдлээс сэрэмжлүүлэх мэдээ

Ойрын өдрүүдэд буюу 8 сарын 20 ноос 22-н хүртэл үргэлжилсэн ахиухан хэмжээний усархаг бороо Сэлэнгэ, Төв аймгийн ихэнх нутгаар орно. Салхи ихэнх хугацаанд баруунаас секундэд 5-10 метр, борооны өмнө түр зуур ширүүсэж секундэд 10-14 метр хүрнэ. Агаарын температур шөнөдөө +9...+14 градус, өдөртөө +19...+24 градус дулаан байна.


Нөөлөг салхи, аянга цахилгаан, үер усны аюулт үзэгдлээс сэргийлэн ажиллана уу!!!

Өнөөдөр оройны 6 цаг хүртэл усархаг бороо орно. Маргааш 2025 оны 8-р сарын 21 нд өдрийн 12 цагаас оройны 10 цаг хүртэл шиврээ бороо орох төлөвтэй байна.



Зураг 53. Цаг агаарын урьдчилсан анхааруулах мэдээ

Хаврын шар ус, хур бороо элбэгтэй үед ил уурхайн талбай болон бусад байгууламжид үерийн ус орохоос сэргийлж үерийн хамгаалалтын далан болон ус зайлуулах суваг шуудууг уурхайн талбайг тойруулан 1000 м урттай, 6.4 м² хөндлөн огтлолын талбайтай хийсэн бөгөөд жил бүр үзлэг шалгалт, шаардлагатай бол засварлан сайжруулах арга хэмжээг авч ажилладаг.



Зураг 54. Үерийн усны хамгаалалтын суваг шуудуу татсан байдал

Аянга, цахилгаан газардуулга тоноглолуудыг төслийн талбайд хамгаалалтын 72-р пост болон дахин дамжуулах станц дээр байгуулсан бөгөөд бүрэн бүтэн болон аюулгүй байдалд 7 хоног бүр үзлэг шалгалтаар хяналт тавьж ажиллаж байна.



Зураг 55. Аянга зайлуулагч

2025 онд Бороо болон Улаанбулаг уурхайн “Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө”-г боловсруулан Онцгой байдлын ерөнхий газраар батлуулж, холбогдох ажилтнууд болон албан тушаалтнуудад хувилбарыг хүргэн, танилцуулж ажилласан.



Зураг 56. Улаанбулагийн уурхайн аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө

8.3. Галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ

Бороогоулд ХХК нь галын аюулаас урьдчилан сэргийлэх, гал түймэртэй тэмцэх аюулгүй ажиллагааны дотоод дүрэм журамтай ба уурхайн талбайд аврах багийн гишүүд

онцгой байдлын үед яаралтай арга хэмжээ авах зорилгоор байнгын бэлэн байдлыг хангаж ажилладаг. Мөн уурхайн аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг жил бүр онцгой байдлын газраар батлуулж ажилладаг. **Хавсралт 19**-өөс Улаанбулагийн төслийн талбайд Галын аюулаас урьдчилан сэргийлэх, галын хамгаалалтын системийн ажиллагааны журмууд болон аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг үзнэ үү.

Улаанбулаг төслийн талбайн оффисын байранд 2ш, уулын засварын хэсэгт 2ш, цахилгааны эх үүсгэвэр буюу генераторт-1ш, нийт 5ш зөөврийн гал унтраах хэрэгслүүдийг зохих байршилд байршуулсан.



Зураг 57. Галын хор байрлуулсан зураг



Зураг 58. Галын хорны хуваарьт үзлэг хийж буй байдал

Галын аюулаас сэргийлж эрсдэлийг буруулахын тулд ажлын байранд 7 хоног бүр галын хорны бүрэн бүтэн байдлыг үзлэг шалгалт хийдэг. Мөн Аюулгүй ажиллагааны ажилтнууд галын аюулаас сэргийлэх үүднээс хуваарьт галын хорны үзлэгийг улирал бүр хийн пайзанд тэмдэглэдэг.

Аюулгүй ажиллагааны хэлтэс уурхайн талбайд ажиллаж буй үндсэн, гэрээт гүйцэтгэгч нийт ажилтнуудад зөөврийн гал унтраагуур ашиглах биечилсэн практик сургалт жилд 1-с доошгүй удаа хуурайшилтын үе буюу намар, хаврын улиралд зохион байгуулж ажиллалаа.

Мөн уурхайн аврах багийн нийт гишүүдэд онцгой байдлын үед бэлэн байдлыг хангах сургалтыг 7 хоног тутам зохион байгуулж сургалтыг батлагдсан төлөвлөгөөний дагуу хийж байна. Уг сургалтаар аврагч нарт ослын талбайд осолдогчид анхны тусламж үзүүлэх, аюулгүй ажиллагааны шаардлагатай дүрэм журам, зааврыг танилцуулахаас гадна галын ослын үед хэрхэн аюул осолгүй ажиллах, галын багаж тоног төхөөрөмжийн хэрхэн аюулгүй ашиглах талаар заавар, зөвлөмжийг өгч дадлагажуулан ажиллаж байна. Мөн уурхайн талбайд эрсдэлтэй ажлын байруудад газар дээр нь төлөвлөгөө зааварчилгааг өгч тухайн ээлжийн аюулгүй байдлыг хангадаг. Мөн галын шланктай харьцах, галын машиныг ажиллуулах, галын машинд байрлуулсан багаж хэрэгслийг ашиглах болон үзлэг шалгалтыг тогтмол хуваарийн дагуу хийдэг.



Зураг 59. Гал унтраах сургалт, дадлага

8.4. Зөөврийн гэрэлтүүлгийн угсралт монтажийг шаардагдах стандартын дагуу хийх

Төслийн үйл ажиллагаанд ATLAS COPCO брэндийн HILIGHT V4 W50HZ ROW LIGHT TOWER нэртэй зөөврийн гэрэлтүүлгийг шаардлагатай газар байрлуулан ашиглаж байна. Зөөврийн гэрлийн цахилгааны холболтын ажлыг хийх аюулгүй ажиллагааны наряд зааварчилгаанд галын аюулаас урьдчилан сэргийлэх талаар тусгагдсан байдаг мөн зөөврийн гэрэлтүүлэг орчимд гал унтраах хэрэгсэл байршуулж тухайн орчимд гал гарахаас урьдчилан сэргийлж ажилладаг.



Зураг 60. Зөөврийн гэрлийн угсралт монтаж

8.5. Эрүүл мэнд, эмнэлгийн анхны тусламж

Улаанбулагийн уурхайн хэмжээнд ажлын байранд мөн тээврийн хэрэгслүүдэд анхны тусламжийн хэрэгслийн хайрцаг 4 ширхгийг байршуулсан бөгөөд сар тутам уурхайн эмч, эрүүл ахуйч анхны тусламжийн хэрэгслүүдийг шалгаж цэнэглэлт хийн бэлэн байдлыг тогтмол хангаж ажилладаг.



Зураг 61. Анхны тусламжийн хайрцаг, хэрэгслүүд

Уурхайн анхны тусламжийн цэгт уурхайн эмч/эрүүл ахуйч нар ажиллаж нийт ажилтнуудын эрүүл мэндэд ямар нэг асуудал үүсэх, онцгой байдлын үед анхны тусламж

үзүүлэх, бэлэн байдлыг ханган ажилладаг. Мөн ажлын байруудад тогтмол үзлэг, шалгалт хийх эрүүл ахуйн шаардлагуудыг ханган ажиллахад хяналт тавьж ажилладаг.

Гүйцэтгэх захирлын 2024 оны 05-р сарын 03-ны өдөр А/32 тоот тушаалаар Ажлын хувцас, хувийн хамгаалах хэрэгслийн журмыг шинэчилж баталсан. Энэ журмын зорилго нь аюултай хүчин зүйлийн нөлөөг бууруулах, хөдөлмөрийн үйл ажиллагааны явцад хүний бие махбодод үзүүлэх орчны нөлөөллийг сайжруулах, хөдөлмөрийн хэвийн нөхцөлийг хангах, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах зориулалттай ажлын дүрэмт хувцас, хамгаалах хэрэгслийг ашиглах, хадгалах, норм тогтоох бөгөөд эдгээр нь ажил мэргэжлийн онцлогоос хамааран олгогддог.

Шинэ ажилтны сургалт болон нийт ажилчдын сэргээх сургалтаар уурхайн аюулгүй ажиллагааны зааварчилгааг давхардсан тоогоор 648 ажилтанд хамруулж бататгах шалтгалт авч ажилд гаргасан байна. Сургалтаар уурхайд дагаж мөрдөх алтан дүрмүүд, ХХХ-ийг зөв хэрэглэх, тэмдэг тэмдэглэгээний журам болон аюул, осол, зөрчлийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ гэх мэт мэдээллийг цогцоор хүргэж ажилладаг.

Аюулгүй ажиллагааны хэлтэс

ШИНЭ АЖИЛТНЫ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГААНЫ БҮРТГЭЛ

№	Овог, нэр	Компани	Хувийн дугаар	Огноо	Зааварчилгаа авсан ажилтны гарын үсэг	Сургагчийн гарын үсэг
1	С. Цэрэн	Mobinet		2025.10.7	<i>[Signature]</i>	<i>[Signature]</i>
2	М. Зоригийн	К-Х		2025.10.7	<i>[Signature]</i>	<i>[Signature]</i>
3	Н. Пурвигийн	Mobinet		2025.10.7	<i>[Signature]</i>	<i>[Signature]</i>
4	Д. Сүрэнжав	Mobinet		2025.10.7	<i>[Signature]</i>	<i>[Signature]</i>
5	З. Сүрэнжав	Mobinet		2025.10.7	<i>[Signature]</i>	<i>[Signature]</i>
6	У. Атантасар	УТБСО "ХХК"		2025.10.8	<i>[Signature]</i>	<i>[Signature]</i>
7	С. Ариунзориал	УТБСО "ХХК"		2025.10.08	<i>[Signature]</i>	<i>[Signature]</i>
8	П. Амгун	А ЧРЧММ		2025.10.08	<i>[Signature]</i>	<i>[Signature]</i>
9	Г. Атантасар	Морчи цагаан		2025.10.8	<i>[Signature]</i>	<i>[Signature]</i>
10	Л. Мөнхтүвшин	Mobinet		2025/10/08	<i>[Signature]</i>	<i>[Signature]</i>
11	С. Ариунзориал	Мобилет		2025/10/08	<i>[Signature]</i>	<i>[Signature]</i>
12	Н. Зургантасар	Мобилет		2025.10.08	<i>[Signature]</i>	<i>[Signature]</i>
13						

Зааварчилгаа авсан ажилтан тус бүрээр гарын үсэг зуруулж баталгаажуулна.

Зураг 62. Шинэ ажилтны ХАБЭА сургалтын бүртгэл

8.6. Тэсрэх материалын ашиглалт

Төслийн талбайд үндсэн болон гэрээт ажилчдад аюулгүй ажиллагааны дүрэм журмыг тогтмол сургалтаар танилцуулан ажилладаг. Тэсэлгээний үйл ажиллагааг явуулахдаа агаарын дэлбэрэлт, чичиргээний талаарх үндэсний болон олон улсын стандартын дагуу өдрийн цагаар хийж гүйцэтгэдэг бөгөөд тэсэлгээний үед “Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийг баримтлан аюулгүй ажиллагааг ханган

аюулгүйн зайг тогтоож, тэсэлгээний аюултай бүсээс бүх хүн, техник, мал амьтныг гаргаж орчныг шалгаж ажилладаг. Тухайн тэсэлгээний удирдагч, тэсэлгээний аюулгүй байдлын харуулууд урьдчилан хуралдаж, мэдэгдэл хүргүүлэх арга хэмжээг авч ажилладаг. Уулын олборлолтын үйл ажиллагаа тайлант жилд 05-р сарын 20-оос 09 дүгээр сарын 02 ний өдөр хүртэл урт хугацааны зогсолт хийж 10-р сарын 15-ны өдөр хүртэл хэвийн ажилласан ба тэсрэх бодисын ашиглалттай холбоотой эрсдэл үүсээгүй.

ТЭСЭЛГЭЭНИЙ МЭДЭГДЭЛ !!! PIT-3 УУРХАЙ


Temuujin Anand
 To: BGC Site Users; Purevraash Duzeenyam; Bat-Orgil Amarbayar
 Cc: BGC Safety; BGC Site Dispatcher; BGC Security Supervisor; Mine Foreman; batbayar.b@blastcompany.mn; buyannemekh.s; drilling@mostmining.mn; Utg Master; b.enkhtaivan2014@gmail.com; Camp Manager Ikh Dashir Foods; +1 other
 Sat 10/18/2025 2:49 PM

This message was sent with High importance.

 Тэсэлгээний харуулын үүрэг.pdf 99 KB
 p3-1050-95.-safety zone-D&B.pdf 1 MB

өнөөдөр 2025.10.18-ний 18:00 ЦАГТ "БОРООГИЙН" УУРХАЙН АШИГЛАЛТЫН PIT-3-1050 ТҮВИНД ТЭСЭЛГЭЭТЭЙ ТҮЛ БҮХ ХҮН, ТЕХНИК АЮУЛГҮЙН ЗАЙД ГАРНА УУ !!!

ТЭСЭЛГЭЭНИЙ УДИРДАГЧААР "БЛАСТ" ХХК-ИЙН ТЭСЭЛГЭЭНИЙ ИНЖЕНЕР С.БҮЯННЭМЭХ УТАС: 9411-3414, ХЯНАЛТААР "БОРООГУУЛД" ХХК-ИЙН ӨРӨМДЛӨГ ТЭСЭЛГЭЭНИЙ ИНЖЕНЕР А.ТЭМУУЖИН УТАС: 9905-0893 НАР АЖИЛЛАНА. ТЭСЭЛГЭЭНИЙ ХУРАЛ 2025 ОНЫ 10-Р САРЫН 18-НИЙ 17:00 ЦАГТ "БОРООГИЙН" УУРХАЙН УУЛЫН АДМИН ОФИС ДЭЭР БОЛОХ ТҮЛ ТЭСЭЛГЭЭНИЙ ХАРУУЛД ТОМИЛОГДСОН ДАРААХ АЖИЛТНУУД ТОВЛОСОН ЦАГТ ИРНЭ УУ !!!

- ҮҮНД:
1. "БЛАСТ" ХХК-ИЙН АНФОТРАХЫН ЖОЛООЧ Э.ТҮВИШКАРГАЛ
 2. "БОРООГУУЛД" ХХК-ИЙН ИЛ УУРХАЙН ЗӨЛЖИЙН МАСТЕР Б.БАТ-ОРГИЛ
 3. "БОРООГУУЛД" ХХК-ИЙН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АЖИЛТАН Б.ЭНХ-ОРЧЛОН
 4. "БОРООГУУЛД" ХХК-ИЙН МАРКШЕЙДЕР ИНЖЕНЕР Б.ЗОРИГТБААТАР
 5. "БОРООГУУЛД" ХХК-ИЙН АХЛАХ ОПЕРАТОР С.ЭНХБОЛД НАР БАЙНА.

АНХААР!!!
 УУРХАЙН ХЭЛТЭС НЭГЖИЙН АХЛАХ АЖИЛТНУУД ТЭСЭЛГЭЭНИЙ МЭДЭГДЛИЙГ АЖИЛЧДАДАА МЭДЭЭЛЭЖ АЖИЛЛАНА. УУРХАЙН ТЭСЭЛГЭЭНИЙ АЖИЛ ЯВАГДАХ ҮЕД РАДИО СТАНЦЫН 2-Р СУВГИЙГ ЧӨЛӨӨЛЖ ЧАГНАХ ГОРИМ ДЭЭР ШИГЖИН АЖИЛЛАХ БА ТЭСЭЛГЭЭНИЙ АЖИЛ ДУУССАНЫГ МЭДЭГДЭХ ХҮРТЭЛ РАДИО СТАНЦЫН 2-Р СУВГААР ЯРИХ, АЮУЛТАЙ БҮС РҮҮ НЭВТРЭХИЙГ ХОРИГЛОНО.
 ЗӨВХӨН ТЭСЭЛГЭЭНИЙ АЖИЛ ЗОГСОХ ОНЦГОЙ ТОХИОЛДОЛД РАДИО СТАНЦЫН 2-Р СУВГИЙГ АШИГЛАЖ БОЛНО.
 ТЭСЭЛГЭЭНИЙ АЖИЛ ЯВАГДАХААС 30 МИНУТЫН ӨМНӨ УУЛ БОЛОН ДАЛАНГИЙН АЖИЛ РАДИО СТАНЦЫН 6-Р СУВАГ РҮҮ ШИТГЭЖ АЖИЛЛАХЫГ АНХААРНА УУ



Зураг 63. Тэсэлгээний мэдэгдэл

8.7. Автомашин, тээврийн хэрэгслийн осол гарахаас сэргийлэх арга хэмжээ

Компанийн дотоод үйл ажиллагааны журмын дагуу замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж ажиллахын тулд уурхайн замд үзлэг шалгалтыг тогтмол гүйцэтгэдэг. Автомашин, тээврийн хэрэгслийн осол гарахаас сэргийлж дараах урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллалаа. Үүнд:

- Байгаль цаг уурын нөхцөл байдлаас үүдэн аюулгүй жолоодлогын анхааруулга санамжийг тухай бүрт нь нийтэд мэдээлж мөн төслийн талбайн хүнд, хөнгөн нийт техник, машин механизмын жолооч, операторуудын аюулгүй байдлыг хангах, болзошгүй аюул ослоос сэргийлж хурдны хязгаарыг бууруулж ажилласан.

Сэрэмжлүүлэг



Surenkhuu Lkhagvarsuren

To: BGC Site Users; drilling@mostmining.mn; zamtiindalan@outlook.com; buyannemekh.s@blastcompany.mn;
Camp Manager lkh Dashir Foods

Tue 6/17/2025 1:10 PM

Reply Reply All Forward

This message was sent with High importance.

Бүгдэд

Цаг агаарын нөхцөл байдал өөрчлөгдөж бороо орж байгаатай холбоотой замд халтиргаа гулгаа үүсэх эрсдэлтэй байгаа тул бүх төрлийн тээврийн хэрэгслээр зорчихдоо хоорондын аюулгүйн зай барьж анхаарал болгоомжтой, замын нөхцөл байдалд хурдаа тохируулж замын хөдөлгөөнд оролцоно уу.



Хүндэтгэсэн



BOROOGOLD

Л.Сүрэнхүү
ХАБ-н ажилтан
АА-ны хэлтэс
Бороогоулд ХХК
Утас: #2205 | 976-99228757 |
Цахим
шуудан: surenkhuu.lkhagvarsuren@boroogold.mn
Веб хууаас: www.boroogold.mn
Ногоон хөгжил, Аюулгүй ажиллагаа, Хармуцлагатай
уул уурхай

Зураг 64. Аюулгүй жолоодлого хийх сэрэмжлүүлэг мэдээ

Уурхайн талбайд тээврийн хэрэгслүүдийн хурдны хязгаарыг Гүйцэтгэх захирлын А/38 тушаалын дагуу ил уурхай болон төслийн талбайн үндсэн замуудын зөвшөөрөгдөх хурдны дээд хязгаарыг 10км/ц-аар бууруулсан бөгөөд хэрэгжилтийг хангуулхаар Хамгаалалтын хэлтэс 7 хоногт 3-4 удаа хурдны хэмжилтийг хийж хяналт тавин төлөвлөгөөний дагуу ажиллаж байна. 2025 онд 107 удаа 727 тээврийн хэрэгслийн хурд шалгаж 20 зөрчил дутагдлыг илрүүлэн холбогдох хэлтэс нэгжүүдэд мэдэгдэж хариу арга хэмжээ авч ажилласан байна.

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ХУРД ШАЛГАСАН ТЭМДЭГЛЭЛ

Огноо: 2025-09-10
Байршил: Хурд талбай
Хурдны хязгаар: 60 км/цаг

№	Жолоочийн нэр	Хэлтэс	Машины дугаар	Км/цаг	Зөрчилгэний тоо	Жолоочийн гарын үсэг
1	Эрбелд	Цул	Ховд 40	41	1	
2	Бадарцаа	Цул	Ховд 38	40	2	
3	Вадим Бадрах	Цул	Ховд 42	37	1	
4	Товч ачигч	Цул	Ховд 51	38	1	
5	Товчсүрэн	Цул	Ховд 44	51	1	
6	Хишигдалсан	Цул	Ховд 36	52	1	
7	Бадарцаа	Цул	Ховд 48	52	1	
8	Вадим Бадрах	Цул	Ховд 42	46	1	
9						
10						
11						
12						
13						
14						
15						
16						
17						
18						
19						
20						

Шалгалт хийсэн: Ажилтны нэр: *Сүрэнхүү Л.*
Ажилтны нэр: *Сүрэнхүү Л.*

Бичиг баримтын дугаар: 22-45PP-204-5101-0101-0003-002
Шалгалтын огноо: 2025 оны 4-р сар



Зураг 65. Тээврийн хэрэгслийн хурд шалгасан тэмдэглэл

- Уурхайн талбайн замын нөхцөл байдал, эрсдэлийн үнэлгээ, аюулгүй жолоодлоготой холбоотой аюулгүй ажиллагааны хурлыг тогтмол зохион байгуулж ажилчдад мэдлэг мэдээлэл өгч анхааруулсан.

Аюулгүй ажиллагааны зөвөрчилгээ, ажлын нэрвэ өгөх журал
Хэвсрэлт-4

ДАВТАН ЗААВАРЧИЛГАА ӨГСӨН АЖИЛТНЫ МЭДЭЭЛЭЛ					
№	Овог нэр	Албан тушаал	Хувийн дугаар	Огноо	Гарын үсэг
1	Б.Энх-Орхон	ХАБ-н ажигтан	6596	2025.10.19	<i>[Signature]</i>
ЗААВАРЧИЛГААНЫ СЭДЭВ: Аюулгүй жолоодлого					
ЗААВАРЧИЛГАА ӨГСӨН ШАЛТГААН: Уулс орж алдаргаа тулган үүсэх өвчний риврал ялган байгаа тийш хөдөөтэй үргэлж Эргүүлэн					
ДАВТАН ЗААВАРЧИЛГАА АВСАН АЖИЛТНЫ МЭДЭЭЛЭЛ					
№	Овог нэр	Албан тушаал	Хувийн дугаар	Огноо	Гарын үсэг
1	Н.Аюулчим	Оператор	6056	2025.10.19	<i>[Signature]</i>
2	У.Зайсан	Оператор	5973	2025.10.19	<i>[Signature]</i>
3	Т.Сүхбаатар	Оператор	5712	2025.10.19	<i>[Signature]</i>
4	Х.Шарууд	Оператор	4068	2025.10.19	<i>[Signature]</i>
5	М.Н.Шарууд	Оператор	6043	2025.10.19	<i>[Signature]</i>
6	Б.Зайсан	Оператор	5572	2025.10.19	<i>[Signature]</i>
7	Б.Цахирал	Оператор	6175	2025.10.19	<i>[Signature]</i>
8	А.Фучидогт	Оператор	6418	2025.10.19	<i>[Signature]</i>
9	Х.Нэргүй	Оператор	6359	2025.10.19	<i>[Signature]</i>
10	А.Зайсан	Оператор	6387	2025.10.19	<i>[Signature]</i>
11	У.Цахирал	Оператор	6340	2025.10.19	<i>[Signature]</i>
12	В.Энхтөговь	Оператор	6201	25.10.19	<i>[Signature]</i>
13	У.Дарамбаатар	Оператор	6389	25.10.19	<i>[Signature]</i>
14	М.Мануулин	Оператор	5989	25.10.19	<i>[Signature]</i>
15	Б.Осорино	Оператор	6805	25.10.19	<i>[Signature]</i>
16	Т.Батцогт	-x-	6420	19.10.25	<i>[Signature]</i>
17	С.Өсөн-Ариун	-x-	6417	20.10.19	<i>[Signature]</i>
18	У.Арвин	-x-	6508	25.10.19	<i>[Signature]</i>
19	Б.Амарал	-x-	6465	25.10.19	<i>[Signature]</i>
20	У.Цахирал	-x-	5593	25.10.19	<i>[Signature]</i>
21	Б.Цахирал	-x-	5882	25.10.19	<i>[Signature]</i>
22	М.Дарамбаатар	Оператор	5654	2025.10.19	<i>[Signature]</i>
23	У.Цахирал	-x-	4628	-	<i>[Signature]</i>
24	У.Цахирал	-x-	5866	2025-10-19	<i>[Signature]</i>
25					

Зааварчилгаа авсан ажилтан тус бүрээр гарын үсэг зуруулж баталгаажуулна.

Аюулгүй ажиллагааны зөвөрчилгээ, ажлын нэрвэ өгөх журал
Хэвсрэлт-4

ДАВТАН ЗААВАРЧИЛГАА ӨГСӨН АЖИЛТНЫ МЭДЭЭЛЭЛ					
№	Овог нэр	Албан тушаал	Хувийн дугаар	Огноо	Гарын үсэг
1	Б.Энх-Орхон	ХАБ	5591	2025.10.19	<i>[Signature]</i>
ЗААВАРЧИЛГААНЫ СЭДЭВ: Уулс орж алдаргаа тулган үүсэх өвчний риврал ялган байгаа тийш хөдөөтэй үргэлж Эргүүлэн					
ЗААВАРЧИЛГАА ӨГСӨН ШАЛТГААН: Уулс орж алдаргаа тулган үүсэх өвчний риврал ялган байгаа тийш хөдөөтэй үргэлж Эргүүлэн					
ДАВТАН ЗААВАРЧИЛГАА АВСАН АЖИЛТНЫ МЭДЭЭЛЭЛ					
№	Овог нэр	Албан тушаал	Хувийн дугаар	Огноо	Гарын үсэг
1	У.Цахирал	Оператор	5678	2025.10.19	<i>[Signature]</i>
2	У.Зайсан	Оператор	6109	2025.10.19	<i>[Signature]</i>
3	У.Цахирал	Оператор	5751	2025.10.19	<i>[Signature]</i>
4	У.Цахирал	Оператор	4994	2025-10-19	<i>[Signature]</i>
5	У.Цахирал	Оператор	5768	2025-10-19	<i>[Signature]</i>
6	У.Цахирал	Оператор	5708	2025.10.19	<i>[Signature]</i>
7					
8					
9					
10					
11					
12					
13					
14					
15					
16					
17					
18					
19					
20					
21					
22					
23					
24					
25					

Зааварчилгаа авсан ажилтан тус бүрээр гарын үсэг зуруулж баталгаажуулна.

Зураг 66. Аюулгүй жолоодлого хийх аюулгүй ажиллагааны хурал

Сэлэнгэ аймгийн Баянгол, Мандал сумын замын цагдаагийн газрын зөвшөөрлийн дагуу хүдэр тээврийн замаас засмал замд нийлэх уулзварт Монгол Улсын авто замын тэмдэг тэмдэглэгээний стандартад нийцсэн хурд сааруулах болон анхааруулах тэмдэг тэмдэглэгээг 50 метр, 100 метрийн зайд байрлуулсан. Энэ нь замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, тээврийн хэрэгслийн хурдыг зохицуулахад дэмжлэг үзүүлэх зорилготой юм.



Зураг 67. Уурхайн дотоод зам дагуу байрлуулсан замын тэмдэг, тэмдэглэгээ



Зураг 68. Хүдэр тээврийн зам дагуу байрлуулсан замын тэмдэг, тэмдэглэгээ

- Тээврийн замд аюулгүй байдлыг нэмэгдүүлэх зорилгоор уул уурхайн тээвэрт ашиглаж буй 47 ширхэг HOWO өөрөө буулгагч техникүүдэд хар хайрцаг суурилуулсан. Эдгээр хар хайрцаг нь тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг бүртгэж, хяналт тавих боломжийг олгодог бөгөөд осол, хурдны зөрчил илэрсэн тохиолдолд мэдээллийг үнэн зөв цуглуулахад чухал ач холбогдолтой. Мөн тээврийн замын уулзварт 180 градусын хяналтын камер, тээврийн замын аюулгүй байдлыг нэмэгдүүлэх зорилгоор тээврийн замын хэсгүүдэд 2 ширхэг камер, хүдэр тээврийн замын хяналтад 2ш PTZ камер суурилуулсан. Эдгээр камерууд нь замын хөдөлгөөнийг тасралтгүй хянах, осол эрсдэлээс урьдчилан

сэргийлэх, хурдны хязгаарлалтын хэрэгжилтэд хяналт тавих боломжийг бүрдүүлж байна.



Зураг 69. Хүдэр тээврийн зам дагуу байрлуулсан хяналтын камер

- Уурхайн талбайд тээврийн хэрэгслүүдийн хурдны хязгаарлалт болон аюулгүй ажиллагааны дүрмийн хэрэгжилтийг хангах үүднээс долоо хоног тутам төлөвлөгөөний дагуу хурдны шалгалт, хэмжилт хийж, зөрчил илэрсэн тохиолдолд шаардлагатай арга хэмжээ авч байна. Энэ нь уурхайн болон замын хөдөлгөөний аюулгүй байдлыг дээшлүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд ихээхэн хувь нэмэр оруулж буй хэрэг юм.



Зураг 70. Замын тэмдэг тэмдэглэгээ, зогсоох саад

- Замын хөдөлгөөний дүрмийн давтан сургалт, танилцуулгыг аюулгүй ажиллагааны хурал болон аюулгүй ажиллагааны сургалтаар нийт ажилтнуудад (гэрээт компанийн ажилтнууд мөн хамаарна) тогтмол танилцуулсан ба уурхай дээр ажлын шаардлагаар жолоо барих ажилтнуудыг уурхайд хөнгөн тэрэг жолоодох эрх олгох сургалтад хамруулан уурхайд баримтлах замын хөдөлгөөний дүрэм журмыг танилцуулж ур чадварын шалгалт аван жолоодох эрх өгдөг.

БОРОО ГОУЛД ХХК

УУРХАЙД ХӨНГӨН ТЭРЭГ ЖОЛООДОХ ЭРХ ОЛГОХ СУРГАЛТ



№	Овог, нэр	Компани	Хэлтэс, нэгж	Огноо	Оролцогчийн гарын үсэг	Сургагчийн гарын үсэг
1	Д. М. Могоор	Майкрософт	Уул	2025.8.5	[Signature]	[Signature]
2	С. Пурвсан	Майкрософт	Уул	2025.8.5	С. Пурвсан	[Signature]
3	Х. Займшув	Майкрософт	Уул	2025.08.05	Х. Займшув	[Signature]
4	Б. Буган-Эрдэнэ	БГК	Т. А. З. Х	2025.08.09	Б. Буган-Эрдэнэ	[Signature]
5	М. Монголбат	БГК	ТАЗХ	2025.08.10	Монголбат	[Signature]
6	Д. Пундуг	Борлоо	Уул	2025.08.10	[Signature]	[Signature]
7	А. Бат-Орш	Борлоо	Уул	2025.08.16	[Signature]	[Signature]
8	Б. Навсхийр	БГК	Уул	2025.8.10	Навсхийр	[Signature]
9	Т. Тогтог	Авруу металл	Тогтог	2025.08.19	Т. Тогтог	[Signature]
10	Т. Болд	Авруу металл	Тогтог	2025.08.19	Т. Болд	[Signature]

Аюулгүй ажиллагааны хэлтэс

MNS4969:2000

Зураг 71. Уурхайд хөнгөн тэрэг барих эрх олгох сургалт, ур чадварын үнэлгээний бүртгэл

АА-ны хэлтэс тээврийн хэрэгсэлд байх шаардлагатай анхан шатны багаж хэрэгслийн үзлэг шалгалтыг 7 хоног тутам хийж байгаа болно. Засварын хэлтэс нь тээврийн хэрэгслийн үзлэг шалгалтыг гүйцэтгэж шаардлагатай үйлчилгээ болон засварын ажлыг тогтмол гүйцэтгэн ажилласан. Тээврийн хэрэгсэлд аюулгүй ажиллагааны шаардлагатай багаж хэрэгсэлүүдийг байрлуулсан. Тээврийн хэрэгслийн үзлэгийн хуудсыг дээрх зургаас харна уу.



УУРХАЙД НЭВТРЭХ ГЭРЭЭТҮҮДИЙН МАШИН, ТЕХНИК, МЕХАНИЗМЫН ҮЗЛЭГИЙН ХУУДАС

Огноо: 2025/09/25/ Цэг: 14:35 Тээврийн хэрэгслийн үзлэг дугаар: 54-36 УНА
Компанийн нэр: Most Drilling Марк: LC 78 LV дугаар: LV 931

Д/л	Шалгах үзүүлэлт	Гүйцэтгэл	Нэмэлт тайлбар
А.Баримт бичиг			
1.	Тээврийн хэрэгслийн гэрчилгээ	✓	
2.	Жолооны үнэмлэх, эрхийн бичиг	✓	
3.	Давтгал албан журмын болон тээврийн хэрэгслийн	✓	
Б.Машины техник, механизм			
4.	БГК-ийн засварын хэлтсийн үзлэгт хамрагдсан эсэх	✓	
5.	Газ унтраагуур /шоорийн эсэлл автомат/	✓	
6.	Дуут дохионы ажиглага	✓	
7.	Суудлын бүс, бүсийн ажиглага	✓	
8.	Туг	✓	
9.	Манк	✓	
10.	Гэрэлтүүлэгч түүш/ шаардлагатай тохиолдолд	✓	
11.	Шил, тос	✓	
12.	Эмийн сан	✓	
13.	Ослын гурвалжин /хоосу/	✓	
14.	Дугуйн илүүр	✓	
15.	Цөөрлөг	✓	
16.	Замны халаагуур, сэрүүтүүлэх системийн ажиглага	✓	
17.	Дугуйн нэгдэл	✓	
18.	Үзлэгийн хуудас байгаа эсэх, /үзлэг хийгдсэн эсэх/	✓	

Жолоочийн нэр гарын үсэг: Р.Дарамъяр
Үзлэг хийсэн: ХАБ-и ажилтан нэр: Б.Насгийншроек



УУРХАЙД НЭВТРЭХ ГЭРЭЭТҮҮДИЙН МАШИН, ТЕХНИК, МЕХАНИЗМЫН ҮЗЛЭГИЙН ХУУДАС

Огноо: 2025/09/25/ Цэг: 11:00 Тээврийн хэрэгслийн үзлэг дугаар: 28-82 УБ
Компанийн нэр: Most Drilling ХХК Марк: D-45 LV дугаар: 27

Д/л	Шалгах үзүүлэлт	Гүйцэтгэл	Нэмэлт тайлбар
А.Баримт бичиг			
1.	Тээврийн хэрэгслийн гэрчилгээ	✓	
2.	Жолооны үнэмлэх, эрхийн бичиг	✓	
3.	Давтгал албан журмын болон тээврийн хэрэгслийн	✓	
Б.Машины техник, механизм			
4.	БГК-ийн засварын хэлтсийн үзлэгт хамрагдсан эсэх	✓	
5.	Газ унтраагуур /шоорийн эсэлл автомат/	✓	
6.	Дуут дохионы ажиглага		
7.	Суудлын бүс, бүсийн ажиглага		
8.	Туг	—	
9.	Манк	✓	
10.	Гэрэлтүүлэгч түүш/ шаардлагатай тохиолдолд	✓	
11.	Шил, тос	✓	
12.	Эмийн сан	✓	
13.	Ослын гурвалжин /хоосу/	✓	
14.	Дугуйн илүүр	—	
15.	Цөөрлөг	✓	
16.	Замны халаагуур, сэрүүтүүлэх системийн ажиглага	✓	
17.	Дугуйн нэгдэл	—	
18.	Үзлэгийн хуудас байгаа эсэх, /үзлэг хийгдсэн эсэх/	✓	

Жолоочийн нэр гарын үсэг: Б.Бугансан
Үзлэг хийсэн: ХАБ-и ажилтан нэр: Б.Бат-Орш

Зураг 72. Тээврийн хэрэгслийн үзлэгийн хуудас шалгасан тэмдэглэл

9. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Бороогоулд ХХК нь хог хаягдлын тухай холбогдох хууль журам, стандартын шаардлагад нийцүүлэн боловсруулсан “2.2.2. SOP 204-5001 ENV 0016-07 Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах” дотоод журмыг мөрдөн ажилладаг. Уг журам болон байгаль орчны бусад дотоод дүрэм, журамд 2025 оны 04 сарын 11-нд дахин хяналт хийж, гүйцэтгэх захирлаар баталгаажуулан ажиллаж байна. **Хавсралт 11**-ээс “Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах дотоод журам”-ыг харна уу.

Тайлант жилд хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг зохих хууль журмыг мөрдлөг болгон бүрэн хэрэгжүүлж ажиллаа.

Журмын дагуу хог хаягдлыг энгийн болон аюултай гэсэн 2 үндсэн төрлөөр ангилан Бороогийн уурхайн талбайд тусгайлан бэлдсэн талбай, нэгдсэн цэгүүдэд хадгалан дараа дараагийн шат дамжлагаар зохих арга хэмжээг авч ажилладаг. Аюултай хог хаягдалд шатамхай, тэсрэмтгий гэх мэт аюултай бохирдуулагч бодисоор бохирдсон хог хаягдал хамаарах бөгөөд аюултай хог хаягдлаас бусад төрлийн хог хаягдал нь энгийн хог хаягдалд тооцогддог.

Улаанбулаг төслийн талбайн хамгаалалтын постууд, ажилчдын нарядны өрөөнөөс энгийн хог хаягдал, уулын засварын түр байранд хийгдсэн засвар үйлчилгээнээс энгийн болон аюултай хог хаягдал үүсдэг. Улаанбулаг уурхайн талбайд үүссэн хог хаягдлыг төслийн талбайд түр хуримтлуулан Бороогийн уурхайн хог хаягдлын нэгдсэн цэгүүд рүү тээвэрлэн ангилан ялгах талбайд байршуулж холбогдох гэрээт байгууллагууд руу шилжүүлдэг.

Доорх хүснэгтэд хог хаягдлын ангиллын төрөл зүйлийг дэлгэрэнгүй харуулав.

Хүснэгт 4. Хог хаягдлын ангилал, тэдгээрийн устгал

№	Хог хаягдлын төрөл	Шат дамжлага	Хаана
1	Ахуйн хог хаягдал	Гэрээний дагуу устгалд шилжүүлэх	Сэлэнгэ аймгийн Мандал сумын “Тохилог Хараа” ААТҮГ-тай байгуулсан гэрээний дагуу устгуулахаар Мандал сум руу тээвэрлэдэг.
2	Хуванцар /Ус ундааны сав, сунадаг гялгар уут/	Дахин боловсруулалтад өгөх	Судалт төв, Сан Оргиу ХХК-д харилцан тохиролцооны дагуу шилжүүлдэг.
3	Картон цаас	Дахин боловсруулалтад шилжүүлэх	ЭКО цаас ХХК-д харилцан тохироцсоны дагуу шилжүүлэхээр ангилан хадгалж байна.
4	Төмөр	Дахин ашиглах эсвэл дахин боловсруулалтад шилжүүлэх	Хаягдал төмрийг Сэц-Энх Стар ХХК-д харилцан тохиролцооны дагуу шилжүүлсэн. Мөн дахин хэрэглэж болох төмрийг дотооддоо дахин ашигладаг.
5	Хаягдал дугуй	Дахин ашиглах эсвэл дахин боловсруулалтад шилжүүлэх	Хаягдал дугуйг уурхайн талбайгаас гаргаж тусгай зөвшөөрөлтэй гэрээт компанид шилжүүлэхээр тусгай талбайд ангилан цуглуулдаг. Мөн дотооддоо дахин ашиглан тохижилтын ажилд ашигладаг.

6	Хаягдал мод	Дахин ашиглах	Дотооддоо дахин ашигладаг
7	Хоосон торх, поошиг /цэвэрлэсэн/	Дахин ашиглах	Цэвэрлэж, хоргүйжүүлсэн торхыг хог хаягдал хийх сав зэрэг зориулалтаар өөрсдөө болон орон нутгийн иргэдэд өгч, дахин ашигладаг.
8	Хаягдал ургамлын тос	Дахин боловсруулах	Канаан ланд ХХК-тай хийсэн гэрээний дагуу гарын саван хийлгэдэг.
9	Хүнсний ногооны хаягдал	Дахин боловсруулах	Нөхөн сэргээлтэд ашиглах компост бордоо гаргаж авдаг.

№	Хог хаягдлын төрөл	Устгах арга	Хаана
1	Хаягдал тос	Дахин боловсруулалтад шилжүүлэх	Хаягдал тос боловсруулах тусгай зөвшөөрөл бүхий "ОБ Ойл" ХХК-д гэрээний дагуу шилжүүлдэг.
2	Ашиглагдсан батерей, аккумулятор	Дахин ашиглах эсвэл дахин боловсруулалтад шилжүүлэх	Тусгай зөвшөөрөлтэй "Электрокем Монгол" ХХК-тай хийсэн гэрээний дагуу хүлээлгэж өгдөг.
3	Эмнэлгийн хог хаягдал	Зориулалтын газар зохих журмын дагуу аюулгүй устгана	Сэлэнгэ аймгийн Мандал сумын нэгдсэн эмнэлэгт шилжүүлж устгуулдаг.

Хүснэгт 5. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Төлөвлөсөн ажлууд	Хийгдэх ажлын тодорхойлолт	Хэрэгжилт, хавсралтын дугаар
Ахуйн гаралтай энгийн хог хаягдал зайлуулах	Уурхайн үйл ажиллагаанаас гарч байгаа хог хаягдлыг бууруулах, дахин ашиглах, боловсруулах. Хог хаягдлыг зориулалтын хогийн сав, цэгт цуглуулж байгаад хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулан тээвэрлүүлнэ.	Ахуйн гаралтай хог хаягдлыг Улаанбулаг уурхайгаас Бороогийн уурхай руу 7 хоног тутам тээвэрлэн Сэлэнгэ аймгийн Мандал суман дахь "Тохилог Хараа" ААТҮГ-т гэрээний дагуу шилжүүлж устгуулдаг. Тайлант жилд Улаанбулагийн уурхайн талбайгаас нийт 17,5м3 хогийг устгуулахаар гаргасан. 
Аюултай хог хаягдал	Аюултай хаягдлыг "Аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах" журмын хэрэгжилтийг хангаж ажиллана. Аюултай хог хаягдлыг дотоод журмын дагуу Бороогийн	Улаанбулагийн төслийн талбайд техник тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг тусгайлан бэлтгэсэн талбайд гүйцэтгэдэг ба засвар үйлчилгээнээс гарсан хаягдал тосыг тухай бүрд нь зөөж авчран Бороогийн уурхайн талбайд байрлах хаягдал тосны танканд хуримтлуулдаг. Ашигласан тосыг дахин боловсруулалтад шилжүүлэхээр ОБ ойл ХХК-тай хамтран ажиллах гэрээтэй бөгөөд гэрээний дагуу шилжүүлдэг.

	<p>уурхайн ангилан цуглуулах талбайд түр хадгалах ба зөвшөөрөл бүхий байгууллагад шилжүүлж ажиллах.</p>	<p>Хавсралт 20-оос “ОБ Ойл” ХХК-тэй байгуулсан гэрээ, дагалдах бичгийн харна уу.</p> <p>Аккумуляторыг мөн Бороогийн уурхай руу тээвэрлэн “Электокем Монгол” ХХК-тай хийсэн гэрээний дагуу дахин боловсруулалтад өгдөг.</p> <p>Шатах, тослох материалаар бохирдсон хаягдал болох бээлий, цагаан хувцас зэргийг цуглуулан түр хадгалах хогийн савыг засварын байрны ойролцоо байрлуулсан. Хаягдлыг 7 хоног бүр Бороогийн уурхай руу тээвэрлэдэг.</p> 
<p>Энгийн хаягдал</p>	<p>Үйл ажиллагаандаа хаягдлыг дахин ашиглах мөн хог хаягдлыг дахин ашиглах, боловсруулах эрх бүхий ААН-үүдтэй хамтран ажиллах, хаягдлыг бууруулах.</p>	<p>Уурхайн талбайд дээр дурдсаны дагуу энгийн хог хаягдлыг картон цаас, хуванцар, хүнсний хаягдал тус бүрээр ангилан ялгаж дахин ашиглаж ажиллаж байна. Улаанбулагийн уурхайн талбайн хог хаягдлын хэмжээг багасгах, дахин боловсруулах зорилгоор ажилчдын цайны өрөөнд ус ундааны хуванцар савыг ангилан хаях хогийн савыг компанийн дотоод журамд нийцүүлэн байрлуулж хаягжуулсан. Ингэснээр ажилчид хог хаягдлыг ангилан хаяхад илүү хялбар болсон.</p>
<p>Үзлэг шалгалт, халдваргүйжүүлэлт</p>	<p>Хогийн сав болон ажилчдын амьдрах байр, гал тогоонд хортон шавжийн ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэх</p>	<p>Улаанбулагийн уурхайн оффисын дэргэдэх ахуйн хогийн цэгийг сард нэг удаа хог дүүрсэн үед Бороогийн уурхайн хогийн цэг рүү шилжүүлэн ачуулсны дараа жавелины уусмалаар шүршиж ариутгалыг хийдэг. Хавсралт 13-аас Ариутгал хийсэн бүртгэлийн хуудсыг харна уу. Улаанбулагийн уурхайн талбайд “Орхон-Овоот” ХХК ариутгал халдваргүйжүүлэлт болон шавж мэрэгч устгах халдваргүйжүүлэх үйл ажиллагааг 2025 оны 08 сарын 09-ны өдөр хийж гүйцэтгэсэн бөгөөд энэхүү ажлыг гүйцэтгэлд уурхайн эмч, эрүүл ахуйч хяналт тавьж ажилласан Хавсралт 21 -ээс харна уу.</p>

Хүснэгт 6. Хог хаягдлын тоо хэмжээ 2025

Төрөл	2025 (10 –р сарын байдлаар)	Устгал
Ахуйн хатуу хог хаягдал	17,5м3	Мандал сумын ахуйн хог хаягдлын цэгт устгасан.
ШТМ-аар бохирдсон материал	35кг	Бороогийн уурхайн талбайн зориулалтын цэгт хадгалдаг.
Хаягдал тос	1442 л	Дахин боловсруулалтад “ОБ Ойл” ХХК-д шилжүүлсэн.
Эмнэлгийн хог хаягдал	0 кг	Мандал сумын нэгдсэн эмнэлэгт устгуулдаг.
Ашиглалтаас гарсан дугуй	1 ш	Уурхайн талбайн хаягдал дугуйн цэгт хадгалагдаж байгаа. /Өөр зориулалтаар дахин ашигладаг./
Хаягдал батерей	0 кг	Уурхайн талбайд тогтоосон цэгт холбогдох зөвшөөрлийн дагуу хадгалагддаг.

Үзлэг шалгалт

Ахуйн хогийн цэг болон хог хаягдал ангилан цуглуулах цэгүүдэд төлөвлөгөөт ажлын байрны үзлэг болон 7 хоног тутмын байгаль орчны хэлтсийн хяналтын хуудсаар ажлын байрны үзлэгийг тогтмол хийж шаардлагатай засах арга хэмжээг тухай бүр авч ажиллалаа. **Хавсралт 22** -оос Хог хаягдал ангилан цуглуулах цэгт гүйцэтгэсэн ажлын байрны үзлэгийн тайланг үзнэ үү.

9.1. Хог хаягдал дахин ашиглах ажлын хүрээнд хийгдсэн ажлууд

Байгалийн нөөцийг хэмнэх, ялгарч буй хог хаягдлыг бууруулах асуудал нь дэлхий нийтийн анхаарлыг татсан чухал сэдвийн нэг болоод байна. Үүнтэй холбоотойгоор 2025 онд Бороогоулд ХХК нь 3R (Reduce, Reuse, Recycle) систем, хог хаягдлыг дахин ашиглах менежментийн хөтөлбөрийг өргөн хүрээнд авч хэрэгжүүлэх зорилт тавин ажилласан ба олон улс болон дотоодын компаниудын авч хэрэгжүүлж буй шилдэг арга туршлагыг судлан, уурхайн үйл ажиллагаандаа нэвтрүүлэх боломжийг эрэлхийлэн дараах ажлуудыг санаачлан хэрэгжүүллээ.

9.1.1 Хуванцрын хаягдлыг дахин боловсруулж хийсэн сандал (RECYCLE)

Өмнө нь ажилчдын хэрэглээнээс үүсэх ус ундааны савыг уурхайн талбайд нэгдсэн хоёр цэгт цуглуулдаг байсан бол тайлант жилд нэмэлтээр ажилчдын хөл хөдөлгөөн ихтэй барилга байгууламжуудад буюу амралтын өрөө, хоолны өрөө, сургалтын өрөө, оффисын цайны өрөө гэх мэт 11 цэгт хуванцар ангилан хаях 60 литрийн багтаамжтай хогийн савнуудыг байршуулсан. Эдгээр хогийн савнуудыг компанийн хаягжуулалт, тэмдэг тэмдэглэгээний дотоод журмын дагуу ногоон өнгөөр сонгож, хаягжуулсан нь ажилчидад хуванцрыг ангилан хаяхад илүү хялбар, хүртээмжтэй болж өгсөн.



Зураг 73. Улаанбулагийн уурхайн нарядны өрөөн дэх ангилах сав

Ингэснээр ангилан хаяж буй хуванцар хаягдлын тоо урьд урьдын жилүүдээс 3-аас 4 дахин нэмэгдсэн үр дүнтэй байна. Сард дунджаар 15-20 кг хуванцар хаягдал цугларч байгаа бөгөөд овор хэмжээг нь багасгах үүднээс бутлагч машинаар бутлан, зарим хуванцрыг пресслэн тээвэрлэлтэд бэлтгэж тусгай талбайд хадгалдаг.



Зураг 74. Бутлан, пресслэн хадгалж буй хуванцар



Зураг 75. Хуванцраар дахин боловсруулж хийсэн сандал

2024 оны 08 сарын 02-нд уурхайн талбайгаас 450 кг бутласан хуванцрыг “Сан Оргиу” ХХК болон “Судалт төв”-тэй хийсэн тохиролцооны дагуу дахин боловсруулалтад шилжүүлсэн. Эдгээр компаниуд нь шилжүүлсэн хуванцар хаягдлыг дахин боловсруулж, гадна тохижилтын түшлэгтэй сандал, дугуйн ивүүр гэх мэт эцсийн бүтээгдэхүүнүүд үйлдвэрлэдэг бөгөөд шилжүүлэн өгсөн хуванцрын үнийн дүнтэй дүйцэхүйц бүтээгдэхүүнийг тохиролцооны дагуу БГК авч өөрсдийн хэрэгцээндээ ашиглаж байна. 2025 оны байдлаар 800кг орчим буталсан болон пресслэсэн хуванцарыг дахин боловсруулах үйлдвэрт шилжүүлэхээр ангилан хадгалах талбайд түр хадгалж байна.

9.1.2 Хаягдал ургамлын тосоор гарын саван хийдэг болов (RECYCLE)

Уурхайн талбайд үүсэх хог хаягдлыг байгальд ээлтэйгээр дахин ашиглах зорилгоор хэрэгжүүлж буй нэг томоохон санаачилга бол хаягдал ургамлын тосыг дахин боловсруулж, эко гарын саван үйлдвэрлэдэг аж ахуйн нэгжтэй хамтран ажиллаж буй явдал юм.

Уурхайн гал тогооноос долоо хоногт дунджаар 10-15 литр ашигласан ургамлын тос гардаг бөгөөд энэ тосыг шууд хаях нь хөрс, усыг бохирдуулах аюултай байдаг. Харин хаягдал ургамлын тосыг дахин боловсруулснаар хог хаягдлын хэмжээ багасаж, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах ач холбогдолтой юм.



Зураг 76. Уурхайн гал тогооноос гарч буй хаягдал тосыг цуглуулсан байдал

2024 оны 05 сарын 17-нд Бороогоулд ХХК нь Канаан ланд ХХК-тай албан ёсны гэрээ байгуулж, 2025 онд уурхайн гал тогооноос гарч буй хаягдал тосыг тогтмол нийлүүлж эхэлсэн. Канаан ланд ХХК нь нийлүүлсэн хаягдал ургамлын тосыг дахин боловсруулж, эко гарын саван үйлдвэрлэдэг бөгөөд үүнийг бид байгууллагынхаа дотоод хэрэглээнд ашиглаж байна.

“Доргонт” гарын саван хариуцлагатай уул уурхайн ,хариуцлагатай бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж эхлэв

Бороогоулд компани биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах хөтөлбөрийг 2018 оноос хойш хэрэгжүүлж эхэлсэн. Энэ хөтөлбөрийн хүрээнд хоёр том төсөл хэрэгжүүлж байгаагийн нэг нь Сэлэнгэ аймгийн Баянгол сумын Хараа багийн нутагт Доргонт хэмээх 7000 га газарт бэлчээрийн менежментийг сайжруулахаар хэрэгжиж эхэлсэн төсөл. Доргонтын малчид болон Бороогоулд компани малын өөх тос, хаягдал ургамлын тос нийлүүлж, Шим Эрдэнэ ХХК-тай хамтран гарын хатуу болон шингэн саван үйлдвэрлэх бичил төсөлийг 2025 оноос хэрэгжүүлж эхэлсэн. Энхүү бичил төслийн үр нөлөө:

- Органик үйлдвэрлэл ба орон нутгийн дэмжлэг – Доргонтын малчдын нийлүүлсэн өөх тосыг савангийн түүхий эд болгон ашигласнаар нутгийн иргэдийн орлого нэмэгдэж байна.
- Хаягдал тос дахин ашиглалт – Бороо уурхайн ажилчдын хоолны газраас гардаг хаягдал ургамлын тосыг савангийн үйлдвэрлэлд ашигласнаар хог хаягдлыг бууруулж, байгаль орчныг хамгаалж буй сайн жишээ болж байна.
- Экосистемийн тогтвортой хөгжил – Органик саван хэрэглэх нь хүний эрүүл мэндэд тустайгаас гадна байгаль орчинд ээлтэй, тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулж байна.

Тухайлбал, уурхайн оффис, ажилчдын амралтын өрөө, ариун цэврийн өрөө зэрэг газруудад энэ саванг байршуулж, өдөр тутмын хэрэглээнд нэвтрүүлсэн нь ажилчдын дунд байгальд ээлтэй бүтээгдэхүүнийг хэрэглэж хэвшихэд эерэг нөлөө үзүүлж байна.



Зураг 77. Гарган авсан эко гарын саван

Ингэснээр зөвхөн хаягдал ургамлын тосыг зөв зохистой ашиглах төдийгүй, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг багасгах тогтвортой хөгжлийн бодлогод нийцсэн ажил болж байна. Мөн ашиглагдахгүй байсан нөөцийг дахин боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн болгон ашиглах боломжийг нэмэгдүүлж байгаагаараа онцлогтой.

Энэхүү гарын саван нь байгаль орчинд ээлтэй, эдийн засгийн хувьд үр ашигтай байхаас гадна компанийн хариуцлагатай, тогтвортой үйл ажиллагааг илэрхийлэх зүйл болж байна.

Хаягдал мод, төмөр торх болон ашиглалтаас гарсан хувцас дахин ашиглалт:

Уурхайн тусгайлан бэлдсэн талбайд хадгалагдаж байсан хаягдал модон подон болон торхыг үр ашигтайгаар дахин ашиглаж, ажилчдын чөлөөт цагаа зөв өнгөрөх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор модон подон болон торхон сандал ширээ хийж тохиромжтой цэгүүдэд байрлуулав. Мөн хүнд даацын техникээс үүссэн хаягдал тосны шүүрийг саармагжуулан цэвэрлэж, гэрэл ойлгогч, хөл хийж уурхайн доторх зам талбайн уулзвар, хөмсөг хэсгүүдэд суурилуулсан.



Зураг 78. Хаягдал модоор хийсэн сандал болон ажилчдын хуучин хувцсаар сандлын дэр хийсэн байдал



Зураг 79. Хаягдал төмөр торхоор хийсэн сандал ширээ



Зураг 80. Хаягдал мод ашиглан модон бортого хийсэн байдал



Зураг 81. Төв замын хөмсөг дагуух гэрэл ойлгогч тэмдэгүүд

Нийт ажилчдын дунд хог хаягдлын Эко шийдэл уралдаан зарлав:

Уурхайн үйл ажиллагаанаас үүсч буй хог хаягдлыг бууруулах, дахин ашиглах, дахин боловсруулах, шинэ санал санаачилгыг дэмжих зорилгын хүрээнд Байгаль орчны хэлтсээс “Хог хаягдлын эко шийдэл” сэдэвт уралдааныг компанийн нийт ажилчдын дунд зохион байгууллаа. Тус уралдаанд нийт 8 хэлтэс нэгжүүд идэвхтэй оролцож, шилдэг санаа санаачилга, уран сэтгэмж, бүтээлч байдлаараа онцлог бүтээлүүдийг танилцуулсан.

Уралдааны бүтээлүүдээс сонирхуулбал:



Зураг 82. Хаягдал агаар шүүгч, төмрийн хаягдлаар хийсэн цэцгийн сав



Зураг 83. Хаягдал төмөр торхоор хийсэн борооны ус цуглуулагч танк



Зураг 84. Хаягдал төмрөөр хийсэн шорлогны зуух



Зураг 85. Замын гэрээл ойлгогч тэмдэг

9.1.3 Хоол хүнсний хаягдлыг ашиглан компост бордоо үйлдвэрлэх төсөл

Бороогийн уурхайн ажилчдын кемпийн галт тогооноос тогтмол хүнсний хаягдал үүсдэг. Энэ хаягдал нь энгийн хог хаягдлын цэгт түр хадгалагдаж, дараа нь гэрээт байгууллагад шилжүүлэн устгагддаг. Гэхдээ хадгалагдах хугацаанд хаягдал ялзрах, муудах явцад үнэр гарч, нян бактер үржиж, энэ нь өвчлөл, бохирдол үүсгэх зэрэг сөрөг нөлөөлөлтэй.

БО-ны хэлтсийн ажилтнууд хоол үйлдвэрлэгч Их дашир Фүүдс ХХК-тай хамтран гал тогооноос гарсан бүх хүнсний ногооны хаягдлыг тусгай цэгт ангилан хадгалж органик бордоо болгон боловсруулж байна. Цуглуулж бэлтгэсэн хүнсний ногооны хаягдлыг жижиглэн бутлаж, өдөрт 2-3 удаа зориулалтын хутгалтын багаж, хүрзээр хутгаж, үртэс, зорголтой хамт бордооны саванд нэмж температур болон чийгийг стандарт түвшинд барьж ажиллаж байна. Үүний үр дүнд хүнсний хаягдал исэлдэж задралд орж органик бордоо үүсэх явц зохих технологийн дагуу хийгдэж байна. Уурхайн хэмжээнд сард дунджаар 140-160 орчим кг хүнс, ногооны хаягдал гардаг ба нийт хаягдлыг 100% бордоо үйлдвэрлэх төсөлдөө ашиглаж байна.



Зураг 86. Бордоо боловсруулах сав

Зохих технологийн дагуу бордоог боловсруулж бэлэн болсон хэсгийг шигшин эцсийн бүтээгдэхүүнээ тасралтгүй гарган авч, итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэн MNS 6507:2015 стандартын шаардлагад нийцүүлэн ажиллаж байна.



**ХОДОО АЖ АХУЙН ИХ СУРГУУЛЬ,
АГРОЭКОЛОГИЙН СУРГУУЛЬ, ХӨРС-
АГРОХИМИЙН ЛАБОРАТОРИ**



Хан-Уул-Дүүрэг, 11-р хороо, Зайсан,
Хянан агаарын тусгаарлах
Агроэкологийн сургууль, 165.164 тусгаар
Шугамын цагдаагийн байр Могой уул,
Улаанбаатар-210335/18 306-МНС
Утас: (976)-99275018, Факс: (976)-73107777
E-mail: ojdared@yuu@mnas.edu.mn

№ 014

Сорын авсан газар	Салынга аймэг	Сорын хүлээн авсан огноо	2024.09.11Б
Зочинлагч	"Ус Оюу"ХХК	Сорын шинжилгээний огноо	2024.09.26
Сорын төрөл	компост бордоо	Сорилтын стандарт	MNS6819:2020
Сорын тоо	1		MNS6820:2020
			MNS6821:2020
			MNS6823:2020

Бордооны химийн шинжилгээний дүн

№	Дэвжний нэр	pH	ЦДЧ dS/m	Чийг, %	Органик үлдэгдэл, %	Унс, %	Нийт		
							Азот, %	Фосфор, %	Кальц, %
1	Бордоо	7.40	0.413	15	35	65	5.88	0.48	0.41

Бордооны хүнд металлын шинжилгээний дүн

№	Дэвжний нэр	Ca - мг/кг	Co - мг/кг	Zn - мг/кг	Ni - мг/кг	Pb - мг/кг	Cd - мг/кг
1	Бордоо	3.0	33> илрээгүй	2.6	16> илрээгүй	6> илрээгүй	17> илрээгүй

Жэж: Энэ дүнг анхны шинжилгээний хариу нь өөрийн үндсэн өгөгдөлөөр хийжээ.
Хөрс, агроэкологийн лабораторийн бичгэр өгсөн нөмөрлөгүүдээр сорилтын дүнгийн үүдэнг өөрчлөхөд хориглоно.

Хянаж баталгаажуулсан:

Агроэкологийн сургуулийн захирал:



Б.Омгэрзан /Ph.D./
Доктор-профессор

Лабораторийн эрхлэгч:



Б.Омгэрзан /Ph.D./
Профессор

Лабораторийн задлан шинжлэгч:

7.33

Г.Батхонгор /M.Sc/

Зураг 87. Бордооны шинжилгээний хариу

Уг төсөл хэрэгжсэнээр мод үржүүлэг, нөхөн сэргээлт болон ойжуулалтын ажилд ашиглагдах бордооны хэрэгцээнд хувь нэмэр оруулах, мөн уурхайн талбайд үүсэх хүнсний хог хаягдлыг бүрэн дахин ашиглах ба хог хаягдлын хэмжээг бууруулж, байгаль орчинд ээлтэй компост бордоо үйлдвэрлэн хөрсний үржил шимийг нэмэгдүүлж, ногоон ургамлын ургалтын нөхцөл сайжирснаар байгалийн нөхөн төлжилт эрчимтэй явагдаж, хүлэмжийн хийн шингээлтийг нэмэгдүүлэх, сөрөг нөлөөллийг бууруулах ач холбогдолтой юм.

2025 оны 10 дугаар сарын байдлаар 3.3 тн хүнс, ногооны хаягдал ашиглаж хагас тн /800кг/ орчим боловсорч гүйцсэн органик бордоог бид үйлдвэрлээд байна. Энэ нь нийт хүнс, ногооны хаягдлаа бүрэн боловсруулж тэдгээр нь задралд орж, овор хэмжээ нь багасаж, анх ашигласан хүнс, ногооны хаягдлын жингийн 4/1 хэсэг хэмжээ органик бордоо болон хувирч буй бодит жишээ юм. Боловсорч гүйцсэн органик бордоог зориулалтын чийг барих саванд түр хадгалан хавар болон намрын мод тарилтын ажилд хөрс сайжруулах, бордох зорилгоор ашиглаж байна.



Зураг 88. Хүнсний хаягдлыг хатааж байна



Зураг 89. Бордоо хутгалт, хэмжилт



Зураг 90. Эцсийн бүтээгдэхүүн бордоо бэлэн болов

9.1.4 Чийгийн улаан өтөөр компост бордоо хийх

Уурхайн талбайн гал тогооноос гарч буй хаягдал өндөгний хайрцаг, Бананы хальс, Алим хальс, Кофе шаар, Өндөгний гадна бор, цагаан хальс зэрэг хүнсний хаягдлаар био ялзмаг хөрс боловсруулах үүрэгтэй мөн хөрсийг давхар ариутгах ашиг тустай чийгийн улааныг үржүүлэх ажлыг эхлүүлэн амжилттай ажиллаж байна.



Зураг 91. Чийгийн улаанаар компост бордоо гаргах

Өнгөрсөн жилийн хугацаанд 300гр чийгийн улааныг үржүүлэн 10-15кг компост бордоог амжилттай гарган авсан. Энэ жилийн чийгийн улааны биомасс 1,2кг хүртэл үржиж одоогийн байдлаар 30-35кг хуурай, 1,5л орчим шингэн компост бордоог амжилттай гарган аваад байна. Чийгийн улаан нь жилийн туршид үржин тоо хэмжээгээ 100 дахин түүнээс илүүтэйгээр үржих чадвартай байдаг тул цаашид технологийн дагуу компост бордоог илүү их хэмжээтэйгээр гарган авч ажиллахаар төлөвлөөд байна.

10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Ашигт малтмалын тухай хуулиудын дагуу тайлант жилд төсөл хэрэгжүүлэгч Бороогоулд ХХК нь орчны хяналт шинжилгээний ажлыг ажиглалт, хээрийн хэмжилт, дээжлэлтийг батлагдсан аргазүй, стандартын дагуу холбогдох зардлын хамт

төлөвлөн хэрэгжүүлж, төслийн талбайгаас авсан аливаа дээжүүдийг Монгол улсын итгэмжлэгдсэн лабораториудад хүргүүлж, гарсан үр дүнг боловсруулан ажилласан.

Тайлант хугацаанд Бороогоулд ХХК-ийн Улаанбулаг төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийг хянах, сөрөг нөлөөллийг бууруулах оновчтой арга хэмжээг сонгох, хяналт шинжилгээний мэдээллийн санг бүрдүүлэн Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ)-т тусгагдсан ажлуудыг хугацаанд нь бүрэн хэрэгжүүллээ.

Хүснэгт 7. Орчны хяналт шинжилгээ гүйцэтгэсэн цэгүүд болон үзүүлэлтүүд

№	Хүрээлэн буй орчны хүчин зүйлс	Хяналт шинжилгээ хийх байршил	Цэгийн дугаар	Хэмжих параметр
1	Гадаргын болон гүний усны чанар:	Бороогийн уурхайн усан хангамжийн гүний 5 худгаас Бороо голын дээд хэсэг 48 U 0596072 UTM 5387552 Бороо голын дунд хэсэг 48 U 0595766 UTM 5391169 Бороо голын доод хэсэг 48 U 0594652 UTM 5393318 Зуун модны гол 48 U 0597851 UTM 395034 Улаанбулаг уурхайн худаг 48 U 0596132 UTM 5391269 Мод үржүүлгийн газрын худгууд 48 U 0596037 UTM 5390683 48 U 0595925 UTM 5390995 Ил уурхайд үүссэн хурын ус 48 U 0596761 UTM 5391452	MB 1-5 UR MR DR ZMR UB_BR TNBR#1 TNBR#2	Химийн шинжилгээ Бактериологи
		Шимт хөрсний овоолго, эрүүл талбай 48 U 0597135 UTM 5390818 48 U 0596284 UTM 5390954 Засварын байр 48U 0597408 UTM 5391477 Хүдэр тээврийн зам 48U 0596610 UTM 5393829 Оффиссын байр 48U 0596258 UTM 5391271	Soil#1 Soil#2 Soil#3 Soil#4	Хөрсний механик бүрэлдэхүүн, ялзмаг, химийн үзүүлэлтүүд, Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн агууламж
3	Агаарын чанар:	N48°40'08.39" E106°19'22.27" N48°39'58.39" E106°20'02.27" N48°39'10.65" E106°19'41.62" N48°39'39.86" E106°18'24.78" N48°39'30.80" E106°19'27.63" N48°39'55.12" E106°19'47.12"	AQ#1 AQ#2 AQ#3 AQ#4 AQ#5 AQ#6	Хүчилтөрөгч, (O2);Нүүрстөрөгч ийн исэл CO;Азотын исэл (NO2); Устөрөгчийн цианид (HCN); Хүхрийн давхар исэл (SO2-) Тоос

№	Хүрээлэн буй орчны хүчин зүйлс	Хяналт шинжилгээ хийх байршил	Цэгийн дугаар	Хэмжих параметр
4	Ажлын байрны эрүүл ахуйн үзүүлэлтүүд	Уулын техникүүд ажиллаж буй зам талбайд Ил уурхай орчимд Оффисын орчимд		Дуу чимээ, гэрэлтүүлэг
5	Ургамлан нөмрөг, амьтны аймаг	Дараах үзүүлэлтүүдийг нөлөөллөөс тусгаарлан авсан 10х10м талбай бүрд тогтмол хийх. -Ургамлын зүйлийн бүрдэл -Ургамлын ургац -Бэлчээр, тэжээлийн ашигт ургамлын илрүүлэлт -Ургамлын бүрхэц	Төслийн талбайн хүрээ, орчны бүсэд 5-7 цэгт	
6	Амьтны аймаг	Шавж, мөлхөгчид, шувууд болон хөхтөн амьтдын хяналт мониторинг хийх, Уурхайн эргэн тойронд үзэгдсэн амьтдын зураг, ул мөр зэргийг тэмдэглэж авч амьтдын мэдээллийн санд бүртгэх.		


10.1. Гадаргын болон гүний усны хяналт шинжилгээ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон Улаанбулагийн алтны үндсэн ордыг ашиглах төслийн Байгаль орчны нарийвчилсан нөлөөллийн үнэлгээ /БОННУ/-нд тусгагдсаны дагуу гүний усны хяналт шинжилгээний дээжлэлтийг Бороогийн уурхайн усан хангамжийн 5, Улаанбулагийн уурхайн 1, Мод үржүүлгийн газрын 2 худгаас, гадаргын усны хяналт шинжилгээг Улаанбулаг төслийн талбайн баруун талд байрлах Бороо голын 3 цэгээс, төслийн талбайн хойд талд байрлах Зуунмодны голын 1 цэгээс, Уурхайн шүүрлийн уснаас нийт 13 цэгээс усны хээрийн хэмжилт, дээжлэлтийн ажлыг гүйцэтгэж итгэмжлэгдсэн лаборатори буюу Геологийн төв лабораторид химийн шинжилгээг хийлгэсэн. Улаанбулагийн төслийн усны хяналт шинжилгээний лабораторийн үр дүнг **Хавсралт 23** -аас үзнэ үү.

Хүснэгт 8. Усны шинжилгээний дээж авсан цэгийн тодорхойлолт

№	Дээжний цэгийн нэр	Цэгийн координат	Дээж авсан газрын тодорхойлолт
1	Хяналтын дээж	48 U 0586016 UTM 5399860	Бороо голын эрэг дагуу байрладаг усан хангамжийн 1-5 дугаар худаг.
2	МВ1-р худаг	48 U 0586016 UTM 5399860	
3	МВ2-р худаг	48 U 0594232 UTM 5401846	
4	МВ3-р худаг	48 U 0594389 UTM 5400975	
5	МВ4-р худаг	48 U 0594336 UTM 5400027	
6	МВ5-р худаг	48 U 0594471 UTM 5398966	

7	UR-Бороо голын эхэн хэсэг	48 U 0596072 UTM 5387552	Төслийн талбайн баруун болон хойд хэсэгт байрлах голууд буюу гадаргын усны хяналтын цэгүүд.
8	MR-Бороо голын дундхэсэг	48 U 0595766 5391169	
9	DR-Бороо голын адаг хэсэг	48 U 0594652 UTM 5393318	
10	ZMR-Зуун модны гол	48 U 0597851 UTM 5395034	
11	Улаанбулагийн гүний худаг,	49 U 0596130 UTM 5391229	Уурхайн гүний худаг болон мод үржүүлгийн газрын 2 худаг
12	МҮГ-ын 1-р худаг	48 U 0596037 UTM 5390683	
13	МҮГ-ын 2- худаг	48 U 0595720 UTM 5390993	
14	Шүүрлийн ус	48 U 0596761 UTM 5391452	



Зураг 92. Улаанбулаг төслийн гадаргын усны хяналт шинжилгээний цэгүүд

Судалгааны арга зүй, ашигласан багаж төхөөрөмжийн хувьд усны дээж, сорьцод химийн задлан шинжилгээг сонгомол болон багажит шинжилгээний арга аргачлалаар гүйцэтгэсэн бөгөөд усны макро элемент, нэгдлүүдийг тодорхойлоход MNS ISO, ISO аргачлалуудын дагуу эзлэхүүний, жингийн, спектрофотометрийн болон индукцийн холбоост плазмын оптик эмиссийн спектрометрийн аргууд, физик үзүүлэлтүүд (рН, цахилгаан дамжуулах чанар, температур, TDS) - ийг усны чанар шалгагч багаж ашиглан

Геологийн төв лабораторит тодорхойлсон болно. Хүнд металлууд болон бусад микро элементүүдийг индукцийн холбоост плазмын масс спектрометрийн аргаар тодорхойлдог ба мөнгөн усыг АМА 254 мөнгөн усны анализатороор, цианидыг спектрофотометрийн аргаар тодорхойлдог.

Усны чанарын мониторинг хийх удирдамжийн дагуу хяналтын цэгүүдэд хэмжилт, дээжлэлт хийгдсэн ба эрдэсийн найрлага буюу үндсэн ионуудын агууламж, микроэлементүүд, исэлдэн ангижрах потенциал, урвалын орчныг лабораторийн шинжилгээгээр тогтоосон 2025 оны 1-ээс 10 дугаар сарын үр дүнг нэгтгэж дараах хүснэгтүүдэд орууллаа.

Гүний худгийн усанд хийгдсэн макро болон микрохимийн шинжилгээний үр дүнг “MNS 0900:2018 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт” стандарттай харьцуулан үзэхэд ундны усны чанарын шаардлага хангаж байгаа болно.

Хүснэгт 9. Гүний худгийн усны макро болон микрохимийн шинжилгээний дүн, чанарын үзүүлэлт

Элемент нэгдэл	Хэмж их нэгж	Арга	Гүний худгийн цэгүүд									
			Мөрдөх стандарт	2025 оны 1-9 дүгээр сард хийсэн шинжилгээний дундаж дүн					2025 оны 1- 8 сарын дундаж дүн			
				MNS 0900:2018	Хяналтын дээж	MB1	MB2	MB3	MB4	MB5	UB_BR	TN_BR1
K ⁺	mg/L	ICP-25		1.5	2.3	2.4	2.2	2.4	2.7	2.13	1.61	1.44
Na ⁺	mg/L	ICP-25	200	8.4	20.2	20.4	18.4	19.3	32.4	24.17	9.08	8.56
Ca ²⁺	mg/L	ICP-25	100	27.3	59.3	58.7	52.4	58.4	61.3	48.06	40.68	42.25
Mg ²⁺	mg/L	ICP-25	30	6.5	18.8	17.8	16.0	17.7	21.4	18.49	10.43	10.39
Cl ⁻	mg/L	Titri-77	350	10.7	13.8	12.9	13.3	15.1	19.4	22.87	11.88	11.39
CO ₃ ²⁻	mg/L	Titri- 93		<1.5	13.5	7.5	7.5	9.0	7.5	3	<1.5	<1.5
HCO ₃ ⁻	mg/L	Titri - 94		110.7	302.8	293.0	266.7	287.1	317.7	199.6	163.25	180.25
TDS	mg/L	WA-102	1000	104.4	221.4	227.9	208.3	218.6	274.5	225.40	151.75	152.25
pH		WA-102	6.5-8.5	7.5	7.7	7.8	7.8	7.7	7.9	7.99	7.97	7.86
T ^o	°C	WA-104		21.6	23.3	21.6	21.7	21.7	21.4	20.96	21.52	21.80
CN-total	mg/L	SPhM-64	0.01	<0.002	<0.002	<0.002	<0.002	<0.002	<0.002	<0.002	<0.002	<0.002
CN-free	mg/L	SPhM-65		<0.002	<0.002	<0.002	<0.002	<0.002	<0.002	<0.002	<0.002	<0.002
CN-WAD	mg/L	SPhM-116		<0.05	<0.05	<0.05	<0.05	<0.05	<0.05	<0.05	<0.05	<0.05
Ag	mg/L	ICP-124	0.1	<0.05	<0.05	<0.05	<0.05	<0.05	<0.05	<0.05	<0.05	<0.05
Al	mg/L	ICP-124	0.5	<0.025	<0.025	<0.025	<0.025	<0.025	<0.025	<0.025	<0.025	<0.025
As	mg/L	ICP-124	0.01	<0.01	<0.01	<0.01	<0.01	<0.01	<0.01	<0.01	<0.01	<0.01
Ba	mg/L	ICP-124	0.7	<0.05	<0.05	<0.05	<0.05	<0.05	<0.05	<0.05	<0.05	<0.05
Cd	mg/L	ICP-124	0.003	<0.005	<0.005	<0.005	<0.005	<0.005	<0.005	<0.005	<0.005	<0.005
Co	mg/L	ICP-124		<0.01	<0.01	<0.01	<0.01	<0.01	<0.01	<0.01	<0.01	<0.01
Cr	mg/L	ICP-124	0.05	<0.02	<0.02	<0.02	<0.02	<0.02	<0.02	<0.02	<0.02	<0.02
Cu	mg/L	ICP-124	2	0.1	<0.01	<0.01	<0.01	<0.01	<0.01	<0.01	<0.01	<0.01
Fe	mg/L	ICP-25	0.3	<0.02	<0.02	<0.02	<0.02	<0.02	0.1	<0.02	<0.02	<0.02
Mn	mg/L	ICP-124	0.1	<0.01	<0.01	<0.01	<0.01	<0.01	<0.01	<0.01	<0.01	<0.01
Mo	mg/L	ICP-124	0.07	<0.03	<0.03	<0.03	<0.03	<0.03	<0.03	<0.03	<0.03	<0.03
Ni	mg/L	ICP-124	0.02	<0.01	0.0	<0.01	<0.01	0.0	<0.01	<0.01	0.01	<0.01
Pb	mg/L	ICP-124	0.01	<0.01	<0.01	<0.01	<0.01	<0.01	<0.01	<0.01	<0.01	<0.01
Zn	mg/L	ICP-124	5	0.2	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.12	0.01	0.01
Hg	µg/L	EPA-7473	0.001	<1	<1	<1	<1	<1	<1	<1	<1	<1
Cond	µS/m	WA-104		208.4	444.8	446.0	406.0	437.6	538.2	463.6	303.5	303.75

Гүний усыг бохирдлоос сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлсэн ажил

Улаанбулаг уурхайн ашиглалтын гурав дах жилээс уурхайн уланд хур тунадас болон хананаас шүүрсэн ус цугларч эхэлсэн бөгөөд уг шүүрлийн усыг итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэхэд зөвхөн байгалийн гаралтай хүнцлийн агууламж нь MNS 4586:2024 “Усан орчны чанар. Ерөнхий шаардлага” стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан үзүүлэлттэй байсан. **Хавсралт 24**-өөс итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний үр дүнг харна уу.

Энэ хуримтлагдсан усны чанарт сөрөг нөлөөлөл үзүүлэх аливаа үйл ажиллагааг Бороогоулд компанийн зүгээс явуулаагүй, дан байгалийн гаралтай хур тунадас болон ил уурхайн хананаас шүүрч бий болсон ус юм. Улаанбулаг уурхайн олборлолтын ажлыг хэвийн үргэлжлүүлэх зорилгоор ил уурхайн уланд хуримтлагдсан усыг хиймэл санд цуглуулж, шүүрлийн усны чанарыг сайжруулах, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор 2025 оны 7–10 дугаар сарын хугацаанд байгалийн цеолит ашиглан байгалийн гүнээс гарах усыг байгалийн процессоор цэвэршүүлэх туршилтыг амжилттай зохион байгуулсан. Туршилтыг олон улсын болон дотоодын туршилт судалгааг үндэслэн компанийн металлургийн баг хамт олон лабораторийн болон талбайн түвшинд амжилттай хийж гүйцэтгэсэн.




Зураг 93. Туршилтад ашигласан байгалийн цеолит

Байгалийн гаралтай цеолит нь бохирдуулагч бодис шингээх өндөр чадвартай тул ус цэвэршүүлэх, хорт бодис саармагжуулах зэрэг байгаль орчны чиглэлээр өргөн ашиглагддаг.



Зураг 94. Лабораторийн түвшний туршилтын явц

Бороо уурхайн лабораторит хийсэн туршилт нь үр дүнтэй байсан тул туршилтыг талбайн хэмжээнд дараах байдлаар Улаанбулаг уурхайн ус соруулан хадгалах сан руу орох цэг дээр 1м диаметртэй 9 тасалгаа бүхий төмөр хэвтээ шүүлтүүр хийн суурилуулж шүүрлийн усыг шүүлтүүрээр дамжуулан цэвэршүүлэх туршилтыг хийсэн.



Зураг 95. Талбайн түвшинд тохируулан хийсэн цеолиттой шүүлтүүр

Туршилтын үр дүнд усанд агуулагдах хүнцлийн агууламж мэдэгдэхүйц буурч, дээрх стандартад нийцсэн нь лабораторийн шинжилгээгээр баталгаажсан болно. Шинжилгээний хариуг **Хавсралт 38**-аас харна уу.



Зураг 96. Улаанбулаг уурхайн улны усыг цуглуулах сан болон цеолиттой шүүлтүүр

Энэхүү физик-биологийн арга нь усны байгалийн шинж чанарт сөрөг нөлөө үзүүлэхгүй тул Улаанбулаг уурхайн шүүрлийн усанд агуулагдах хүнцлийг бууруулах, усыг дахин ашиглах болон байгальд нийлүүлэхэд аюулгүй, үр дүнтэй арга болохыг баталж байна.

Иймд цэвэршүүлсэн шүүрлийн усыг уурхайн тоосжилтыг бууруулах, нөхөн сэргээлт, мод үржүүлэг, мод, ургамлын усалгаа хийх зориулалтаар ашиглах боломжтой юм.

Төв аймгийн Борнуур сумын БОХУБ ус цэвэршүүлэх туршилтын үйл явц, үр дүнг газар дээр хяналт тавьж ажилласан бөгөөд цэвэршүүлсэн усны чанар холбогдох MNS стандартын шаардлагыг хангаж байгаа талаар Байгаль орны хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гаргуулсан болно.

Гадаргын усны хяналт

Гадаргын усны хяналтыг дээр дурдсанчлан Бороо голын 3 цэг, Зуунмодны голын 1 цэгт гүйцэтгэсэн бөгөөд шинжилгээний үр дүнгээс үзэхэд “MNS 4586:2024 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага” стандартын дагуу буюу голын усанд мөнгөн ус, төмөр, хар тугалга, зэс гэх мэт хүнд метал, хортой бодис зөвшөөрөгдөх хэмжээнээс

доогуур буюу бохирдолгүй байгаа нь төслөөс үүдэлтэй сөрөг нөлөөлөл байхгүй гэдгийг харуулж байна.



Зураг 97. Гадаргын усны хээрийн хэмжилт, усны дээжлэлт


Хүснэгт 10. Гадаргын усны цэгт хийгдсэн лабораторийн макро болон микрохимийн шинжилгээний дүн, чанарын үзүүлэлт

Элемент нэгдэл	Хэмжих нэгж	Арга	Мөрдөх стандарт	2025 оны 5 болон 8 дугаар сард хийсэн шинжилгээний дундаж дүн			
			MNS 4586:2024	Гадаргын усны хяналтын цэгүүд			
				UR-Бороо голын дээд хэсэг	MR-Бороо голын дунд хэсэг	DR-Бороо голын доод хэсэг	ZMR-Зуун модны гол
K ⁺	мг/л	ICP-25		3.185	3.01	2.81	1.515
Na ⁺	мг/л	ICP-25		24.27	25.49	23.71	7.685
Ca ²⁺	мг/л	ICP-25	200	45.495	47.96	43.52	28.87
Mg ²⁺	мг/л	ICP-25	50	17.71	18.79	17.505	5.695
Cl ⁻	мг/л	Titri-77	50	16.01	18.005	16.22	8.49
CO ₃ ²⁻	мг/л	Titri- 93	3.1	<1.5	<1.5	<1.5	6
HCO ₃ ⁻	мг/л	Titri - 94	500	239.5	251.5	242.5	106.5
TDS	мг/л	WA-102		230	220.5	203.5	113
NO ₂	мг/л	Titri-77	0.12	0.0705	0.12	0.025	0.355
NO ₃	мг/л	Titri- 93	6	2.055	2.89	2.8	7.015
pH		WA-102	6.5-9	7.92	8.105	7.89	7.93
T ^o	°C	WA-104		21.8	21.85	22.3	23.15
CN-total	мг/л	SPhM-64		<0.002	<0.002	<0.002	<0.002
CN-free	мг/л	SPhM-65		<0.002	<0.002	<0.002	<0.002
CN-WAD	мг/л	SPhM-116		<0.05	<0.05	<0.05	<0.05
Ag	мг/л	ICP-124		<0.05	<0.05	<0.05	<0.05
Al	мг/л	ICP-124	75	<0.025	<0.025	<0.025	<0.025
As	мг/л	ICP-124	0.01	<0.01	<0.01	<0.01	<0.01
Ba	мг/л	ICP-124		<0.05	<0.05	<0.05	<0.05
Cd	мг/л	ICP-124	0.005	<0.005	<0.005	<0.005	<0.005
Co	мг/л	ICP-124	0.01	<0.01	<0.01	<0.01	<0.01
Cr	мг/л	ICP-124	0.05	<0.02	<0.02	<0.02	<0.02

Cu	мг/л	ICP-124	1	<0.01	<0.01	<0.01	<0.01
Fe	мг/л	ICP-25	5	0.04	0.04	0.04	0.04
Mn	мг/л	ICP-124	1	<0.01	<0.01	<0.01	<0.01
Mo	мг/л	ICP-124	0.25	<0.03	<0.03	<0.03	<0.03
Ni	мг/л	ICP-124	0.08	<0.01	<0.01	<0.01	<0.01
Pb	мг/л	ICP-124	0.05	<0.01	<0.01	<0.01	<0.01
Zn	мг/л	ICP-124	1	<0.03	<0.03	<0.03	<0.01
Hg	мкг/л	EPA-7473	1	<0.01	<0.01	<0.01	<0.01
Cond	µS/cm	WA-104		450	442	407	226

10.2. Хөрсний хяналт шинжилгээ

Хөрсний чанарын хяналт, шинжилгээний цэгүүдийг тогтоохдоо уурхайн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийн орон зайн тархалтыг үндэслэн олборлолтын талбайн 3 талд, шимт хөрсний овоолго/эрүүл хөрснөөс 1 цэг сонгож тус бүр 1 дээжийг авч орчны хяналт шинжилгээний удирдамжийн дагуу төслийн үйл ажиллагаанаас тухайн газар нутгийн хөрсөнд сөрөг нөлөөлөл учруулж буй эсэхэд хяналт тавих, шинжилгээ хийх зорилгоор хөрсний чанар, хүнд металл, бохирдлын судалгаа, дээжлэлтийг 5 болон 8 дугаар саруудад хийж гүйцэтгэв. Эдгээр цэгүүдээс цуглуулсан хөрсний дээжүүдийг стандартын дагуу савлан, хаяглаж, дээжийн бичгийг үйлдэн Геологийн Төв лаборатори болон Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн хөрс судлалын лабораторид шинжлүүлж, шинжилгээний үр дүнг нэгтгэн мэдээллийн сан үүсгэн холбогдох стандарттай харьцуулан дүгнэлт хийж ажиллалаа.



Зураг 98. Улаанбулаг төслийн хөрсний чанарын хяналт шинжилгээний цэгүүд

Хүснэгт 11. Хөрсний чанарын хяналт шинжилгээний цэгүүдийн тодорхойлолт

№	Цэгийн дугаар	Цэгийн байршил	Координат	Дээж авсан газрын тодорхойлолт
1	Soil#1	Засварын байр	48 U 0597408 UTM 5391477	1, 2, 3-р цэг буюу үйл ажиллагааны нөлөөлөлд өртөөгүй талбай 0-20см гүнээс дээж авсан. TPS#1,2 шимт хөрсний овоолго.
2	Soil#2	Хүдэр тээврийн зам	48 U 0596610 UTM 5393829	
3	Soil#3	Оффисын байр	48 U 059258 UTM 5391271	
4	TPS#1	Шимт хөрсний овоолго	48 U 0597135 UTM 5390818	
5	TPS#2	Эрүүл талбай	48 U 0596284 UTM 5390954	



Зураг 99. Хөрсний чанарын хяналт шинжилгээний дээжлэлт

Шинжилгээний үр дүн:

Байгалийн нөхцөл, улирлын болон байгаль-цаг уурын хэлбэлзэл, газрын гадаргын хэлбэр, тархалт, антропогенийн хүчин зүйлсийн нөлөөгөөр хөрсөн дэх элементийн шилжилт хөдөлгөөний идэвхжилт нь тогтвортой бус, динамик зүй тогтолтой байдаг. Үүний улмаас тухайн бүс нутагт илрэх хүнд металлын агууламж харилцан адилгүй хэлбэлздэг болох нь хяналт, шинжилгээний үр дүнгүүдээс харагдаж байдаг. Хөрсний хүнд металлын судалгааны хувьд 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу нийт 15 (CN total, pH, NO₃, Cl, Pb, Cr, SO₄, Cd, Ca, Mg, Na, Cu, Co, Ni, Fe) төрлийн элементийг 5, 9-р саруудад дээрх 5 цэгээс дээж авч шинжлүүлсэн. Хөрсний дээжийн лабораторийн шинжилгээг хийхдээ химийн шинжилгээний ICP-25 аргыг ашиглан тодорхойлсон.

Геологийн Төв лабораторийн шинжилгээний дүнгүүдээс үзэхэд уурхайн хөрсний хяналтын нийт цэгүүдээс авсан хөрсөнд агуулагдах хүнд металлын агууламж хүлцэх хэмжээнээс доогуур ба “MNS 5850-2019 Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ” стандартын дагуу байгалийн фоны хэмжээнд байгаа нь үйлдвэрлэлийн гаралтай хүнд металлын хөрсний бохирдолгүй буюу төслөөс үүдэлтэй сөрөг нөлөөлөл байхгүй гэдгийг илтгэж байна.

Хөрсөнд агуулагдах дээр дурдсан хүнд металлуудаас хром (Cr), зэс (Cu), хар тугалга (Pb), кадми (Cd) болон цианидын (CN) шинжилгээний үр дүнг “MNS5850-2019” стандартын хүлцэх хэмжээтэй /ЗДА/ харьцуулан хөрсний чанарт өгсөн үнэлгээний дүнг хүснэгтээр үзүүлэв. Хөрсний лабораторийн шинжилгээний дэлгэрэнгүй хариуг **Хавсралт 25** -аас үзнэ үү.

Хүснэгт 12. Хөрсөнд агуулагдах Хромын лабораторийн шинжилгээний дүн

№	Дээжийн н дугаар	Цэгийн нэр, байршил	2025 оны Cr, мг/кг	Cr, мг/кг 5-р сарын хариу	Cr, мг/кг 9-р сарын хариу	ХЧС	Хөрсний чанар
1	Soil#1	Засварын байр	62.3	58.25	66.54	150	Стандартын хэмжээнд
2	Soil#2	Хүдэр тээврийн зам	50.83	67.52	34.14	150	Стандартын хэмжээнд
3	Soil#3	Оффисын байр	72.72	65.67	79.78	150	Стандартын хэмжээнд

Тайлбар. ХЧС (Хөрсний чанарын стандарт) - "Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ" MNS 5850-2019 стандартын дагуу байна.

Хүснэгт 13. Хөрсөнд агуулагдах Зэсийн лабораторийн шинжилгээний дүн

№	Дээжийн дугаар	Цэгийн нэр, байршил	2025 оны Cu, мг/кг	Cu, мг/кг 5-р сарын хариу	Cu, мг/кг 9-р сарын хариу	ХЧС (ЗДА)	Хөрсний чанар
1	Soil#1	Засварын байр		17.34		100.0	Стандартын хэмжээнд
2	Soil#2	Хүдэр тээврийн зам		20.92		100.0	Стандартын хэмжээнд
3	Soil#3	Оффисын байр		12.65		100.0	Стандартын хэмжээнд

Тайлбар. ХЧС (Хөрсний чанарын стандарт) - "Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ" MNS 5850-2019 стандартын дагуу байна.

Хүснэгт 14. Хөрсөнд агуулагдах хар тугалгын лабораторийн шинжилгээний дүн

№	Дээжийн дугаар	Цэгийн нэр, байршил	2025 оны Pb, мг/кг	Pb, мг/кг 5-р сарын хариу	Pb, мг/кг 9-р сарын Хариу	ХЧС (ЗДА)	Хөрсний чанар
1	Soil#1	Засварын байр	23.27	20.92	25.63	100.0	Стандартын хэмжээнд
2	Soil#2	Хүдэр тээврийн зам	16.95	19.66	14.33	100.0	Стандартын хэмжээнд
3	Soil#3	Оффисын байр	23.13	19.63	26.64	100.0	Стандартын хэмжээнд

Тайлбар. ХЧС (Хөрсний чанарын стандарт) - "Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ" MNS 5850-2019 стандартын дагуу байна.

Хүснэгт 15. Хөрсөнд агуулагдах Кадмийн лабораторийн шинжилгээний дүн

№	Дээжийн дугаар	Цэгийн нэр, байршил	2025оны Cd мг/кг	Cd мг/кг 5-р сарын хариу	Cd мг/кг 9-р сарын хариу	ХЧС (ЗДА)	Хөрсний чанар
1	Soil#1	Засварын байр	0.20	0.19	0.22	3	Стандартын хэмжээнд
2	Soil#2	Хүдэр тээврийн зам	0.24	0.24	0.24	3	Стандартын хэмжээнд
3	Soil#3	Оффисын байр	0.22	0.21	0.24	3	Стандартын хэмжээнд

Тайлбар. ХЧС (Хөрсний чанарын стандарт) - "Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ" MNS 5850-2019 стандартын дагуу байна.

Хүснэгт 16. Хөрсөнд агуулагдах Цианидын лабораторийн шинжилгээний дүн

№	Дээжийн дугаар	Цэгийн нэр, байршил	2025оны CN, мг/кг	CN, мг/кг 5-р сарын	CN, мг/кг 9-р сарын	ХЧС (ЗДА)	Хөрсний чанар
---	----------------	---------------------	-------------------	---------------------	---------------------	-----------	---------------

				хариу	Хариу		
1	Soil#1	Засварын байр	<1.0	<1.0	<1.0	25.0	Стандартын хэмжээнд
2	Soil#2	Хүдэр тээврийн зам	<1.0	<1.0	<1.0	25.0	Стандартын хэмжээнд
3	Soil#3	Оффисын байр	<1.0	<1.0	<1.0	25.0	Стандартын хэмжээнд

Тайлбар. ХЧС (Хөрсний чанарын стандарт) - "Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ" MNS 5850-2019 стандартын дагуу байна.

Шимт хөрсний агрохимийн үзүүлэлтүүд: Хөрсөн дэх хүнд металлын шинжилгээнээс гадна уурхайн нөхөн сэргээлтийн чухал бүрэлдэхүүн хэсэг болсон шимт хөрсний нөөцийн овоолгоос 5 болон 9-р саруудад дээж авч хөрсний физик, хими, агрохимийн үзүүлэлтийг ШУА-ийн Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн Хөрс судлалын лабораторид өгч шинжлүүлсэн. **Хавсралт 26** -аас Хөрсний дээжийн агрохимийн шинжилгээг эзлэхүүний болон колориметрийн аргаар лабораторид тодорхойлсныг харна уу.

Хөрсний чанарын хяналт, шинжилгээний удирдамжийн дагуу шимт хөрсний нөөцийн овоолгод ялзмаг, урвалын орчин хөрсөнд агуулагдах агрохимийн нэгдлүүд болох аммони, сульфат, фосфор болон механик бүрэлдэхүүний агууламжийг тогтоосон дүн болон хүлцэх хэмжээтэй /ЗДА/ харьцуулан хөрсний чанарт өгсөн үнэлгээний дүнг доорх хүснэгтүүдээр харуулав.

Хүснэгт 17. Шимт хөрсний агрохимийн үзүүлэлтүүдийн шинжилгээний дундаж дүн

№	ХӨРСНИЙ ЗҮСЭЛТИЙН ДУГААР	ХӨРСНИЙ МЕХАНИК БҮРЭЛДЭХҮҮН					ХӨРСНИЙ ХИМИЙН ҮНДСЭН ШИНЖ						
		Чулуу, >2 мм(%)	Эзлэхүүн жин (гр/см3)	Ширхэгийн хэмжээ мм-ээр (%)			рН Н2О (1:5)	СаСО3 (%)	N-NO3 (мг/кг)	Ялзмаг (%)	ЕС 2.5 (dS/m)	Хөдөлгөөн т (Мг/100г)	
				Элс	Тоос (0.05-0.002 мм)	Шавар						P2O5	K2O
	MNS 5916:2008	8-21%	1.0-1.3				6.3-9.0			2.7-4.0			
1	TPS#1	10.5	1.36	40	48	12	9	1.96	1.96	2.218	0.287	2.85	32.6

Хүснэгт 18. Шимт хөрсний давсжилт болон хуурай үлдэгдлийн лабораторийн шинжилгээний дундаж дүн

№	ХӨРСНИЙ ЗҮСЭЛТИЙН ДУГААР	ХӨРСНИЙ ДАВСЖИЛТ									
		Хуурай үлдэгдэл (%)	Cl ⁻	SO4 2-	Ca 2+	Mg 2+	Na+	K+	Шүлтлэг		
									СО3 2-	НСО3-	
			мг-экв/100гр								
1	TPS#1	0.065	0.18	0.14	1.30	0.35	1.15	0.02	0.00	1.50	

Хөрсний механик бүрэлдэхүүн: Шинжилгээний үр дүнгээр шимт хөрсний овоолго нь хөнгөн шавранцар бүрэлдэхүүнтэй болох нь харагдаж байна. Ийм хөрс нь бүтэц сайн, ус нэвтрүүлэх чадвар сайн, ус даах чадвар өндөр байдаг.

Хөрсний урвалын орчин рН: Хөрсөн дэх устөрөгчийн ионы хэмжээг илэрхийлдэг үзүүлэлт юм. Энэ нь тухайн хөрс хэр зэрэг хүчиллэг, шүлтлэг байгааг илэрхийлдэг. Шимт хөрс нь 9 буюу шүлтлэг урвалын орчинтой байна. Ийм орчинд төмөр боловсруулах бактериуд үүсэн төмрийг шингээн түүний уусдаггүй нэгдлүүдийг үүсгэдэг. Ингэснээр хөрсний гадаргуугийн нэгэн жигд биш байдал эвдэгдэж улмаар хөрсний зэврэх чанарыг нэмэгдүүлнэ. Мөн хөрс ийм рН утгатай үед шаардлагатай хэмжээний фосфатыг шингээж чадна.


Хөрсний цахилгаан дамжуулах чанар: Утга нь 10-аас бага байгаа нь давсжилтгүй болохыг баталж байна.

Хөрсөнд агуулагдах карбонатын агууламж: Шимт хөрс нь бага зэргийн карбонатлаг хэмжээнд байна. Карбонатын үзүүлэлтээс ион солилцох катионууд, уусмалын рН, хөдөлгөөнт химийн элементүүдийн агууламж, хөрсний үржил шим, ус даах чадвар зэрэг үзүүлэлтүүд хамаарна.

Ялзмаг агууламж: Ялзмаг нь усыг шингээж, чийгийг хадгалан ургамал ургахад зайлшгүй шаардлагатай эх үүсвэрээр хангаж байдаг. Дээжний ялзмагийн үзүүлэлт нь 2.2 % буюу дундаж агууламжтай гарсан байна. Шим тэжээлийн бодис хөдөлгөөнт фосфор нь хөрсөнд P_2O_5 хэлбэрээр 0.02%-иас багагүй байх ёстой бөгөөд дээжинд 2.85 буюу дунд зэрэг агууламжтай байна. Харин хөдөлгөөнт Калий нь K_2O хэлбэрээр хөрсөнд 57-60% -с багагүй агууламжтай байх ёстой дээжинд K_2O агууламж 32,6% хангалттай хэмжээнд гарсан нь тус хөрсөнд ямар нэгэн бордоо шаардлагагүйг харуулж байна. Шинжилгээний үзүүлэлтийг **хавсралт 26** -аас харна уу,

10.3. Агаарын хяналт шинжилгээ

Агаарын чанарын хяналт шинжилгээний ажлыг сөрөг нөлөөлөл үүсгэж болохуйц ажлын талбаруудаас хамаарч агаарын чанарын нийт 6 цэгт орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн удирдамжийн дагуу агаар дахь хүхэрлэг хий (SO_2), азотын давхар исэл (NO_2), метаны хий (CH_4), нүүрстөрөгчийн хий (CO), циант устөрөгчийн хий (HCN), аммиак (NH_3), хүчилтөрөгч (O_2) зэрэг 7 төрлийн элементүүдийг 2025 оны 01 сарын 06-наас 2025 оны 10 сарын 13-ийг хүртэлх хугацаанд нийт 41 удаагийн хэмжилтийг төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хийлээ.



Зураг 100. Улаанбулагийн төслийн агаарын чанарын хяналт шинжилгээний цэгүүд

Агаарын чанарын хяналт, шинжилгээ хийгдсэн цэгүүдийн тодорхойлолтыг дараах байдлаар хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 19. Агаарын чанарын хяналт шинжилгээний цэгийн тодорхойлолт

№	Цэгийн дугаар	Цэгийн байршил	Координат	Хэмжилт хийсэн газрын тодорхойлолт
1	AQ#1	Төслийн талбайн хойд талд	N48° 40'08.39" E106° 19'22.27"	Ил уурхайн хойд хэсэгт
2	AQ#2	Төслийн талбайн зүүн хойд талд	N48° 39'58.39" E106° 20'02.27"	Ил уурхайн зүүн талд
3	AQ#3	Төслийн талбайн урд талд	N48° 39'10.65" E106° 19'41.62"	Шимт хөрсний овоолгын урд
4	AQ#4	Төслийн талбайн баруун талд	N48°39'39.86" E106°18'24.78"	Баруун талын шимт хөрсний овоолгын урд
5	AQ#5	Төслийн талбайн зүүн урд талд	N48°39'30.80" E106°19'27.63"	Уурхайн урд хэсэгт хамгаалалтын хашааны гадна
6	AQ#6	Төслийн талбайн зүүн урд талд	N48°39'55.12" E106°19'47.12"	Хамгаалалтын 72-р постны дэргэд уурхайн хашааны гадна

Агаар дахь хийн хольцын агууламжийг тодорхойлохдоо Герман улсад үйлдвэрлэсэн “Draeger Ham 5000” хэмээх гар зөөврийн багажийг ашиглан хэмжилтийг гүйцэтгэсэн. Уг багажийг ашиглан хэмжилтийн цэгт очиж, багажийг ажиллуулсны дараа тоон үзүүлэлтүүд тогтворжихыг хүлээнэ. Уг төхөөрөмж орчны агаарыг соруулж, 7

төрлийн хийн мэдрэгчүүдэд мэдрэгдсэн агаарт агуулагдаж буй хийн найрлагыг тогтооно. Жил бүр хэмжилтийн багажийн техник, багаж хэмжилзүйн тохиргоог PSC ХХК-иар хийлгэж гэрчилгээжүүлдэг бөгөөд баталгаажуулалтын гэрчилгээний хуулбарыг **Хавсралт 1** -ээс үзнэ үү. Мөн хэмжилтийн дэлгэрэнгүй үр дүнг **Хавсралт 27** - оос харна уу.



Зураг 101. Агаарын хийн болон тоосонцрын хэмжилтүүд

Агаарын чанарын хяналт шинжилгээний удирдамжийн дагуу тогтоосон цэгүүдийн агаарт агуулагдах SO₂, NO₂, CO, HCN хийн найрлагыг хүлцэх хэмжээнд харьцуулан үнэлж, доорх хүснэгтүүдэд харууллаа.

Хүснэгт 20. Хүхэрлэг хийн агууламжид хийгдсэн хээрийн хэмжилтийн дүн (SO₂)

№	Сорьц авсан цэг		Сорьц авсан өдөр	SO ₂ , мкг/м ³ / жилийн дундаж үзүүлэлт/	АЧС (ЗДА) жилийн дундаж	Агаарын чанар
	Дээжийн дугаар	Цэгийн байршил нэр,				
1	AQ#1	Төслийн талбайн хойд талд	2025 оны 01 сарын 02-наас 2025 оны 10 сарын 13 хүртэлх хугацаанд нийт 41 удаагийн хэмжилт хийсэн	илрээгүй	20	Стандартын хэмжээнд
2	AQ#2	Төслийн талбайн зүүн хойд талд		илрээгүй	20	стандартын хэмжээнд
3	AQ#3	Төслийн талбайн урд талд		илрээгүй	20	стандартын хэмжээнд
4	AQ#4	Төслийн талбайн баруун талд		илрээгүй	20	стандартын хэмжээнд
5	AQ#5	Төслийн талбайн зүүн урд талд		илрээгүй	20	стандартын хэмжээнд
6	AQ#6	Төслийн талбайн зүүн урд талд		илрээгүй	20	стандартын хэмжээнд

Тайлбар. АЧС - MNS 4585:2025 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага

Хүснэгт 21. Азотын давхар ислийн агууламжид хийгдсэн хээрийн хэмжилтийн дүн (NO₂)

№	Сорьц авсан цэг		Сорьц авсан өдөр	NO ₂ , мкг/м ³ / жилийн дундаж үзүүлэлт/	АЧС (ЗДА) жилийн дундаж	Агаарын чанар
	Дээжийн дугаар	Цэгийн нэр, байршил				
1	AQ#1	Төслийн талбайн хойд талд	2025 оны 01 сарын 05-наас 2025 оны 10 сарын 13 хүртэлх хугацаанд нийт 41 удаагийн хэмжилт хийсэн	0.27	30	стандартын хэмжээнд
2	AQ#2	Төслийн талбайн зүүн хойд талд		0.225	30	стандартын хэмжээнд
3	AQ#3	Төслийн талбайн урд талд		0.19	30	стандартын хэмжээнд
4	AQ#4	Төслийн талбайн баруун талд		0.18	30	стандартын хэмжээнд
5	AQ#5	Төслийн талбайн зүүн урд талд		0.14	30	стандартын хэмжээнд
6	AQ#6	Төслийн талбайн зүүн урд талд		0.20	30	стандартын хэмжээнд

Тайлбар. АЧС - MNS 4585:2025 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
Хүснэгт 22. Нүүрстөрөгчийн хийн агууламжид хийгдсэн хээрийн хэмжилтийн дүн, бохирдлын түвшин (CO)

№	Сорьц авсан цэг		Сорьц авсан өдөр	CO, мкг/м ³ / жилийн дундаж үзүүлэлт/	АЧС (ЗДА) 8 цагийн дундаж	Агаарын чанар
	Дээжийн дугаар	Цэгийн нэр, байршил				
1	AQ#1	Төслийн талбайн хойд талд	2025 оны 01 сарын 03-наас 2025 оны 10 сарын 13 хүртэлх хугацаанд нийт 41 удаагийн хэмжилт хийсэн	илрээгүй	4000	стандартын хэмжээнд
2	AQ#2	Төслийн талбайн зүүн хойд талд		илрээгүй	4000	стандартын хэмжээнд
3	AQ#3	Төслийн талбайн урд талд		илрээгүй	4000	стандартын хэмжээнд
4	AQ#4	Төслийн талбайн баруун талд		илрээгүй	4000	стандартын хэмжээнд
5	AQ#5	Төслийн талбайн зүүн урд талд		илрээгүй	4000	стандартын хэмжээнд
6	AQ#6	Төслийн талбайн зүүн урд талд		илрээгүй	4000	стандартын хэмжээнд

Тайлбар. АЧС - MNS 4585:2025 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага

Хүснэгт 23. Циант устөрөгчийн хийн агууламжид хийгдсэн хээрийн хэмжилтийн дүн, бохирдлын түвшин (HCN)

№	Сорьц авсан цэг		Сорьц авсан өдөр	HCN, мкг/м ³ / жилийн дундаж үзүүлэлт/	АЧС (ЗДА) жилийн дундаж (ppm)	Агаарын чанар
	Дээжийн дугаар	Цэгийн байршил нэр,				
1	AQ#1	Төслийн талбайн хойд талд	2025 оны 01 сарын 03-наас 2025 оны 10 сарын 13 хүртэлх хугацаанд нийт 41 удаагийн хэмжилт хийсэн	илрээгүй	4.7	стандартын хэмжээнд
2	AQ#2	Төслийн талбайн зүүн хойд талд		илрээгүй	4.7	стандартын хэмжээнд
3	AQ#3	Төслийн талбайн урд талд		илрээгүй	4.7	стандартын хэмжээнд
4	AQ#4	Төслийн талбайн баруун талд		илрээгүй	4.7	стандартын хэмжээнд
5	AQ#5	Төслийн талбайн зүүн урд талд		илрээгүй	4.7	стандартын хэмжээнд
6	AQ#6	Төслийн талбайн зүүн урд талд		илрээгүй	4.7	стандартын хэмжээнд

Тайлбар. АЧС - MNS 4585:2025 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага

Дээрх хүснэгтүүдээс харахад хүхэрлэг хий, азотын давхар исэл, нүүрстөрөгчийн хий, циант устөрөгчийн хийнүүд илрээгүй гэсэн үзүүлэлттэй гарсан байна. Энэ нь тухайн төслийн талбай уурхайн үйл ажиллагааны хүчин чадалтай бага агаарын бохирдол үүсгэх эх үүсвэр бага байгаатай холбоотой юм.

Мөн агаарын чанарын хэмжилт хийгдсэн бүх цэгүүдэд метаны хий (CH₄), нүүрстөрөгчийн хий (CO), амиак (NH₃) илрээгүй бөгөөд хүчилтөрөгч (O₂) нь “MNS 4585:2025” стандартын дагуу хэвийн хэмжээнд байна.

10.4. Агаарын тоосонцор

Төслийн үйл ажиллагаанаас үүсэлтэй агаарын тоосонцрыг уурхайн талбайд 6 цэгт, тээврийн замын трассын дагуу 14 цэгт 7 хоногийн давтамжтай, хийж гүйцэтгэн үр дүнг “**MNS 4585:2025 Агаарын чанар, техникийн ерөнхий шаардлага**” стандарттай харьцуулан нийт тоосонцрын тархалтыг зураглалаа.



Зураг 102. Хүдэр тээврийн замын агаарын тоосны хэмжилт

2025.01 cap							2025.02 cap						
ХЭМЖЛХ ЦЭГ	PM2.5	PM10	Total	MNS 4585:2025 PM2.5	MNS 4585:2025 PM10	MNS 4585:2025 Нийт тоос	ХЭМЖЛХ ЦЭГ	PM2.5	PM10	Total	MNS 4585:2025 PM2.5	MNS 4585:2025 PM10	MNS 4585:2025 Нийт тоос
DMP-1	20.50	49.50	92.50	37.5	100	500	DMP-1	28.25	59.25	184.75	37.5	100	500
DMP-2	22.00	55.00	94.50	37.5	100	500	DMP-2	34.75	66.75	175.50	37.5	100	500
DMP-3	30.00	58.50	128.50	37.5	100	500	DMP-3	24.25	46.25	171.50	37.5	100	500
DMP-4	24.00	53.00	97.00	37.5	100	500	DMP-4	26.25	52.00	126.50	37.5	100	500
DMP-5	37.00	70.00	121.00	37.5	100	500	DMP-5	24.00	52.25	125.75	37.5	100	500
DMP-6	27.00	53.00	95.00	37.5	100	500	DMP-6	21.50	47.00	78.50	37.5	100	500
DMP-7	39.00	58.00	121.00	37.5	100	500	DMP-7	25.00	48.75	77.50	37.5	100	500
DMP-8	28.00	55.00	78.50	37.5	100	500	DMP-8	20.00	43.50	101.00	37.5	100	500
DMP-9	27.00	52.50	69.00	37.5	100	500	DMP-9	23.75	63.50	114.00	37.5	100	500
DMP-10	27.50	55.50	83.50	37.5	100	500	DMP-10	21.50	52.00	86.75	37.5	100	500
DMP-11	22.00	36.50	70.00	37.5	100	500	DMP-11	22.75	45.50	74.25	37.5	100	500
DMP-12	30.00	43.00	120.00	37.5	100	500	DMP-12	19.75	41.75	73.50	37.5	100	500
DMP-13	22.50	41.00	57.50	37.5	100	500	DMP-13	17.67	46.18	81.98	37.5	100	500
DMP-14	19.50	38.00	72.50	37.5	100	500	DMP-14	17.85	46.70	74.64	37.5	100	500
AQ-1	29.5	53.3	105.0	37.5	100	500	AQ-1	30.8	49.5	114.5	37.5	100	500
AQ-2	19.8	41.0	80.3	37.5	100	500	AQ-2	26.8	50.8	114.5	37.5	100	500
AQ-3	18.5	43.5	99.0	37.5	100	500	AQ-3	25.3	43.5	108.0	37.5	100	500
AQ-4	27.0	52.8	72.8	37.5	100	500	AQ-4	24.0	45.5	56.5	37.5	100	500
AQ-5	33.8	40.5	69.5	37.5	100	500	AQ-5	19.0	45.8	76.0	37.5	100	500
AQ-6	80.5	151.8	289.5	37.5	100	500	AQ-6	20.3	39.0	78.8	37.5	100	500

2025.03 cap							2025.04 cap						
ХЭМЖЛХ ЦЭГ	PM2.5	PM10	Total	MNS 4585:2025 PM2.5	MNS 4585:2025 PM10	MNS 4585:2025 Нийт тоос	ХЭМЖЛХ ЦЭГ	PM2.5	PM10	Total	MNS 4585:2025 PM2.5	MNS 4585:2025 PM10	MNS 4585:2025 Нийт тоос
DMP-1	41.6	92.7	205.7	37.5	100	500	DMP-1	23.66	43.89	85.26	37.5	100	500
DMP-2	29.4	46.1	172.1	37.5	100	500	DMP-2	172.00	70.36	97.53	37.5	100	500
DMP-3	34.1	63.5	221.8	37.5	100	500	DMP-3	19.98	51.89	102.41	37.5	100	500
DMP-4	31.2	55.1	177.7	37.5	100	500	DMP-4	22.09	36.73	57.11	37.5	100	500
DMP-5	32.7	56.8	194.7	37.5	100	500	DMP-5	20.89	50.20	98.78	37.5	100	500
DMP-6	89.8	190.7	317.5	37.5	100	500	DMP-6	27.16	36.47	82.66	37.5	100	500
DMP-7	41.7	124.2	244.8	37.5	100	500	DMP-7	16.00	30.75	99.50	37.5	100	500
DMP-8	36.2	110.2	204.6	37.5	100	500	DMP-8	21.69	52.84	86.04	37.5	100	500
DMP-9	29.2	80.4	116.2	37.5	100	500	DMP-9	22.25	56.25	102.50	37.5	100	500
DMP-10	22.6	57.4	154.6	37.5	100	500	DMP-10	22.25	45.75	64.75	37.5	100	500
DMP-11	19.0	60.0	156.6	37.5	100	500	DMP-11	21.75	50.00	54.75	37.5	100	500
DMP-12	13.0	38.8	92.4	37.5	100	500	DMP-12	12.00	39.50	47.25	37.5	100	500
DMP-13	13.0	39.4	74.2	37.5	100	500	DMP-13	21.50	46.50	54.75	37.5	100	500
DMP-14	19.6	50.0	101.8	37.5	100	500	DMP-14	14.25	38.25	60.00	37.5	100	500
AQ-1	32	55	91	37.5	100	500	AQ-1	26.3	37.8	79.5	37.5	100	500
AQ-2	20	29	56	37.5	100	500	AQ-2	26.0	31.0	52.8	37.5	100	500
AQ-3	21	29	41	37.5	100	500	AQ-3	20.3	32.8	67.0	37.5	100	500
AQ-4	30	47	109	37.5	100	500	AQ-4	28.0	50.0	84.8	37.5	100	500
AQ-5	31	44	154	37.5	100	500	AQ-5	26.3	35.5	69.3	37.5	100	500
AQ-6	23	30	99	37.5	100	500	AQ-6	21.5	41.8	61.3	37.5	100	500

2025.05 cap						
ХЭМЖИХ ЦЭГ	PM2.5	PM10	Total	MNS 4585:2025 PM2.5	MNS 4585:2025 PM10	MNS 4585:2025 Нийт тоос
DMP-1	18.80	43.00	100.00	37.5	100	500
DMP-2	21.60	48.20	99.60	37.5	100	500
DMP-3	22.00	40.00	65.60	37.5	100	500
DMP-4	18.80	48.40	74.20	37.5	100	500
DMP-5	25.00	60.40	109.80	37.5	100	500
DMP-6	29.00	62.60	157.60	37.5	100	500
DMP-7	30.80	74.20	141.40	37.5	100	500
DMP-8	19.80	55.40	103.60	37.5	100	500
DMP-9	23.00	48.20	84.20	37.5	100	500
DMP-10	19.40	54.40	82.60	37.5	100	500
DMP-11	23.12	61.92	160.78	37.5	100	500
DMP-12	18.81	43.86	81.54	37.5	100	500
DMP-13	21.50	51.10	116.19	37.5	100	500
DMP-14	27.67	69.05	132.61	37.5	100	500
AQ-1	21.9	38.3	79.8	37.5	100	500
AQ-2	23.8	40.3	60.8	37.5	100	500
AQ-3	15.4	40.8	65.0	37.5	100	500
AQ-4	30.3	78.6	146.0	37.5	100	500
AQ-5	26.4	57.3	105.9	37.5	100	500
AQ-6	18.0	49.9	67.7	37.5	100	500


2025.06 cap						
ХЭМЖИХ ЦЭГ	PM2.5	PM10	Total	MNS 4585:2025 PM2.5	MNS 4585:2025 PM10	MNS 4585:2025 Нийт тоос
DMP-1	19.75	35.25	99.50	37.5	100	500
DMP-2	21.75	78.75	213.75	37.5	100	500
DMP-3	23.30	45.38	135.70	37.5	100	500
DMP-4	20.50	75.75	98.25	37.5	100	500
DMP-5	21.50	70.00	137.50	37.5	100	500
DMP-6	35.50	63.50	260.00	37.5	100	500
DMP-7	19.50	67.25	225.75	37.5	100	500
DMP-8	26.00	70.50	154.75	37.5	100	500
DMP-9	26.75	67.75	223.75	37.5	100	500
DMP-10	23.50	50.50	327.50	37.5	100	500
DMP-11	21.75	36.25	87.75	37.5	100	500
DMP-12	25.75	64.00	266.00	37.5	100	500
DMP-13	32.50	80.50	297.50	37.5	100	500
DMP-14	29.00	79.00	320.25	37.5	100	500
AQ-1	23.0	47.5	111.3	37.5	100	500
AQ-2	14.8	24.5	58.5	37.5	100	500
AQ-3	20.7	23.7	64.2	37.5	100	500
AQ-4	18.0	23.6	53.2	37.5	100	500
AQ-5	16.3	30.5	67.3	37.5	100	500
AQ-6	15.0	22.0	103.0	37.5	100	500

2025.07 cap						
ХЭМЖИХ ЦЭГ	PM2.5	PM10	Total	MNS 4585:2025 PM2.5	MNS 4585:2025 PM10	MNS 4585:2025 Нийт тоос
DMP-1	25.46	38.35	90.88	37.5	100	500
DMP-2	33.31	55.88	86.13	37.5	100	500
DMP-3	29.91	51.26	74.73	37.5	100	500
DMP-4	23.25	59.00	83.25	37.5	100	500
DMP-5	32.25	61.50	84.75	37.5	100	500
DMP-6	20.00	53.50	61.25	37.5	100	500
DMP-7	20.25	31.50	42.50	37.5	100	500
DMP-8	18.00	32.25	54.75	37.5	100	500
DMP-9	33.00	52.50	45.00	37.5	100	500
DMP-10	27.56	47.14	77.15	37.5	100	500
DMP-11	22.25	45.75	74.00	37.5	100	500
DMP-12	22.50	39.50	74.75	37.5	100	500
DMP-13	23.75	39.50	68.00	37.5	100	500
DMP-14	19.25	45.25	62.25	37.5	100	500
AQ-1	21.2	44.0	64.4	37.5	100	500
AQ-2	16.6	38.8	69.4	37.5	100	500
AQ-3	15.3	39.9	75.8	37.5	100	500
AQ-4	24.7	41.1	54.8	37.5	100	500
AQ-5	24.5	35.0	68.7	37.5	100	500
AQ-6	18.4	39.6	63.4	37.5	100	500

2025.08 cap						
ХЭМЖИХ ЦЭГ	PM2.5	PM10	Total	MNS 4585:2025 PM2.5	MNS 4585:2025 PM10	MNS 4585:2025 Нийт тоос
DMP-1	11.75	24.00	38.50	37.5	100	500
DMP-2	13.42	28.68	60.23	37.5	100	500
DMP-3	13.60	35.45	60.14	37.5	100	500
DMP-4	16.25	39.25	59.25	37.5	100	500
DMP-5	14.50	33.50	44.75	37.5	100	500
DMP-6	15.75	38.50	64.50	37.5	100	500
DMP-7	8.50	16.00	22.50	37.5	100	500
DMP-8				37.5	100	500
DMP-9	16.25	32.50	52.50	37.5	100	500
DMP-10	13.50	31.25	43.25	37.5	100	500
DMP-11	11.75	30.75	56.25	37.5	100	500
DMP-12	14.25	29.25	47.75	37.5	100	500
DMP-13	15.75	28.00	48.75	37.5	100	500
DMP-14	13.85	24.70	46.64	37.5	100	500
AQ-1	10.5	15.3	27.0	37.5	100	500
AQ-2	14.0	29.5	50.5	37.5	100	500
AQ-3	23.8	37.3	66.3	37.5	100	500
AQ-4	19.4	22.8	134.8	37.5	100	500
AQ-5	16.2	28.7	54.0	37.5	100	500
AQ-6	17.2	25.2	87.8	37.5	100	500

2025.09 сар							2025.10 сар						
ХЭМЖЛХ ЦЭГ	PM2.5	PM10	Total	MNS 4585:2025 PM2.5	MNS 4585:2025 PM10	MNS 4585:2025 Нийт тоос	ХЭМЖЛХ ЦЭГ	PM2.5	PM10	Total	MNS 4585:2025 PM2.5	MNS 4585:2025 PM10	MNS 4585:2025 Нийт тоос
DMP-1	24.25	38.00	69.25	37.5	100	500	DMP-1	16.00	24.33	38.67	37.5	100	500
DMP-2	14.25	25.00	43.75	37.5	100	500	DMP-2	22.13	41.94	110.51	37.5	100	500
DMP-3	17.75	27.25	45.75	37.5	100	500	DMP-3	27.65	61.21	116.42	37.5	100	500
DMP-4	18.19	29.15	75.02	37.5	100	500	DMP-4	20.00	53.00	85.33	37.5	100	500
DMP-5	23.50	22.50	206.75	37.5	100	500	DMP-5	20.00	42.67	65.00	37.5	100	500
DMP-6	17.75	39.00	81.25	37.5	100	500	DMP-6	16.00	38.67	109.33	37.5	100	500
DMP-7	0.00	0.00	0.00	37.5	100	500	DMP-7	0.00	0.00	0.00	37.5	100	500
DMP-8	0.00	0.00	0.00	37.5	100	500	DMP-8	0.00	0.00	0.00	37.5	100	500
DMP-9	20.75	29.75	74.00	37.5	100	500	DMP-9	15.33	28.67	63.00	37.5	100	500
DMP-10	23.75	35.75	61.25	37.5	100	500	DMP-10	20.33	31.67	66.33	37.5	100	500
DMP-11	14.00	26.25	46.50	37.5	100	500	DMP-11	19.33	38.00	67.33	37.5	100	500
DMP-12	14.25	32.50	46.50	37.5	100	500	DMP-12	23.67	43.00	71.67	37.5	100	500
DMP-13	14.00	43.50	67.25	37.5	100	500	DMP-13	21.67	39.67	179.00	37.5	100	500
DMP-14	16.00	34.00	69.75	37.5	100	500	DMP-14	18.33	28.67	74.00	37.5	100	500
AQ-1	23.3	37.0	67.8	37.5	100	500	AQ-1	14.7	35.0	82.0	37.5	100	500
AQ-2	15.0	22.5	33.8	37.5	100	500	AQ-2	16.0	20.0	39.3	37.5	100	500
AQ-3	20.3	27.0	45.0	37.5	100	500	AQ-3	17.0	24.3	44.7	37.5	100	500
AQ-4	25.8	34.3	53.3	37.5	100	500	AQ-4	13.7	19.7	31.0	37.5	100	500
AQ-5	18.5	25.3	38.0	37.5	100	500	AQ-5	16.3	24.0	57.7	37.5	100	500
AQ-6	21.5	31.5	53.8	37.5	100	500	AQ-6	21.3	38.3	75.3	37.5	100	500


Зураг 103. 2025 оны 1-10 сарын агаарын тоосны хэмжилтийн үр дүн





Зураг 104. 2025 оны 1-10-р сарын агаарын тоосны хэмжилт

PM2.5, PM10, TSP тоосонцорын хэмжилтийн үр дүнг “MNS 4585:2025 Агаарын чанар, техникийн ерөнхий шаардлага” стандартын шаардлагын зөвшөөрөгдөх хэмжээтэй харьцуулахад хүлцэх агууламжаас хэтэрсэн үзүүлэлт байхгүй буюу үйл ажиллагаанаас үүсэлтэй агаарын тоосонцорын бохирдол үүсээгүй байна.




Зураг 105. Төслийн талбай орчмын агаарын тоосны тархалт

2025 оны 1-р сараас 10-р сарын хооронд хүдэр тээврийн зам дагуу тогтоосон 14, уурхайн талбай орчим тогтоосон 6 цэгүүдэд 7 хоногийн давтамжтай хэмжсэн нийт тоосны хэмжилтийн мэдээг ашиглан төслийн талбай орчмын тоосны тархалтыг зураглалаа. Төслийн талбай орчмын тогтоосон цэгүүдэд хэмжигдсэн нийт тоосонцорын хамгийн бага утга 2 мкг/м³, хамгийн их утга 327 мкг/м³ буюу “MNS 4585:2025 Агаарын чанар, техникийн ерөнхий шаардлага” стандартад заасан хүлцэх хэмжээнээс хэд дахин бага байна. Тоосонцрын ялгарал үүсгэж буй цэгүүд үйл ажиллагаа явагдаж буй хэсэг болон тээврийн замын трассын дагуу байх ба тархалт нь үйл ажиллагааны эрчим, салхины чиглэл, гадаргын рельеф зэргээс хамаарах бөгөөд тоосны агууламж нь маш бага хэмжээнд байна.

10.5. Дуу шуугианы хэмжилт

Тэсэлгээний үйл ажиллагааг явуулахдаа агаарын дэлбэрэлт, чичиргээний талаарх үндэсний болон олон улсын стандартын дагуу өдрийн цагаар хийж гүйцэтгэдэг. Тэсэлгээ болон техникүүдээс үүсэх дуу чимээг тайлант хугацаанд хүдэр тээврийн зам-1, 2, ил уурхай орчим, оффис орчмын талбай гэсэн 4 цэгт “Sound Level metr” багаж ашиглан 7 хоногийн давтамжтай 41 удаагийн хэмжилт гүйцэтгэж мэдээллийн сан үүсгэн бүртгэсэн. Хэмжилтийн нийт жилийн дундаж үр дүн хамгийн багадаа 31 Дб, хамгийн ихдээ 59,7 Дб байгаа нь MNS 6768:2019 “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй. Ажлын байран дахь шуугианы өртөлтийн хэмжилт, зөвшөөрөх дээд хэмжээ, ажилтны сонсгол хамгаалахад тавих ерөнхий шаардлага”, MNS4585:2025 “Агаарын чанар Техникийн ерөнхий шаардлага” стандартуудад заасан хүлцэх хэмжээнээс бага байна.



Зураг 106. 2025 оны 1-10 сарын дуу шуугианы хэмжилтийн үр дүн

10.6. Ажлын байрны эрүүл ахуйн үзүүлэлт

Улаанбулагийн уурхайн талбайд ОХШХ-ийн дагуу жилд 1 удаа ил уурхай, уулын техник ажиллаж буй талбайд ажлын байрны эрүүл ахуйн үзүүлэлтүүдийг шуугиан, дулаан хэмжигч, гэрэлтүүлэг зэрэг параметруудээр хэмжилтийг Аюулгүй ажиллагааны хэлтэс тогтмол хийж гүйцэтгэдэг.

2025 оны 09 сарын 08-12-ны өдөр NL 20- шуугиан хэмжигч багаж, дулааныг TESTO 610, гэрэлтүүлгийг TESTO 600 багажаар тус тус хэмжсэн. Хэмжилтийн үр дүнг MNS 5002:2000 шуугианы норм, MNS 4990:2015 агаарын хорт бодисын ЗДХ, MNS 4996:2015 Гэрэлтүүлэг гэсэн стандарттай харьцуулан дүгнэхэд ЗДХ-ээс даваагүй, хэвийн үзүүлэлттэй байна. **Хавсралт 28** -аас Эрүүл ахуйн хэмжилтийн үр дүнг харна уу.




Зураг 107. Дуу шуугианы болон агаарын хэмийн хэмжилт хийж буй байдал

10.7. Ургамалан нөмрөгт судалгаа хийж ургамлын зүйлийн бүрдлийг тодорхойлж, биомассын хэмжилт хийх

Улаанбулаг төслийн талбайн хэмжээнд ургамал нөмрөгийн төлөв байдал, өөрчлөлтийг тодорхойлох, хянах зорилгоор төслийн талбайд 7 цэгт дулааны улиралд ургамлын хяналт мониторингийг хуваарийн дагуу 7 болон 8-р саруудад 2 удаа хийж гүйцэтгэсэн.

Төслийн талбай болон түүний орчимд 3 хэв шинжийн буюу У-IV-2-12, Үетэн- алаг өвст, Х-I-4-1, Жижиг улалж-үетэнт, Н-II-2-3, Үетэн-улалж-алаг өвст бүлгэмдэл тархсан байна. Бүлгэмдлийн зүйлийн бүрэлдэхүүний хувьд 13 овгийн, 23 төрөлд хамаарагдах 26 зүйл ургамал бүртгэгдсэн нь өмнө жилийнхтэй ижил буюу төслийн үйл ажиллагаанаас үүдэлтэй ургамал нөмрөг, түүний бүрэлдэхүүнд өөрчлөлт ороогүй байна. Дээрх бүртгэгдсэн ургамлууд нь амьдралын хэлбэрийн хувьд олон наст өвс зонхилох хувийг эзэлж алаг өвс болон нэг наст зүйлүүд бүлгэмдэл дэд зонхилогчоор оролцож байна. Мөн тайлант жилд Төвийн бүсийн нутгаар хур тунадас бага орж, гангийн үзэгдэл давамгайлсан нь 7-р сарын байдлаар ургамлын зүйлийн бүрдлүүдийн өсөлтийн эрчийг бууруулсан. Үүний улмаас ургамлын хлорофилын ногоорох хувирал сул илэрсэн. 8-р сараас эхлэн хур тунадас нэмэгдсэнээр уурхайн талбайн ургамлын зүйлийн бүрдлүүд

сэргэж эхэлсэн ч олон наст өвс ургамлын өндөр өмнөх жилүүдийн дунджаас доогуур буюу давжаа хэв шинжтэй байдал хэмжилт мониторингийн явцад ажиглагдсан.



Зураг 108. Ургамлын бичиглэлийн цэгүүд

Хүснэгт 24. Ургамал зүйн бичиглэл

№	УРГАМАЛШИЛ ЗҮЙН БИЧИГЛЭЛИЙН ДУГААР: #04	
1	Огноо:	2025-07-15
2	Байршил:	Шимт хөрсний овоолго орчим
3	Газрын нэр:	Улаанбулаг уурхайн талбай
4	Координат:	48°39'40.97" N, 106°18'32.26" E
5	Өндөршил:	1035метр
6	Газрын гадарга:	Жалга
7	Фото зураг: 	
8	Бичил гадарга:	Тэгш
9	Налуу:	2-3 градус
10	Хөрсний нэр:	Нугын хүрэн хөрс
11	Механик бүрэлдэхүүн:	Шаварлаг
12	Чийгийн хангамж:	Сайн
13	Хөрсний эвдрэл:	Байхгүй
14	Эвдрэлийн хэлбэр:	Байхгүй
15	Ургамлын бүлгэмдэл:	Олон наст үетэн, алаг өвс
16	Чулууны бүрхэц /%/:	0
17	Халцгай газрын хэмжээ /%/:	0
18	Хаг, хөвдний хэмжээ /%/:	5
19	Тусгаг бүрхэц /%/:	65
20	Талбайн хэмжээ:	1 м2
21	Ургамлын өнгө:	Шар ногоон
22	Ашиглалт:	Нөлөөлөлд өртөөгүй талбай
23	Зүйлийн тоо:	5
24	Тоологдсон ургамал	Адамын шарилж, царгас, хялгана, улалж, хиэг
25	Ургамлын өндөр /5 ургамлын дундаж/	25-36см

№	УРГАМАЛШИЛ ЗҮЙН БИЧИГЛЭЛИЙН ДУГААР: #05	
1	Огноо:	2025-07-15
2	Байршил:	Шимт хөрсний овоолго орчим
3	Газрын нэр:	Улаанбулаг уурхайн талбай
4	Координат:	48°39'41.9" N, 106°19'10.4" E
5	Өндөршил:	972 метр
6	Газрын гадарга:	Уулын бэл
7	<p>Фото зураг:</p> 	
8	Бичил гадарга:	Тэгш
9	Налуу:	1-2 градус
10	Хөрсний нэр:	Хар хүрэн хөрс
11	Механик бүрэлдэхүүн:	Шаварлаг
12	Чийгийн хангамж:	Сайн
13	Хөрсний эвдрэл:	Байхгүй
14	Эвдрэлийн хэлбэр:	Байхгүй
15	Ургамлын бүлгэмдэл:	Олон наст алаг өвс, үетэн
16	Чулууны бүрхэц /%/:	1
17	Халцгай газрын хэмжээ /%/:	5
18	Хаг, хөвдний хэмжээ /%/:	2
19	Тусгаг бүрхэц /%/:	75
20	Талбайн хэмжээ:	1 м ²
21	Ургамлын өнгө:	Шар ногоон
22	Ашиглаалт:	Нөлөөлөлд өртөөгүй талбай
23	Зүйлийн тоо:	7
24	Тоологдсон ургамал	Улаалж, хялгана, сэдэргэнэ, имт гичгэнэ, алаг өвс, саман ерхөг, өмхий буржгар
25	Ургамлын өндөр /5 ургамлын дундаж/	15-27 см

№		УРГАМАЛШИЛ ЗҮЙН БИЧИГЛЭЛИЙН ДУГААР: #01	
1	Огноо:	2025-07-03	
2	Байршил:	Пост 71	
3	Газрын нэр:	Улаанбулаг уурхайн талбай	
4	Координат:	48°40'58.06" N, 106°19'18" E	
5	Өндөршил:	934 метр	
6	Газрын гадарга:	Уулын зүүн хаяа	
7	Фото зураг:		
8	Бичил гадарга:	Налуу	
9	Налуу:	3-4 градус	
10	Хөрсний нэр:	Уулын хар хүрэн хөрс	
11	Механик бүрэлдэхүүн:	Шавранцар	
12	Чийгийн хангамж:	Сайн	
13	Хөрсний эвдрэл:	Байхгүй	
14	Эвдрэлийн хэлбэр:	Байхгүй	
15	Ургамлын бүлгэмдэл:	Олон наст үетэн, алаг өвс	
16	Чулууны бүрхэц /%/:	0	
17	Халцгай газрын хэмжээ /%/:	80	
18	Хаг, хөвдний хэмжээ /%/:	0	
19	Тусгаг бүрхэц /%/:	20	
20	Талбайн хэмжээ:	1 м ²	
21	Ургамлын өнгө:	Шар	
22	Ашиглалт:	Нөлөөлөлд өртөөгүй талбай	
23	Зүйлийн тоо:	3	
24	Тоологдсон ургамал	Ээрэм шарилж, хазаар өвс, цагаан дууль, нангиад цагаан суль (хиаг),	
25	Ургамлын өндөр /5 ургамлын дундаж/	2-7 см	

№	УРГАМАЛШИЛ ЗҮЙН БИЧИГЛЭЛИЙН ДУГААР: #02	
1	Огноо:	2025-08-13
2	Байршил:	Пост 74
3	Газрын нэр:	Улаанбулаг уурхайн талбай
4	Координат:	48°40'51.4" N, 106°18'56.1" E
5	Өндөршил:	1014 метр
6	Газрын гадарга:	Уулын баруун хойд энгэр
7	Фото зураг: 	
8	Бичил гадарга:	Налуу
9	Налуу:	4-5 градус
10	Хөрсний нэр:	Уулын хар хүрэн хөрс
11	Механик бүрэлдэхүүн:	Шавранцар
12	Чийгийн хангамж:	Сайн
13	Хөрсний эвдрэл:	Байхгүй
14	Эвдрэлийн хэлбэр:	Байхгүй
15	Ургамлын бүлгэмдэл:	Олон наст үетэн, алаг өвс
16	Чулууны бүрхэц /%/:	1
17	Халцгай газрын хэмжээ /%/:	0
18	Хаг, хөвдний хэмжээ /%/:	2
19	Тусгаг бүрхэц /%/:	75
20	Талбайн хэмжээ:	1 м ²
21	Ургамлын өнгө:	Шар ногоон
22	Ашиглалт:	Нөлөөлөлд өртөөгүй талбай
23	Зүйлийн тоо:	6
24	Тоологдсон ургамал	Саман ерхөг, улаалж, хялгана, харгана, шар царгас, бушилз
25	Ургамлын өндөр /5 ургамлын дундаж/	15-37 см
26	Амьтны нөлөөлөл:	Байхгүй

10.8. Амьтны аймгийн судалгаа

Төслийн талбай нь амьтны газар зүйн мужлалаар Монгол дагуур, Хэнтийн тойргуудын шилжилтийн заагт байрлаж байгаараа онцлог юм. Амьдрах орчны хувьд голын нуга, уулын хээр, ойт хээр, ойн гэсэн ялгаатай хэв шинжүүд ажиглагдана. Төслийн талбайн амьтны аймгийн зүйлийн бүрдлийг хээрийн судалгааны материал, холбогдох ном, сурвалж, зэргэлдээх уурхайн байгаль орчны судалгаа, мониторингийн тайланд

тулгуурлан боловсруулсан байна. Тухайн бүс нутагт 19 зүйлийн хөхтөн, 65 зүйлийн шувуу, 5 зүйлийн хоёр нутагтан, мөлхөгчид, 116 зүйлийн сээр нуруугүй амьтан тохиолдох боломжтой байдаг.

Амьтны аймгийн төлөв байдал судалгааны товч үр дүнгээс

2023 оны 5 сард “Баялаг эко” мэргэжлийн компаниар хийлгэсэн судалгааны үр дүнгээс үзэхэд тухайн бүс нутагт болон уурхайн талбайд 19 зүйлийн хөхтөн, 65 зүйлийн шувуу, 5 зүйлийн хоёр нутагтан, мөлхөгчид, 116 (нарийвчилсан судалгаа хийх шаардлагатай) зүйлийн сээр нуруугүй амьтан тохиолдох боломжтой байна. Хөхтөн амьтдаас урт сүүлт зурам, бор туулай зэрэг мэрэгч амьтад тоо толгой элбэг тааралддаг. Харин шувуудын зүйлийн баялаг нэлээд өндөр 10.7% суурин, 41.5% нь нүүдлийн үедээ дайрч өнгөрдөг, 7.6% нь өвөлждөг, 7.6% нь зусдаг бол 32.3% нь зусаж, үрждэг байна. Эдгээрийн дотор бүс нутгийн хэмжээнд ховордсон, хамгаалах шаардлагатай зүйлүүд байхгүй ч Олон улсад ховордож байгаа нөмрөг тас тохиолдоно. Мөн CITES-ийн II хавсралтад бүртгэгдсэн цөөн зүйлийн махчин шувууд байна. Мөлхөгч болон хоёр нутагт амьтдаас манай оронд хамгийн түгээмэл тархалттай зүйлүүд тоо толгойн хувьд элбэг таарна.

Амьтны бүртгэл, мэдээллийн системийг сайжруулах зорилгоор Улаанбулаг уурхайн хамгаалалтын пост болон хэлтэс, нэгж бүрт компанийн бүртгэл мэдээллийн хуудсыг байрлуулсан. Энэ нь уурхайн талбайд амьдардаг, идэвхэждэг эсвэл тухайн бүсэд нүүдэллэн орж ирсэн амьтдыг бүртгэж, тэдний хөдөлгөөн, байршил, идэвхжилийг тогтмол хянах боломжийг олгодог. Уурхайн ажилчид өдөр тутам талбайд ажиллаж байхдаа таарсан ан амьтдыг энэ бүртгэл дээр тэмдэглэж, БО-ны хэлтэст мэдээллийг цаасаар эсвэл имэйлээр илгээдэг.

БО-ны хэлтэс нь ан амьтны хөдөлгөөнийг хянахын тулд долоо хоног бүр уурхайн талбайд хөдөлгөөн мэдрэгч камер байрлуулдаг. Камерт өртсөн ан амьтдын зураг мэдээллийг мэдээллийн санд хадгалж, тус амьтны төрөл зүйл, тоо хэмжээ, идэвхжил зэргийг судалж, хяналт шинжилгээний үр дүнг баяжуулан ажилладаг. Бүртгэл мэдээллийн хуудсын формыг **Хавсралт 14**-д харуулсан.

Энэхүү судалгаа, бүртгэл нь уурхайн талбай дахь биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөөллийг бууруулах, хамгаалах арга хэмжээг цаг алдалгүй авах, болон амьтны тархац, нөхцөл байдлыг үнэн зөв тодорхойлоход дэмжлэг үзүүлж байна.

11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

Бороогоулд ХХК нь анх 2005 онд Байгаль орчны менежментийн тогтолцооны (ISO 14001:2004) болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн (ISO 18001:2007) менежментийн тогтолцооны олон улсын стандартуудыг компанийн дотоод үйл ажиллагаандаа нэвтрүүлж, Монгол Улсын холбогдох хууль, эрхзүйн орчинтой уялдуулан хэрэгжүүлж ирсэн ба хүн, байгаль орчинд сөрөг нөлөөгүй, ээлтэй байдлаар уурхайн болон компанийн үйл ажиллагааг явуулах үүднээс тогтмол сайжруулахыг зорин ажиллаж ирсэн.

2019 онд Байгаль орчны менежментийн тогтолцооны ISO 14001:2015, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцооны ISO 45001:2018

стандартуудын шинэчлэгдсэн шаардлагуудад нийцүүлэн үйл ажиллагаандаа шинэчлэл, сайжруулалт хийж, шинээр Эрчим хүчний менежментийн тогтолцооны ISO 50001:2018 стандартыг нэвтрүүлсэн. Ийнхүү стандартуудын баталгаажилтыг ханган Австралийн “Business Systems Certification Pty, Ltd” хэмээх баталгаажилтын байгууллагаас ISO14001, ISO45001, ISO 50001 стандартуудын гэрчилгээг хүлээн авсан. (**Хавсралт 29** - ISO стандартын гэрчилгээ).

Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын хүрээнд 2025 онд нэмэлт дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Байгаль орчны талаар баримтлах бодлогыг хянан шинэчилж, Гүйцэтгэх захирлын 2025 оны 8-р сард А/51 тоот тушаалаар батлуулан мөрдөж ажилласан /**Хавсралт 30** БГК-ийн 2025 оны Байгаль орчны талаар баримтлах бодлого/.
- Эрчим хүч, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд, Байгаль орчны нэгдсэн менежментийн тогтолцооны “Хамрах хүрээний баримт бичиг”-үүд болон тогтолцооны түвшний 18 журамд ээлжит хяналт хийн шинэчилж гүйцэтгэх захирлын 2025 оны 04 сарын 11-ны өдрийн А/48-Б тоот тушаалаар батлуулан нийт удирдах болон ахлах ажилтнуудад танилцуулж ажилласан.
- 2025 онд байгаль орчны менежментийн тогтолцооны ISO 14001 стандартын хэрэгжилтийг үнэлэх дотоод аудитыг 2025 оны 06 дугаар сард хуваарийн дагуу зохион байгуулсан.
- Шинэчлэгдэн батлагдсан “Байгаль орчны талаар баримтлах бодлого”, БОУАӨЯ-аар батлуулсан БОМТ болон бусад холбогдох төлөвлөгөөнд нийцүүлэн “2025 оны зорилго, зорилтыг” тодорхойлж, мөн дээрх тушаалын хоёрдугаар хавсралтаар батлуулсан ба хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2025 онд бид байгаль орчны зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ хэрэгжүүлэх, хог хаягдлын менежментийг тасралтгүй сайжруулах, нийгмийн хариуцлагын хүрээнд 3 сая мод тарих төлөвлөгөөг хэрэгжүүлэх, орон нутаг, төр захиргааны байгууллагатай хамтран ажиллах 5 зорилго дэвшүүлж, тус бүрийг хэрэгжүүлэх нийт 21 зорилт тавин ажилласан ба 2025 оны 10 дугаар сарын байдлаар 92% гүйцэтгэсэн байна. Батлагдсан зорилго зорилтыг **Хавсралт 31** -д үзүүлэв.
- Байгаль орчны менежментийн тогтолцооны ISO14001:2015 стандартын хэрэгжилтийг хангахад чиглэсэн болон байгаль орчны үйл ажиллагаанд шаардагдах 1 бодлогын баримт бичиг, 1 хамрах хүрээний баримт бичиг, 1 зорилго зорилт, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний баримт бичиг, тогтолцооны 18 журам, үйл ажиллагааны 20 стандарт журам, 12 ажлын заавар, болон 8 аюулгүй ажиллах заавар буюу нийт 61 ширхэг баримт бичигт ээлжит хяналт хийж, гүйцэтгэх захирлын тушаалаар батлуулсан байна. Батлагдсан эдгээр 61 баримтыг холбогдох ажлын байрууд болон дотоод сүлжээнд байршуулах, хамаарах ажилтнуудад танилцуулах үйл ажиллагааг төлөвлөгөөний дагуу бүрэн хэрэгжүүлж ажилласан болно. **Хүснэгт 25**-д нийт баримт бичгийн жагсаалтыг үзүүлэв. Баримт бичиг баталсан тухай Гүйцэтгэх Захирлын тушаалыг **Хавсралт 32**-д үзүүлэв.
- Байгаль орчны менежментийн тогтолцооны ISO14001:2015 стандарт, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн менежментийн

тогтолцооны ISO45001:2018, стандарт, Эрчим хүчний менежментийн тогтолцооны ISO50001:2018 стандартын хэрэгжилтийн ханган баталгаажилтын гэрчилгээг 2019 онд анхлан, 2022 онд давтан, 2025 онд давтан тус тус баталгаажуулсан. 2025 давтан баталгаажилтыг хангаж ISO стандартуудыг гэрчилгээг сунгуулах хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Менежментийн тогтолцоо хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилго, зорилтыг тодорхойлон, хэрэгжүүлэх, менежментийн тогтолцооны баримт бичгийн эргэн хяналт хийх, "Evacuation drill, Mock drill" буюу Нүүлгэн шилжүүлэх сургуулилт зохион байгуулах, осол, зөрчлийн статистик гарган ажилтнуудад танилцуулах, дотоод аудит, удирдлагын дүн шинжилгээний хурал зохион байгуулах, дотоо аудитын мөрөөр хариу арга хэмжээ авах, хөндлөнгийн аудитаар ISO стандартын гэрчилгээг давтан баталгаажуулах, түүний мөрөөр арга хэмжээ авах, дотоод аудиторын сургалт авах, сэргээх сургалт зохион байгуулах зэрэг 13 ажил бүхий төлөвлөгөө боловсруулж (Зураг), Гүйцэтгэх захирлын 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А-16 тоот тушаалаар батлуулсан. Төлөвлөгөөг холбогдон нэгжүүдэд танилцуулж 2025 оны 10 дугаар сарын 30-ны байдлаар хэрэгжилтийг 93% ханган ажилласан.
- Баталгаажилтын эрх бүхий “Эф Эм Си” компанийн аудитор Г.Ангар Бороогоулд компанийн ISO стандартын хэрэгжилтийн үнэлэх хөндлөнгийн аудитыг 2025 оны 07 дугаар сарын 23-24-ний өдрүүдэд хийж Зураг тайланг 2025 оны 08 дугаар сарын 06-нд бидэнд ирүүлсэн. Хөндлөнгийн аудитын үнэлгээгээр дээрх 3 стандартын хэрэгжилт 100% хангагдсан үнэлгээ авч, 2025.09.01 – 2028.08.31-ний хугацаанд хүчин төгөлдөр байх гэрчилгээг **Зураг** олгосон.
- Шинээр ажилд орж байгаа ажилтнуудыг ХНМӨСҮТөвд урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж тухайн ажлын байранд тэнцэх эсэх дүгнэлтийг үндэслэн уурхайн эмнэлэгт хяналтын үзлэг хийж эрүүл мэндийн карт, үзлэгийн хуудсыг мэдээллийн сан үүсгэн хадгалдаг. Бороогоулд компани ажилчдын эрүүл мэндийн байдалд ерөнхий үнэлгээ дүгнэлт өгөх, аливаа өвчин үүсэхэд нөлөөлөх эрсдэлд хүчин зүйлс байгаа эсэхийг тодорхойлох, өвчнийг эрт үед оношлох, эмчлэх, бусад нэмэлт шинжилгээ болон нарийн мэргэжлийн эмчийн үзлэг шаардлагатай эсэх, цаашид анхаарвал зохих болон хяналтанд байх шаардлагатай эсэхийг тоймлон гаргаж ажилчдад заавар зөвлөгөө өгөх үүднээс 2025 оны 07- дугаар сард Улсын хоёр дугаар төв эмнэлэгтэй хамтран эрүүл мэндийн үзлэгийг багцын сонголттойгоор зохион байгуулж нийт ажилчдыг хамруулсан.
- Гүйцэтгэх захирлын 2025 оны 05-р сарын 03-ны өдөр А/56 тушаалаар Ажлын хувцас, хувийн хамгаалах хэрэгслийн журмыг шинэчлэн баталж мөрдөн ажиллаж байна. Энэхүү журмаар аюултай хүчин зүйлийн нөлөөллийг бууруулах, хөдөлмөрийн үйл ажиллагааны явцад хүний бие махбодод нөлөөлөх орчны нөлөөллийг тохиромжтой болгож, хөдөлмөрийн хэвийн нөхцөлөөр хангах, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах зориулалт бүхий ажлын дүрэмт хувцас, бүх төрлийн хамгаалах хэрэгслийн ашиглалт, хадгалалт болон нормыг тогтоож зохих ажил мэргэжлийн онцлогоос хамааруулан олгож ажилласан.

- Байгаль хамгаалахад орон нутгийн иргэдийн оролцоог идэвхжүүлэх, сургалт, уулзалт зөвлөгөөн зохион байгуулах, тэдний санал зөвлөмжийг БОМТ-г хэрэгжүүлэх ажилд тусгах талаар тайлангийн 12-р бүлэгт дэлгэрэнгүй тусгав.

Хүснэгт 25. Тогтолцооны түвшний журам, зааврууд

Менежментийн тогтолцооны баримт бичгүүд	
0	Байгаль орчны талаар баримтлах бодлого
00	Байгаль орчны менежментийн тогтолцооны хамрах хүрээний баримт бичиг
000	Байгаль орчны 2025 оны зорилго зорилт
Байгаль орчны нэгдсэн менежментийн тогтолцооны түвшний журмууд	
1.1	Өөрчлөлтийн менежментийн журам
1.2	Удирдлагын дүн шинжилгээний журам
1.3	Байгаль орчны асуудлыг тодорхойлох ба үнэлэх журам
1.4	Байгаль орчны зөрчлийг судлан шалгах журам
1.5	Зорилт ба төлөвлөлтийн журам
1.6	Үл тохирол ба залруулах арга хэмжээний журам
1.7	Байгаль орчны мониторинг, хэмжилт хийх журам
1.8	Аюулыг тодорхойлох, эрсдэлийг үнэлэх ба хянах журам
1.9	Онцгой байдлын бэлэн байдал ба хариу арга хэмжээний журам
1.10	Гүйцэтгэлийн мониторинг ба хэмжилт хийх журам
1.11	Осол зөрчлийг судлан шалгах журам
1.12	Цианидын осол зөрчлийг судлан шалгах журам
1.13	Хууль тогтоомжийн шаардлага /нийцлийн үүрэг/-ыг тодорхойлох журам
1.14	Чадамж, мэдлэг ойлголт, сургалтын журам
1.15	Баримт бичгийн хяналт, бүртгэлийн журам
1.16	Менежментийн тогтолцооны дотоод аудитын журам
1.17	ЭХХАБЭМБО-ны менежментийн тогтолцооны эрх мэдэл ба үүрэг хариуцлагын журам
1.18	Дотоод болон гадаад мэдээлэл, харилцааны журам
Байгаль орчны хэлтсийн дараах үйл ажиллагааны стандарт журам	
2.1	Тоосны менежментийн журам
2.2	Цаг уурын мониторингийн журам
2.3	Асгаралтаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, цэвэрлэх, тайлагнах ажиллагааны журам
2.4	Цианидын бохирдолтой усны дээжлэлтийн журам
2.5	Цианидын бохирдолтой хөрсний дээжлэлтийн журам
2.6	Бохир ус цэвэршүүлэх системийн журам
2.7	Нуруулдан уусгалтын усны хэмжилт дээжлэлтийн журам
2.8	Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах журам
2.9	Ашиглалтаас гарсан батарей, бусад зай хураагууртай харьцах, устгах журам
2.10	Ашигласан тосны торхтой харьцах, хадгалах, устгах журам
2.11	Нөхөн сэргээлтийн журам
2.12	Үржил шимт хөрс хуулалт ба хадгалалтын журам
2.13	Өрөмдлөг тэсэлгээний ажлын үед тоосжилт үүсэхээс урьдчилан сэргийлэх журам
2.14	Хөрсний элэгдэл, эвдрэлийг хянах, засах журам
2.15	Мал, ан амьтныг хамгаалах журам
2.16	Хог ургамал устгах журам
2.17	Түүх соёлын үл хөдлөх болон хөдлөх дурсгалыг хамгаалах журам /БГ/
2.18	Түүх соёлын үл хөдлөх болон хөдлөх дурсгалыг хамгаалах журам /УБ/

2.19	Байгаль орчны хяналт шинжилгээний журам
2.20.	Ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн журам
Байгаль орчны хяналт шинжилгээний заавар	
3.1	Агаарын чанарын хэмжилт гүйцэтгэх заавар
3.2	Агаар дахь PM10 хэмжээтэй тоосны дээжлэгч ашиглах заавар
3.3	Усны дээжлэлт, бэхжүүлэлт, тээвэрлэлт гүйцэтгэх заавар
3.4	Гүний усны түвшин хэмжилт болон шүүрэлт хянах цооногийн хэмжилт гүйцэтгэх заавар
3.5	Олон үйлдэлт Hi 9828 (MPS) багаж ашиглах заавар
3.6	Гадаргын усны урсгалын хурд хэмжих заавар
3.7	Усны pH хэмжигч багаж ашиглах ба тохируулах заавар
3.8	Хөрсний дээжлэлт гүйцэтгэх заавар
3.9	Ан амьтны хөдөлгөөн хянах камер ашиглах заавар
3.10	Ургамлын бичиглэл гүйцэтгэх заавар
3.11	Хаягдал чулуулгийн дээжлэлт гүйцэтгэх заавар
3.12	Тоос хэмжигч багаж Dusttrack 8533 DRX ашиглах заавар
Байгаль орчны ажлын аюулгүй ажиллах заавар	
4.1	Биологийн нөхөн сэргээлт хийх ба үр түүх ажил
4.2	Мод тарих, услах, тайрах, танах, арчлах ажил
4.3	Хог хаягдлыг цэвэрлэх, цэгцлэх ажил
4.4	Кубота трактор M135A ашиглах
4.5	Кубота L44-SV трактор, роторт сийрүүлэгч, 4 корпуст анжис, тарьц суулгац таригч, шилжүүлэн суулгагч, ухагч агрегат ашиглах, ажиллуулах
4.6	Хайлаас тарих ажил
4.7	Олон наст зүлэг үрээр тарилт хийх ажил
4.8	Компост бордоо боловсруулах ажил

Улаанбулаг төслийн 2025 оны БОМТ-д тусгагдсан байгаль орчны удирдлага зохион байгуулалтын ажлуудын хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан ба мэдээллийг дараах хэсэгт орууллаа.

- **Байгаль орчны ерөнхий сургалт болон БОУТ-ны үйл ажиллагааны стандарт журмуудын сургалтыг төслийн талбайд ажиллах үндсэн болон гэрээт компанийн ажилчдад зохион байгуулах:**

Бороогоулд ХХК нь нийт ажилчдад байгаль орчныг хамгаалах асуудалд хариуцлагатай ханддаг соёлыг бий болгох, байгаль орчны дотоод журмуудын хэрэгжилтийг бүрэн хангах үүднээс төслийн талбайд ажиллаж буй үндсэн болон гэрээт ажилтнуудад байгаль орчны сургалт, мэдээллийг тогтмол өгч хэвшсэн. Энэхүү байгаль орчны сургалт нь Уурхайн товч танилцуулга, БОУТ-ын товч танилцуулга, Байгаль орчны бодлого, Байгаль орчны асуудлууд, Байгаль орчны зорилго, зорилтууд, Системийн түвшний журмууд болон тэдгээрийн үүрэг хариуцлага /SLPs/, Үйл ажиллагааны журмууд, тэдгээрийн үүрэг хариуцлага /SOPs/, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, Байгаль орчны нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа, Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ гэсэн агуулгын хүрээнд нийт ажилтнуудад мэдлэг олгох зорилгоор зохион байгуулагддаг. Сургалтыг төслийн талбайд ажиллахаар ирж буй үндсэн болон гэрээт ажилтнуудад ажил үүргээ эхлэхээс нь өмнө байгаль орчны хэлтсийн зүгээс ордог бөгөөд 15 минутын бататгах тест аван 70%-иас доош үнэлгээ авсан ажилчдыг дахин сургалтад хамруулдаг.

Байгаль орчны сэргээх сургалтыг жил бүр компанийн нийт ажилтнуудын дунд зохион байгуулдаг бөгөөд тайлант жилд Байгаль орчны хэлтэс болон Хүний нөөцийн хэлтэс хамтран 5-р сарын 02-ноос 26-ыг хүртэл нийт 11 удаагийн сургалтаар 566 ажилтанд давхардсан тоогоор /бататгах үнэлгээнд 70%-иас доош авсан ажилтнуудыг дахин хамруулсан/ байгаль орчны сэргээх сургалтыг зохион байгуулсан байна.

Уг сэргээх сургалтыг байгаль орчны үндсэн сургалтын агуулгын дагуу бөгөөд бүтээлчээр зохион байгуулсан ба хамрагдаж буй ажилтнуудыг 6 багт хуваан баг бүрт байгаль орчны холбогдолтой кейс судалгаа хийх даалгавар өгч ажиллуулсан. Хамгийн оновчтой хариултыг өгч буй багуудыг гарын бэлгээр шагнаж урамшуулсан бөгөөд баг бүр бүтээлчээр оролцсон.



Зураг 109. Сэргээх сургалтын үеийн зураг



Зураг 110. Сэргээх сургалтын кейс даалгавар

Байгаль орчны сургалт

Дээр дурдсаны дагуу Улаанбулаг төслийн талбайд ажиллахаар ажилд орсон ажилчид бүгд байгаль орчны сургалтад хамрагдсан бөгөөд шаардлагатай тохиолдолд Бороогийн уурхайд ажиллаж буй ажилтнуудаас тухайн төсөл дээр ажиллуулахаар төлөвлөж байна. Бороогоулд ХХК-ийн үндсэн болон гэрээт нийт 639 ажилтанд, мөн үйл ажиллагааны стандарт журмуудын сэргээн сануулах сургалтыг 566 ажилтанд, нийт 126 цагийн сургалт зохион байгууллаа. **Хавсралт 33** -аас Байгаль орчны сургалтын бүртгэлийг харна уу.

Хүснэгт 26. Байгаль орчны сургалтад хамрагдсан ажилчдын мэдээлэл

Д/д	Байгаль орчны сургалтууд	Сургалтад хамрагдсан хүний тоо
1	Аюулгүй ажиллагааны хурал болон хэлтсүүдийн наръяд зааварчилгаанд Байгаль орчны журмын танилцуулга	185
2	“Байгаль орчны сэргээх сургалт”-ыг уурхайн талбайд ажиллаж байгаа гэрээт болон үндсэн ажилчдад	566
3	“Байгаль орчны ерөнхий сургалт”-ыг Бороогоулд ХХК-д шинээр ажилд орж байгаа үндсэн ажилтан эсхүл уурхайн талбайд ажиллах гэрээт ажилтнуудад	639
4	“Химийн бодисын сургалт”-ыг уурхайн талбайд химийн бодис урвалжтай харьцдаг ажилтнуудад	86
Нийт		1390

11.1. Хөндлөнгийн хяналт шинжилгээ хийлгэх

2025 онд агаар, ус, хөрсний чанарын хөндлөнгийн хяналт шинжилгээг төлөвлөгөөний дагуу 2 удаа буюу 6 болон 9 дүгээр сард Төв аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн мэргэжилтнүүд уурхайн талбайд ирж хийж гүйцэтгэсэн.

Улаанбулагийн уурхайн талбайд 2 удаагийн давтамжтай агаарын 3 цэг, усны 5-6 цэг, хөрсний 2 цэгүүдэд хээрийн хэмжилт, лабораторийн шинжилгээ хийж Ундны усны шинжилгээний дүнг MNS 0900:2005, Гадаргын усыг MNS 4586:2024 стандарт, Агаарын чанарын MNS 4585:2025 стандарт, Хөрсний MNS 3310:91 стандарттай харьцуулан дүгнэхэд эдгээр стандартын шаардлагыг бүрэн хангаж байгаа болохыг тодорхойлон дүгнэлт гаргасан болно. Хөндлөнгийн хяналт шинжилгээний 5,9 дүгээр сарын үр дүнг **Хавсралт 34** -өөс харна уу.



Зураг 111. Хөндлөнгийн хяналтын дээжлэлт, чанарын хэмжилт

11.2. Уурхайн ажилтнуудыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангах

Гүйцэтгэх захирлын 2025 оны 05-р сарын 03-ны өдрийн А/32 тоот тушаалаар Ажлын хувцас, хувийн хамгаалах хэрэгслийн журмыг шинэчлэн баталж мөрдөн ажиллаж байна /Хавсралт 35/. Энэхүү журмаар аюултай хүчин зүйлийн нөлөөллийг бууруулах, хөдөлмөрийн үйл ажиллагааны явцад хүний бие махбодод нөлөөлөх орчны нөлөөллийг тохиромжтой болгож, хөдөлмөрийн хэвийн нөхцөлөөр хангах, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах зориулалт бүхий ажлын дүрэмт хувцас, бүх төрлийн хамгаалах хэрэгслийн ашиглалт, хадгалалт болон нормыг тогтоож зохих ажил мэргэжлийн онцлогоос хамааруулан олгож ажилласан.

Уг журмын дагуу хэлтсийн удирдлага нь шинээр ирж ажиллаж буй үндсэн, гэрээт гүйцэтгэгчид, улирлын түр гэрээт ажилтанд тохирох дүрэмт хувцас, хувийн хамгаалах хэрэгслийг тэдгээрийн гүйцэтгэх ажлын аюул эрсдэл хамгийн бага түвшинд байлгах нэмэлт тусгай хамгаалалтын хэрэгслүүдийг бүрдүүлэхэд, цаг тухай бүрд нь баталсан нормын дагуу элэгдсэн хамгаалах хэрэгслийг солих ажлыг зохион байгуулах үүргийг хүлээж ажилладаг.

11.3. Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамруулах

Бороогоулд компанийн ажилчдын эрүүл мэндийн байдалд ерөнхий үнэлгээ дүгнэлт өгөх, аливаа өвчин үүсэхэд нөлөөлөх эрсдэлд хүчин зүйлс байгаа эсэхийг тодорхойлох, өвчнийг эрт үед оношлох, эмчлэх, бусад нэмэлт шинжилгээ болон нарийн мэргэжлийн эмчийн үзлэг шаардлагатай эсэх, цаашид анхаарвал зохих болон хяналтанд байх шаардлагатай эсэхийг тоймлон гаргаж ажилтнуудад заавар зөвлөгөө өгөх үүднээс 2025 оны 06-р сарын 18-аас 07 сарын 28 хооронд Улсын 2 дугаар төв эмнэлэг хамтарч багцын сонголттойгоор зохион байгуулж нийт 485 ажилтныг хамруулсан. Үүнээс 255 ажилтанд мэргэжлийн эмчийн зөвлөгөөг хүргэж ажилласан байна.

11.4. Байгаль орчны Аудитыг мэргэжлийн байгууллагаар хийлгэх:

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10¹.1.-д “Байгаль орчны аудитыг байгалийн нөөц, баялгийг ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллага нь хоёр жил тутам хийлгэж, холбогдох дүгнэлт, зөвлөмж гаргуулан

хэрэгжүүлэх бөгөөд зөвлөмжид заасан хугацаанд тайлангаа аймаг, нийслэлийн байгаль орчны албанд хүргүүлнэ” гэж заасны дагуу Бороогоулд компани нь Улаанбулагийн алтны үндсэн орд ашиглах төсөл”-ийн үйл ажиллагаанд байгаль орчны аудитыг “Тод Марк” ХХК мэргэжлийн газраар хамтран ажиллах гэрээ байгуулан 2025 оны 10-р сард хийлгэсэн. Байгаль орчны аудитаар Улаанбулаг төслийн хууль эрхзүйн ерөнхий шаардлагын нийцэл; технологи ажиллагаа, агаарын чанар, хийн ялгаруулалт; газар ашиглалт; усны менежмент, нөөц чанар, ашиглалт; биологийн төрөл зүйлийн менежмент; орон нутгийн иргэдэд тайлагнах гэсэн 7 чиглэлээр үнэлсэн. Аудитын баг байгаль орчны аудитын нээлтийн хурлыг зохион байгуулж, аудитын зорилго, хүрээ, хуваарийг талуудтай танилцуулан эхлүүлсэн. Мөн баг нь төслийн бичиг баримтын бүрдэлтэй нарийвчлан танилцаж, байгаль орчны менежментийн бодлого, тайлан, бүртгэл, хяналтын материалуудыг шалгаж, шаардлагатай мэдээллийг цуглуулсан. Үүний зэрэгцээ, доктор Ж.Сэржмаагаар ахлуулсан аудитын баг төсөл хэрэгжиж буй талбайд ажиллаж, газар дээр нь ажлын явц, үр дүнг бүртгэн, аудитын баримт бичигт суурилсан мэдээллийг цуглуулан ажилласан. Энэхүү тайлан нь төслийн байгаль орчны менежментийн үйл ажиллагааг үнэлэх, сайжруулах боломжийг тодорхойлох зорилготой. **Хавсралт 36** -аас байгаль орчны аудитын мэргэжлийн байгууллагатай хийсэн гэрээг харна уу.



Зураг 112. Байгаль орчны аудитын нээлтийн хурлын зураг

12. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт

12.1. Төв аймгийн Борнуур, Сэлэнгэ аймгийн Мандал сумын иргэдийн төлөөлөлд Төслийн үйл ажиллагаа, тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийг танилцуулах

Бороогоулд ХХК нь уурхайн үйл ажиллагаагаа эхэлснээс өдгөөг хүртэл олон нийт тэр дундаа орон нутгийн иргэдэд компанийн үйл ажиллагааг нээлттэй байлгах, мэдээллээр хангах, мэдээлэл солилцох, иргэдийн санал, хүсэлтийг үйл ажиллагаандаа тусган ажиллах бодлого баримталсаар ирсэн ба жил бүр орон нутгийн иргэд болон бусад зочид төлөөлөгчдийг уурхайн талбайд хүлээн авч, уурхайн үйл ажиллагаа, нөхөн сэргээлтийн хөтөлбөр, тэдгээрийн үр дүнг газар дээр нь танилцуулж ирсэн.



Зураг 113. Борнуур сумын иргэдэд БОМТ-ний биелэлтийн явцыг танилцуулав

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) - ний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний дагуу Төв аймгийн Борнуур сумын иргэдийн төлөөллийг 2025 оны 08 дүгээр сарын 28-ны өдөр, Сэлэнгэ аймгийн Мандал сумын Хэрх багийн иргэдийг 2025 оны 10-р сарын 03-ны өдөр уурхайн талбайд хүлээн авах ажлыг Хэвлэл мэдээлэл, орон нутагтай харилцах хэлтэстэй хамтран зохион байгуулж, Байгаль орчны нөхөн сэргээлт, Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах хөтөлбөрийн хүрээнд хийгдэж буй ажлууд, “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, “Улаанбулаг мод үржүүлгийн газар”-ын мэдээ, тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийн танилцуулга мэдээллүүдийг өгч, иргэдийн сонирхсон асуултад хариулж ажилласан.

БОМТ, түүний биелэлтийн танилцуулга презентациар:

- Улаанбулагийн уурхайн үйл ажиллагааны товч танилцуулга
- Тухайн онд хэрэгжүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт
- Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт
- БОЯБ-ыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хэрэгжилт
- Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
- Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
- Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт
- Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт
- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт, дээжлэлт, шинжилгээ, хэмжилтийн үр дүн
- Тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

- Улаанбулаг мод үржүүлгийн газрын үйл ажиллагаа, технологи, усалгааны систем, тарьц, суулгац бүтээгдэхүүний чанар, үр дүнг мэдээлсэн болно.

Мөн иргэдийг уурхайн нөхөн сэргээлт болон ойжуулалтын талбай, Улаанбулагийн мод үржүүлгийн газартай биечлэн танилцууллаа. **Хавсралт 37** -оос мэдээлэлтэй танилцсан иргэдийн бүртгэл, гарын үсгийг харна уу.



Зураг 114. Нөхөн сэргээлтийн талбайтай танилцуулж буй үе

Орчны хяналт шинжилгээ (ОХШ)- ний хөтөлбөрийн хэрэгжилтийг танилцуулах болон хээрийн хэмжилт, дээжлэлтийн ажлыг нөлөөллийн бүсийн иргэдийн хамтын оролцоотой хийж үр дүнг танилцуулсан.



Зураг 115. Мод үржүүлгийн газрыг танилцуулах явцад

Иргэдийн зүгээс олон төрлийн ажлыг зохион байгуулж буйд ам сайтай байсан бөгөөд компост бордоо төслийг сонирхон, гэрийн нөхцөлд хэрхэн бордоо боловсруулах талаар сургалт авах тухай, мөн мод үржүүлгийн газраас тарьц суулгац худалдаж авч болох талаар асууж байсан.

➤ **“Нээлттэй Бороо” өдөрлөг зохион байгуулав**

Бороогоулд ХХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд орон нутагтай хамтын ажиллагааг улам өргөжүүлэх, иргэдэд компанийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг хүргэх, тэдний санал хүсэлтийг авах зорилгоор 2025 оны 5 дугаар сарын 26-нд Сэлэнгэ аймгийн Мандал сумын Мөнгөн хараа чуулгын байранд, 5 дугаар сарын 27-нд Баянгол сум, 6 дугаар сарын 01 нд Борнуур сумд “Нээлттэй бороо” өдөрлөг, арга хэмжээг зохион байгууллаа.

➤ **Борнуур сум 2025 оны 06 сарын 01**

